



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



# ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Судалгааны тайлан

Захиалагч: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн  
ажлын алба

Гүйцэтгэгч: “Эс Ай Си Эй” ХХК



## **СУДАЛГААНЫ БАГ**

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг дараах багийн бүрэлдэхүүнтэй боловсрууллаа.

### *Судалгааны багийн ахлагч:*

П.Цэрэнбазар (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Зөвлөх, доктор)

### *Судалгааны зөвлөх:*

Г.Эрдэнэ (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Дэд захирал, докторант)

Т.Пүрэвхүү (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал, магистр)

Б.Сүндэръяа (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Зөвлөх, докторант)

### *Судлаачид:*

Э.Должин (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Нийгэм, эдийн засгийн судалгааны хэлтсийн захирал, докторант)

Б.Батсүрэн (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хэлтсийн захирал)

Т.Амаржаргал (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Нийгэм, эдийн засгийн судалгааны хэлтсийн менежер)

Б. Сувд-Эрдэнэ (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Гэрээт судлаач)

### *Тайлан хянасан*

А.Дэмбэрэл (“Эс Ай Си Эй” ХХК-ийн Зөвлөх, доктор, профессор)



## ТАЛАРХАЛ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны захиалгаар гүйцэтгэсэн “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэхэд санхүүжилт олгосон, судалгааны арга зүйг нарийвчлахад зөвлөгөө өгсөн, судалгаанд хамрагдаж бидэнд мэдээлэл өгсөн бүх байгууллага, албан хаагчдад талархал илэрхийлье.

Та бүхний хичээл зүтгэлээр энэхүү судалгааны ажлын үндсэн мэдээллийг цуглуулж, тайлан бичих боломж бүрдлээ.

Энэхүү судалгааны тайлан нь үндсэн 4 бүлэгтэй бөгөөд эхний бүлэгт судалгааны арга зүй, зохион байгуулалтын талаар, хоёрдугаар бүлэгт хүн худалдаалах гэмт хэрэг, түүний өнөөгийн нөхцөл байдлын талаар, гуравдугаар бүлэгт хөтөлбөрийн үйл ажиллагаа тус бүрийн хэрэгжилтийн үнэлгээг, дөрөвдүгээр бүлэгт үр нөлөөний талаар оруулсан. Харин төгсгөлд дүгнэлт, санал, зөвлөмж болон хавсралт материалыг оруулсан болно.

Судалгааны үр дүнтэй холбогдох санал хүсэлт, анхаарах асуудлаар бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна. Та бүхний санал бидний дараа, дараагийн ажлуудад томоохон дэмжлэг болно.

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбогдох бүх эрхийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн Ажлын алба эзэмшинэ.

## АГУУЛГА

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>5</b>
<b>ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>6</b>
<b>ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ .....</b>	<b>8</b>
<b>ХУРААНГУЙ.....</b>	<b>9</b>
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....</b>	<b>12</b>
1.1 Үнэлгээний зорилго, зорилт.....	12
1.2 Хамрах хүрээ.....	12
1.3 Арга зүй .....	12
1.4 Судалгааны төрөл, мэдээлэл цуглуулах арга зүй.....	15
1.5 Судалгааны хяналтын үе шатууд.....	17
1.6 Үнэлгээ хийхэд учирсан хүндрэл, бэрхшээл.....	17
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ .....</b>	<b>20</b>
2.1 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох илрүүлсэн гэмт хэргийн мэдээлэл.....	20
2.2 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан Прокурорын байгууллагаас хянасан хэргийн мэдээлэл.....	23
2.3 Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх мэдээлэл .....	26
2.4 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ял эдэлж буй иргэдийн мэдээлэл .....	30
2.5 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох дуудлага, мэдээлэл .....	32
2.6 Дүгнэлт .....	33
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ ..</b>	<b>35</b>
3.1 Нэгдүгээр зорилтын үйл ажиллагаануудын үнэлгээ, үр дүн .....	37
3.2 Хоёрдугаар зорилтын үйл ажиллагаануудын үнэлгээ, үр дүн .....	58
3.3 Гуравдугаар зорилтын үйл ажиллагаануудын үнэлгээ, үр дүн .....	68
3.4 Дөрөвдүгээр зорилтын үйл ажиллагаануудын үнэлгээ, үр дүн .....	74
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ .....</b>	<b>80</b>
4.1 Үндэсний хөтөлбөрийн зорилтот бүлгүүд .....	80
4.2 Эдийн засагт үзүүлсэн нөлөө .....	81
4.3 Нийгэмд үзүүлсэн нөлөө .....	81
4.4 Бодлогын хэрэгжилтийн явцад бий болсон хууль, эрх зүйн шинэчлэл .....	90
4.5 Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын тогтолцоонд үзүүлсэн нөлөө.....	91
4.6 Үр нөлөөний үнэлгээний үр дүн .....	93
4.7 Салбарын тулгамдсан болон цаашид анхаарах асуудал .....	95
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>98</b>
<b>ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>100</b>
<b>ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 1 – ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО.....</b>	<b>102</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БНИУ	Бүгд Найрамдах Итали Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНХАУЗЗОБХ	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ГХУСАЗЗАА	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГССҮТ	Гэмтэл, согог судлалын үндэсний төв
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
МСҮТ	Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв
МУИС	Монголын үндэсний их сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
СБД	Сүхбаатар дүүрэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ХБМБ	Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХБХ	Хэрэг бүртгэлтийн хэрэг
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлал.....	13
Хүснэгт 2. Зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг шилжүүлэх ангилал.....	13
Хүснэгт 3. Бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээ хийх аргачлал .....	14
Хүснэгт 4. Судалгааны түүвэр .....	15
Хүснэгт 5. Судалгаанд хамрагдсан байгууллагууд .....	16
Хүснэгт 6. Зорилт тус бүрийн үйл ажиллагааны үр дүн, тоогоор .....	36
Хүснэгт 7. Нэгдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн үнэлгээ .....	37
Хүснэгт 8. Хоёрдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн үнэлгээ .....	58
Хүснэгт 9. Гуравдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн үнэлгээ .....	68
Хүснэгт 10. Цагдаагийн байгууллагын хүн худалдаалахтай тэмцэх чиг үүрэг бүхий хэлтсийн албан хаагчдын гадаад улсад сургалтад суусан, мэргэжил дээшлүүлсэн байдал.....	72
Хүснэгт 11. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн үнэлгээ.....	75
Хүснэгт 12. Үр нөлөөний үнэлгээ хийх хүрээ .....	80
Хүснэгт 13. Эдийн засгийн таамаглал.....	81
Хүснэгт 14. Үр нөлөөний үнэлгээний үр дүн .....	93

График 1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл заалтаар.....	21
График 2. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, холбогдогчийн тоо .....	21
График 3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын төрөл, хувиар, 2017-2021 он .....	22
График 4. Шинээр үүссэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг, 2017-2021 ..	23
График 5. Улаанбаатар хотод шинээр үүссэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг.....	23
График 6. Орон нутагт шинээр үүссэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг.....	24
График 7. Хэрэг бүртгэл явуулсан хэрэг .....	24
График 8. Мөрдөн байцаалт явуулсан хэрэг .....	25
<i>График 9. Шүүхэд хүлээн авсан хэрэг .....</i>	<i>25</i>
График 10. Шүүхийн ерөнхий зөвлөлд шийдвэрлэвэл зохих хэрэг болон хүний тоо .....	26
График 11. Нийт бүртгэгдсэн хэргийн шийдвэрлэсэн байдал, тайлангийн үлдэгдэл.....	26
График 12. 2018-2021 онд хэргийн шийдвэрлэгдсэн байдал .....	27
График 13. Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэсэн байдал .....	27
График 14. Шүүхээр дангаар болон бүрэлдэхүүнээс шийдвэрлэсэн хэргийн тоо .....	27
График 15. Өмгөөлөгч оролцсон шүүх хурлын тоо .....	28
График 16. Ял шийтгүүлсэн хүний тоо, хүйсээр .....	28
График 17. Хорих ял шийтгүүлсэн хүмүүс, насны ангиллаар .....	28
График 18. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн боловсролын түвшин .....	29
График 19. Давхар зүйл ангиар ял шийтгүүлсэн хүн.....	29
График 20. Хорих ялын хугацаа .....	29
График 21. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хорих ял эдэлж байсан хүмүүсийн тоо, хүйсээр.....	30
График 22. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хорих ял эдэлж байсан хүмүүсийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл ангиар.....	30
График 23. Бэлгийн мөлжлөгтэй холбоотой ял эдэлж байсан хүмүүсийн тоо, хүйсээр .....	31
График 24. Бэлгийн мөлжлөгтэй холбоотой ял эдэлж байсан хүмүүсийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл ангиар.....	32



График 25. Хүүхдийн тусламжийн 108 утсанд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ирсэн дуудлагын тоо.....	32
График 26. Хөтөлбөрийн ерөнхий үнэлгээ .....	35
График 27. Хөтөлбөрийн ерөнхий үнэлгээ, 2019 оны үнэлгээтэй харьцуулсан байдал.....	36
График 28. Хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сонссон, хувиар, амьдарч буй байршлаар.....	87
График 29. Хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар нэг мэдээлэл сонсож, уншиж байсан байдал, хүйсээр.....	88
График 30. Мэдээллийн эх үүсвэр, давхардсан тоогоор .....	88
График 31. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн талаар сонссон байдал, ач холбогдлоор.....	89
График 32. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар, судалгаанд оролцогчдын хариулт.....	89
Зураг 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд .....	12
Зураг 2. Судалгааны төрөл, мэдээлэл цуглуулах арга .....	15
Зураг 3. Судалгааны хяналтын үе шатууд.....	17

## ШИГТГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Шигтгээ 1. Хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэлт буурсан шалтгаан .....	22
Шигтгээ 2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эдийн засагт үзүүлсэн нөлөө.....	81
Шигтгээ 3. Төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдад үзүүлсэн нөлөө, хохирогч илрүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн тухай.....	82
Шигтгээ 4. Төрийн байгууллагын албан хаагчдад үзүүлсэн нөлөө, хохирогч төвтэй хандлага төлөвшиж байгаа тухай .....	82
Шигтгээ 5. Төрийн байгууллагын албан хаагчдад үзүүлсэн нөлөө, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах болсон тухай.....	83
Шигтгээ 6. Өмгөөлөгчдөд үзүүлсэн нөлөө .....	83
Шигтгээ 7. Сэтгүүлчдэд үзүүлсэн нөлөө .....	84
Шигтгээ 8. Хувийн байгууллагын ажилтан, албан хаагчдад үзүүлсэн нөлөө .....	85
Шигтгээ 9. Хохирогчид үзүүлсэн нөлөө, гэмт хэргийн хохирогч гэдгээ мэдэж авдаг тухай ..	85
Шигтгээ 10. Хохирогчид үзүүлсэн нөлөө, эрүүл мэндийн үйлчилгээ авсан тухай.....	86
Шигтгээ 11. Хохирогчид үзүүлсэн нөлөө, сэтгэл зүйн үйлчилгээ авсан тухай .....	86
Шигтгээ 12. Хохирогчийн гэр бүлд үзүүлсэн нөлөө .....	86
Шигтгээ 13. Олон нийтэд үзүүлсэн нөлөө, мэдээлэх үүргээ ухамсарласан тухай .....	87
Шигтгээ 14. Олон нийтэд үзүүлсэн нөлөө, уламжлалт хандлага өөрчлөгдөж байгаа тухай	87
Шигтгээ 15. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үзүүлсэн нөлөө, мэргэжил эзэмшиж болох тухай .....	90
Шигтгээ 16. Байгууллагын бүтцэд үзүүлсэн нөлөө .....	91
Шигтгээ 17. Байгууллага хоорондын хамтын ажиллагаанд үзүүлсэн нөлөө .....	92
Шигтгээ 18. Судалгаанд оролцогчдын сэтгэгдэл .....	95
Шигтгээ 19. Судалгаанд оролцогчдын сэтгэгдэл .....	96
Шигтгээ 20. Судалгаанд оролцогчдын сэтгэгдэл .....	96
Шигтгээ 21. Судалгаанд оролцогчдын сэтгэгдэл .....	97
Шигтгээ 22. Судалгаанд оролцогчдын сэтгэгдэл .....	97



## ХУРААНГУЙ

Хүн худалдаалах гэмт хэрэг нь техник технологийн дэвшил, цар тахал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан үйлдэгдэх хэлбэр, нөхцөл байдал нь хувьсан өөрчлөгдөж байгаа онц ноцтой гэмт хэргийн төрөл юм. Монгол Улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд тухайлан заасан бөгөөд 2017-2021 оны байдлаар цагдаагийн байгууллагад хүн худалдаалах гэмт хэрэг болон түүнтэй холбогдох 76 гэмт хэрэг бүртгэгдэж, улмаар прокурорын байгууллагаас 81 хэрэгт хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 31 хэрэгт шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байна.

Монгол Улсын Их Хурлаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан.


Тус хөтөлбөрийн зорилго нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн.<sup>1</sup>

Энэхүү үндсэн зорилгын хүрээнд 4 зорилт, 26 үйл ажиллагааг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр тусгажээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ **91.9** хувь байна. Хэрэгжүүлсэн 26 үйл ажиллагааны 13 нь үр дүнтэй, 11 нь тодорхой үр дүнтэй, 2 нь эрчимжүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд Эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны хувьд

- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудыг нэгдсэн мэдээллийн сүлжээгээр холбож, шаардлагатай техник хэрэгсэл, мэргэжилтнээр хангах,
- Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх төвийг байгуулах зэрэг үйл ажиллагаа байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа эрчимжиж, энэ төрлийн гэмт хэрэг хүрээгээ тэлж хохирогчийн тоо нэмэгдэхээс урьдчилан сэргийлж чадсан бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нэгдсэн нэг төлөвлөгөөтэй болж, түүнд холбогдох байгууллага бүрийг татан оруулж, улсын төсөв болон олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжиж байна. Иргэд энэ төрлийн гэмт хэргийн талаар тодорхой ойлголт мэдлэгтэй болж, хүний эрхийн зөрчлийг мэдээлэх үүргээ ухамсарладаг болсон нь эерэг үр дүнгүүдийн нэг болсныг онцолж тэмдэглэж байна. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд хүний нөөцийг нэмэгдүүлснээр гэмт хэргийн илрүүлэлт өссөн үр дүн гарчээ. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг ТББ-уудын үйл ажиллагаа сайн байгаа нь сайшаалтай үр дүн байлаа.

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 2.1 дэх заалт



Цаашид байгууллага хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагаа цахим системд оруулах, статистикийн тоон мэдээлэлд зөрүүтэй байдал үүсгэхгүй байхад анхаарах шаардлагатай.

Мөн ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн албан хаагчдын тоог нэмэх, тэдний ур чадварын өсөлт, тогтвортой байдалд анхаарах хэрэгтэй.

Гэмт хэргийн илрүүлэлт өссөнөөр хохирогчдыг хамгаалах, нийгэм сэтгэл зүй, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж хэвийн амьдралдаа эргэн ороход нь тусалцаа үзүүлэхэд анхаарах нөхцөл бүрдэх юм.

Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, хохирогчид тусалцаа үзүүлэх чиглэлээр ажиллаж буй ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал, онцлог нөхцөл байдлыг нарийвчлан судалж, тэдний ажлын онцлогт тохирсон уян хатан нөхцөл бүхий дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Цаашид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, зөвлөгөө мэдээлэл өгөх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, иргэний нийгмийн үйл ажиллагааг илүүтэй татан оруулахад анхаарч тэдний үйл ажиллагааны онцлогт тохирсон бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлагатай.



---

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.  
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү бүлэгт үнэлгээний ажлын зорилго, зорилт, хамрах хүрээ, мэдээлэл цуглуулалт болон боловсруулалтын арга зүй, үнэлгээ хийхэд учирсан хүндрэл, бэрхшээлийн талаар орууллаа.

### 1.1 Үнэлгээний зорилго, зорилт

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалаар хийж дүгнэлт, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах тодорхой зөвлөмж боловсруулах зорилготой юм.

Дараах зорилтыг төлөвлөн ажиллав. Үүнд:

- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан болон судалгааны үр дүнд үндэслэн 4 зорилт, 26 үйл ажиллагаа тус бүрийн хэрэгжилтийг үнэлэх
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын үр нөлөөг үнэлэх
- Судалгаанд оролцогчдын үндэсний хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлага дээр үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх зөвлөмж гаргах

### 1.2 Хамрах хүрээ

**Цаг хугацааны хувьд** 2022 оны 06 дугаар сарын 09 –ний өдрөөс 09 дүгээр сарын 13–ны өдрийг хүртэл зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэв.

**Баримт бичгийн хувьд** үндэсний хөтөлбөр болон түүний тайлан бусад холбогдох хууль, эрх зүй, бодлогын баримт бичиг, аргачлалыг ашиглалаа.

**Судалгаанд оролцогч талуудын хувьд** үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаануудад оролцсон, гүйцэтгэсэн байгууллагуудын төлөөлөл болон олон нийт/иргэдийг хамруулав.

### 1.3 Арга зүй


Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажилд **үндсэн 3 төрлийн судалгааны ерөнхий загварыг хослуулан** ашигласан.

#### **Загвар 1: Шалгуур үзүүлэлтүүд (OECD-DAC)**

Үнэлгээг хийхдээ ЭЗХАХБ-аас гаргасан шалгуур үзүүлэлтүүдийг ашиглав.

- **Үр дүнтэй байдал:** Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа зорилгодоо хүрч чадсан уу?
- **Үр нөлөөтэй байдал:** Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт ямар өөрчлөлтийг бий болгосон бэ?
- **Тогтвортой байдал:** Үндэсний хөтөлбөрийн үр нөлөө урт хугацаандаа байх уу?

Зураг 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд



**Загвар 2: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйл хяналт-шинжилгээ, үнэлгээ, төлөвлөлт, төрөл, арга зүй**

Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй байсан тул дараах аргачлалаар тооцлоо.

Хүснэгт 1. Баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлал

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	Ашигласан хувь
1	Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол	90	90-100
2	Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол	70	70-89
3	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол	50	50-69
4	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол	30	30-49
5	Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг бавч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол	0	0-29

Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дээрх аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцсон.

Хүснэгт 2. Зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг шилжүүлэх ангилал

№	Ангилал	Хувь
1	“Үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол	100
2	“Тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол	70-99
3	“Эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол	31-69
4	“Үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол	0-30

**Загвар 3: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын хавсралтын 7.8-д батлагдсан аргачлалыг үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 8 дугаар хавсралт**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д бодлогын үр нөлөөг дараах аргачлалын дагуу үнэлэхээр тусгасан бөгөөд энэхүү аргачлалыг ашиглаж үр нөлөөг үнэллээ.

**Хүснэгт 3. Бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээ хийх аргачлал**


<b>Эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тодорхойлсон үр нөлөө</b>	
<b>А. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөлөл</b>	
1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлсэн зорилтот бүлэг болон бусад бүлэг	Бодлогыг хэрэгжүүлснээр хууль ёсны эрх ашиг, санхүүгийн боломж, өнөөгийн нөхцөл байдалд нь шууд болон шууд бусаар нөлөөлсөн нийгмийн зорилтот бүлгийг тодорхойлно. Зорилтот бүлэг гэж бүлэг хувь хүмүүс, нийгмийн бүлэг, хуулийн этгээд (Засгийн газрын болон орон нутгийн удирдлагын байгууллага, түүний ажилчид) зэрэг тухайн бодлогыг хэрэгжүүлснээр эерэг болон сөрөг нөлөөнд өртсөн бүлгийг ойлгоно.
2. Эдийн засгийн хөгжил болон захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөө	1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын шалгуур үзүүлэлтэд үзүүлсэн нөлөөллийг тодорхойлох
	2. Захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийг тооцоолох:
	2.1. захиргааны үйл ажиллагааны нөлөө хэвээр үлдсэн бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зорилтот бүлгийн эрх ашиг, хариуцлагыг хөндөөгүй гэдгийг тодорхойлон бичих;
	2.2. захиргааны үйл ажиллагааны нөлөө буурч байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс үр шим хүртэж байгаа нийгмийн бүлэг, байгууллага, аж ахуй, салбарыг тодорхойлон бичих;
2.3. захиргааны үйл ажиллагааны нөлөө нэмэгдэж байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь нийгмийн ямар бүлэг, байгууллага, аж ахуй, салбарт нөлөө үзүүлж байгаа, ямар гол өөрчлөлтүүд бий болсныг тодорхойлон бичих	
3. Бусад мэдээлэл	Энэхүү үр нөлөөний үнэлгээний "А"-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй эдийн засгийн хөгжилд үзүүлсэн нөлөөллийн талаар энд бичиж болно.
<b>Б. Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөлөл</b>	
1. Хэрэв тухайн бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ нь нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн бол тухайн бүлэгт үзүүлсэн үр нөлөөг тодорхойлно. Үр нөлөөг тодорхойлохдоо тухайн бүлэгт үзүүлсэн нөлөөллийн хэмжээ, нөлөөлсөн магадлал, үр дүнгийн талаар байна. Тухайлбал, орон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газар, жижиг, дунд, том бизнес эрхлэгчид, импортлогчид, экспортлогчид, дотоодын зах зээлд бүтээгдэхүүн ханган нийлүүлэгчид, хэрэглэгчид, газар зүйн бүсүүд, нийгмийн бүлгүүд байна.	
2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр гарах нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байна:	
2.1. хүмүүсийн амьдралын хэв маягт үзүүлсэн нөлөө;	
2.2. хүмүүсийн соёлд үзүүлсэн нөлөө (хамтын итгэл, зан үйл, үнэт зүйл, соёл зэрэг);	
2.3. хүмүүсийн амьдардаг суурин болон нийгмийн бүлэгт үзүүлсэн нөлөө (уялдаа, тогтвортой байдал, шинж чанар, үйлчилгээ, байгууламж);	
2.4. хүрээлэн буй орчинд үзүүлсэн нөлөө (хүмүүсийн хэрэглэдэг ус, амьсгалдаг агаарын чанар, хүнсний бүтээгдэхүүний чанар, олдоц, аюул, эрсдэлийн түвшин, тоос, дуу чимээний хэмжээ, ариун цэврийн байгууламжийн хангамж, байгууламжийн аюулгүй байдал, нөөцөөс хүртэх боломж, нөөцөд хяналт тавих боломж).	
3. Бусад мэдээлэл	Энэхүү нөлөөллийн үнэлгээний "Б"-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөллийн талаар энд бичиж болно.

В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлсэн нөлөө	
1.Бодлогыг хэрэгжүүлэх явцад бий болсон хууль, эрх зүйн шинэчлэл	Тухайн бодлогыг хэрэгжүүлэх явцад өөрчлөлт, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулсан, батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журмуудыг жагсаан бичнэ.
Г. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлсэн нөлөө	
1.Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлсэн	1. Бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хэрэв төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд өөрчлөлт оруулсан бол энэ хэсэгт өөрчлөлтүүдийг оруулна. (шинээр бий болсон бүтэц, өнөөгийн институтийг татан буулгасан, эсхүл бүтцийг өөрчлөн байгуулсан)
2. Хүний нөөцөд	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, чадавхад гарсан бол өөрчлөлтийг бичнэ.

#### 1.4 Судалгааны төрөл, мэдээлэл цуглуулах арга зүй

Мэдээллийн үнэн бодит, тэнцвэртэй байдлыг хангаж, баталгаатай мэдээлэл авах зорилгоор судалгаанд анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх үүсвэр ашигласан. Анхдагч мэдээллийн судалгаанд ганцаарчилсан ярилцлага болон олон нийтийн судалгаа<sup>2</sup>, хоёрдогч мэдээллийн судалгаанд баримт бичгийн судалгаа хийлээ.

Зураг 2. Судалгааны төрөл, мэдээлэл цуглуулах арга



Ганцаарчилсан ярилцлагад хамрагдах байгууллага, албан хаагчдыг сонгохдоо дараах зарчмыг баримтлав. Үүнд:

1. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд оролцсон оролцогчдын цар хүрээг харгалзан үзэх;
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл”-ийн бүрэлдэхүүн байгууллагуудын холбогдох албан хаагчдыг хамруулах.

Хүснэгт 4. Судалгааны түүвэр

№	Судалгааны төрөл	Түүврийн нэгж	Хамрах хүрээ	Түүврийн хэмжээ
1				Уулзсан-16

<sup>2</sup> Олон нийтийн судалгаа нь ажлын даалгаварт тусгагдаагүй байсан бөгөөд судалгааны багийн зүгээс нэмэлтээр хийсэн. Санхүүжилттэй холбоотой олон нийтийн санаа бодол, нөлөөллийг өргөн цар хүрээнд судлах боломжгүй байсан.

	Ганцаарчилсан ярилцлага	- Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүн байгууллагуудын төлөөллүүд - Хөтөлбөрийн үйл ажиллагааны оролцогч талууд	Улаанбаатар хот	Утас-1 Цахим-2
3	Түүвэр судалгаа	- Цахимаар судалгаанд хамрагдах боломжтой иргэд /санамсаргүй түүврийн аргаар/ <sup>3</sup>	Монгол Улсын иргэд	50

Ганцаарчилсан ярилцлага судалгааны төлөвлөлт болон гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 5. Судалгаанд хамрагдсан байгууллагууд

№	Судалгаанд хамрагдахаар төлөвлөгдсөн байгууллагууд	Төлөвлөсөн нь	Гүйцэтгэл (биелэлт)
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
2	Гадаад харилцааны яам	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
3	Эрүүл мэндийн яам	Цахим асуулга	Цахим асуулга явуулсан
4	Соёлын яам	Цахим асуулга	Цахим асуулга явуулсан
5	Боловсрол, шинжлэх ухааны яам	Цахим асуулга	Цахим асуулга явуулсан
6	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Цахим асуулга	Цахим асуулга явуулсан
7	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Цахим асуулга	Цахим асуулга явуулсан
8	Сангийн яам	Цахим асуулга	Цахим асуулга явуулсан
9	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
10	ЦЕГ Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
11	Гадаад иргэн, харьяатын газар	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
12	Хил хамгаалах ерөнхий газар	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
13	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
14	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
15	Улсын ерөнхий прокурорын газар	Ганцаарчилсан ярилцлага	Утсаар мэдээлэл авсан
16	Тагнуулын ерөнхий газар	Ганцаарчилсан ярилцлага	Цахим асуулга бөглөсөн
17	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
18	Гаалийн ерөнхий газар	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
19	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн /хуучин нэрээр/	Цахим асуулга	Ганцаарчилсан ярилцлага хийсэн

<sup>3</sup> Байгууллагын цахим хаягаар судалгааны линк байршуулан судалгаа өгөх боломжтой иргэдээр бөглүүлсэн.



20	Дотоод хэргийн их сургууль	Цахим асуулга	Цахим асуулга бөглөсөн
21	Монголын хуульчдын холбоо	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
22	НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
23	Хүйсийн тэгш эрх төв ТББ	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
24	АНБАУНД ТББ	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн
25	ЭКПАТ МОНГОЛ ТББ	Ганцаарчилсан ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага хийсэн

### 1.5 Судалгааны хяналтын үе шатууд

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад мэдээллийн үнэн бодит байдлыг хангаж дараах хяналтуудыг хийлээ.


Зураг 3. Судалгааны хяналтын үе шатууд

АСУУЛГЫН ХУУДАСНЫ ХЯНАЛТ	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ХЯНАЛТ	МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ДАРААХ ХЯНАЛТ	МЭДЭЭЛЭЛ ШИВЭЛТИЙН ХЯНАЛТ
<p>Асуулгын хуудсыг боловсруулж, багаараа хэлэлцэж эцэслэх</p> <p><b>АРГА ЗҮЙ</b></p> <p>Холбогдох мэдээллийн судалгаа хийх</p> <p>Асуулгын хуудасны анхны төслийг гаргах</p> <p>Зөвлөх болон судалгааны багийн гишүүдтэй хэлэлцэж, санал тусгах</p> <p>Асуулгын хуудсыг эцэслэх</p>	<p>Дуу хураагуур, утас ашиглах</p> <p><b>АРГА ЗҮЙ</b></p> <p>Өдөр бүр бичлэгүүдийг тулган сонсож хяналт тавих</p> <p>Тухай бүр ирсэн ярилцлагыг хөрвүүлэх</p> <p>Зорилтот оролцогч судалгаанд хамрагдаж буй эсэхийг хянах</p>	<p>Судалгаанд оролцогчидтой утсаар холбогдон зарим хариултыг тодруулах</p> <p><b>АРГА ЗҮЙ</b></p> <p>Мэдээллийн логик алдааг шалгах</p> <p>Тодруулах шаардлагатай мэдээллийг дахин асуух</p>	<p>Шивэлтийн алдааг алдааны программ болон ярилцлага хийсэн судлаачаар уншуулж тулгаж шалгах</p> <p><b>АРГА ЗҮЙ</b></p> <p>Шивсэн өгөгдөл мэдээллийг алдаа шалгагч программаар шалгах</p> <p>Ярилцлага хийсэн судлаачаар уншуулж, дуу хураагчийг дахин сонсож дурдсан санаа агуулга орхисон эсэхийг шалгах</p>

### 1.6 Үнэлгээ хийхэд учирсан хүндрэл, бэрхшээл

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэх хугацаанд дараах хүндрэл, бэрхшээлүүд тулгарсан бөгөөд захиалагч тал, судалгаанд оролцогчдын дэмжлэг болон “Эс Ай Си Эй” ХХК-ын үнэлгээний багийн оновчтой зохион байгуулалтын үр дүнд амжилттай даван туулж чадсан.

- Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээний гэрээний хугацаанд улсын баяр наадмын амралт, төрийн байгууллагуудын албан хаагчдын



ээлжийн амралт зэрэг урт хугацааны амралт таарсан нь судалгааны мэдээлэл цуглуулах үйл явцыг удаашруулах хүчин зүйл болсон.

- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагуудын зарим үйл ажиллагаа нь Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулагддагтай холбоотойгоор шаардлагатай статистикийн тоо, мэдээлэл гаргаж өгөх, албан хаагчидтай холбогдох, уулзахад хүндрэлтэй байсан нь мэдээлэл цуглуулах ажлыг удаашрахад нөлөөлсөн.



---

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮН  
ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН  
НӨХЦӨЛ БАЙДАЛ**

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### 2.1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох илрүүлсэн гэмт хэргийн мэдээлэл

166 орны 51,675 хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн мэдээлэлд үндэслэн НҮБ-аас 2022 онд гаргасан тайлан дурдсанаар энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын 42 хувийг насанд хүрсэн эмэгтэй, 23 хувийг насанд хүрсэн эрэгтэй, 18 хувийг насанд хүрээгүй охид, 17 хувийг насанд хүрээгүй хөвгүүд эзэлж байна<sup>4</sup>. Хүн худалдаалах гэмт хэрэг нь техник технологийн дэвшил, цар тахал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан үйлдэгдэх хэлбэр, нөхцөл байдал нь хувьсан өөрчлөгдөж байгаа онц ноцтой гэмт хэргийн төрөл юм.

Монгол Улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд тухайлан заасан бөгөөд 2017-2021 оны байдлаар цагдаагийн байгууллагад хүн худалдаалах гэмт хэрэг болон түүнтэй төстэй зарим гэмт хэрэг 76 бүртгэгджээ. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг нийт 21 бүртгэгдсэн бөгөөд үүнээс 2018, 2019 онд хамгийн олон байна. Харин 2020 онд буюу Ковид-19 цар тахал гарснаас хойш энэ төрлийн гэмт хэргийн бүртгэгдэх байдал буурсан<sup>5</sup>.
- Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэрэг нь нийт 49 бүртгэгдсэн байна. Үүнээс 2019 онд хамгийн олон буюу 14 гэмт хэрэг бүртгэгджээ<sup>6</sup>. Харин 2022 оны эхний 8 сарын байдлаар нийт 8 хэрэг бүртгэгдсэн байна.
- Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд заасан Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг нийт 4 бүртгэгджээ. Үүнээс 2019 онд хамгийн олон буюу 2 гэмт хэрэг бүртгэгдсэн байна<sup>7</sup>.
- Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд заасан Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэрэг нь 2019 болон 2020 онд нийт 2 бүртгэгдсэн байна.<sup>8</sup>

<sup>4</sup> United National Office on Drugs And Crime, Global report on trafficking in persons 2022, page 15

<sup>5</sup> Эрүүгийн хууль, 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг


<sup>6</sup> Эрүүгийн хууль, 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах

<sup>7</sup> Эрүүгийн хууль, 13.13 дугаар зүйл Албадан хөдөлмөрлүүлэх

<sup>8</sup> Эрүүгийн хууль, 15.3 дугаар зүйл Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасагт 2017-2021 оны байдлаар Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл ангиар 225 хохирогч, 108 холбогдогчтой нийт 59 гэмт хэрэгт бүртгэгдсэн байна.


График 1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл заалтаар



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

2019 онд хамгийн олон 65 хохирогч бүхий гэмт хэрэг илрүүлсэн бөгөөд 2020 оноос эхлэн илрүүлсэн гэмт хэргийн тоо буурчээ. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдлын улмаас улсын хилээс гадна болон дотоодын зорчих хөдөлгөөнийг хязгаарласан нь 2021 онд хүн худалдаалах 7 гэмт хэрэг бүртгэгдэхэд нөлөөлсөн байх магадлалтай бөгөөд нөгөө талаараа нууц, далд хэлбэрт шилжиж байж болзошгүй гэж үзэх нөхцөлийг бий болгож байна<sup>9</sup>.

График 2. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, холбогдогчийн тоо



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

<sup>9</sup> Азийн сан, Хүйсийн тэгш эрх төв ТББ "Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ", УБ, 2022 он

2020, 2021 онд хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэлт буурсан нь дараах шалтгаантай. Үүнд:

1) 2019 онд Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг дүүргүүдээс нэмэлт хүч аван ажилласан бол 2020, 2021 онуудад үндсэн бүтцээрээ ажиллажээ.


2) Ковид-19 цар тахлын үед улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хөл хорио тогтоосноор чиглэл хариуцсан хэлтсийн мөрдөгчид шалгаж буй хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан тодорхой ажиллагааг явуулах боломжгүй нөхцөл байдал үүсэж, цагдаагийн байгууллагын нийтлэг үүргийнхээ хүрээнд халдвар авсан иргэдийн хавьтал, маршрутыг гаргаж ажилласан байна.

*Шигтгээ 1. Хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэлт буурсан шалтгаан*

*Хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэлт буурсан хэд хэдэн шалтгаан байгаа. Нэгдүгээрт 2019 онд Хүн худалдаалахтай тэмцэх хэлтэс дүүрэг бүрээс тодорхой тооны мөрдөгчид нэмэлтээр авч, өөр ажил руу оролгүй зөвхөн хүн худалдаалах гэмт хэрэг илрүүлэх чиглэлээр ажилласан. Албан хаагчдын тоо гэмт хэргийг илрүүлэлтэд шууд нөлөө үзүүлдэг. Үүнээс гадна Ковид-19 цар тахлын улмаас цагдаагийн байгууллагын нийтлэг үүргийн дагуу халдвар авсан иргэдийн хавьтал маршрутыг гаргаж өндөр ачаалалтай ажилласан.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

График 3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын төрөл, хувиар, 2017-2021 он



*Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар*

2017-2021 онд бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын 40.1 хувь нь насанд хүрээгүй. 2020 оноос эхлэн нийт хохирогчид эзлэх насанд хүрээгүй хүний эзлэх хувь огцом өссөн бөгөөд 2021 онд 73.1 хувьд хүрсэн нь анхаарал татахуйц байна.

2021 онд хүн худалдаалах гэмт хэргээр гадаад улсад хохирогч болсон иргэн бүртгэгдээгүй байна.

## 2.2 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан Прокурорын байгууллагаас хянасан хэргийн мэдээлэл

2017-2021 онд 81 хэрэг шинээр үүсэж, 81 хэрэгт хэрэг бүртгэлийн хэрэг нээж, 31 хэрэгт шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татжээ.

График 4. Шинээр үүссэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг, 2017-2021



Эх үүсвэр: Улсын Ерөнхий Прокурорын газар

Шинээр үүссэн болон хэрэг бүртгэлийн хэрэг үүсгэсэн хэрэг нь 2018 онд хамгийн олон буюу 28 байна. 2019-2021 онд буурсан байх бөгөөд харин 2019 онд нийт 20 хэрэг шинээр бүртгэгдэж, 19 хэрэг хэрэг бүртгэлийг хэрэг нээжээ.

Шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг 2017 онд 2 байсан бол 2018 онд 8-аар нэмэгджээ. Харин 2019-2021 онд харьцангуй ойролцоо үзүүлэлттэй байна.

График 5. Улаанбаатар хотод шинээр үүссэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг



Эх үүсвэр: Улсын Ерөнхий Прокурорын газар

2017-2021 онд Улаанбаатар хотод нийт 147 хэрэгт хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулжээ. Тэдгээрээс шинээр үүссэн, хэрэг бүртгэлийн хэрэг үүссэн хэрэг 78 байгаа бол шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг 30 байна.

2017 онд нийт 15 хэрэгт хэрэг бүртгэл үүсгэн, мөрдөн байцаалт явуулснаас 10 хэрэг шинээр үүсэж, 2 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байна. 2018 онд тус

үзүүлэлт өсөж нийт 40 хэрэгт хэрэг бүртгэлт үүсгэж, мөрдөн байцаалт явуулснаас 28 хэрэг шинээр үүсэж, хэрэг бүртгэлт нээн, 10 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байна. 2019 онд хэрэг бүртгэлт үүсгэж, мөрдөн байцаалт явуулсан нийт 31 хэрэг байснаас 6 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байна. 2020 онд хэрэг бүртгэлт үүсгэж, мөрдөн байцаалт явуулсан 34 хэрэг, үүнээс 6 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татжээ. 2021 онд мөн 6 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн бол 27 хэрэгт хэрэг бүртгэлтийн үүсгэж, мөрдөн байцаалт явуулсан байна.

График 6. Орон нутагт шинээр үүссэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг




Эх үүсвэр: Улсын Ерөнхий Прокурорын газар

2017-2021 онд орон нутагт нийт 5 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулжээ. Тэдгээрээс шинээр үүссэн, хэрэг бүртгэлтийн хэрэг үүссэн 3 хэрэг байгаа бол шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 1 хэрэг байна.

2017, 2018 онд хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэн, мөрдөн байцаалт явуулсан хэрэг байхгүй бол 2019 онд 3 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалт явуулж, тэдгээрийн 1-д шинээр эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татжээ. Харин 2020 болон 2021 онд тус бүр 1 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэн, мөрдөн байцаалт явуулжээ. Шинээр хэрэг үүссэн, яллагдагчаар татсан хэрэг байхгүй байна.

2017-2021 онд хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэсэн нийт 127 хэрэг байгаагийн 44-ийг хааж, 30 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан байна.

График 7. Хэрэг бүртгэлт явуулсан хэрэг






Эх үүсвэр: Улсын Ерөнхий Прокурорын газар

2017 онд 14 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэснээс 2 хэргийг хааж, 2 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, 10 хэрэг үлджээ. 2018 онд 38 хэрэгт бүртгэл үүсгэснээс 20 хэргийг хааж, 10 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 8 хэрэг үлджээ. 2019, 2020 онд тус бүр нийт 27 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 9 хэргийг хааж, 6 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татжээ. 2019, 2020 онд тус бүр 12 хэрэг үлдсэн байна. 2021 онд 21 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг үүсгэж, 4 хэргийг хааж, 6 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.


График 8. Мөрдөн байцаалт явуулсан хэрэг



Эх үүсвэр: Улсын Ерөнхий Прокурорын газар

2017-2021 онд 55 хэрэгт мөрдөн байцаалт явуулсны 28 хэргийг шүүхэд шилжүүлж, 6 хэрэг нэгтгэгдэж, 1 хэргийг түдгэлзүүлж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 19 хэрэг үлджээ. Тухайлбал, 2017 онд 3 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, шүүхэд шилжүүлсэн бол 2018 онд 12 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, 5 хэргийг шүүхэд шилжүүлж, 2 хэрэг нэгтгэгджээ. 2019 онд 13 хэрэгт мөрдөн байцаалт хийж, 5 хэргийг шүүхэд шилжүүлэн, 3 хэргийг нэгтгэсэн байна. 2020 онд 14 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, 7 хэргийг шүүхэд шилжүүлэн, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хэргийг түдгэлзүүлжээ. 2021 онд 13 хэрэгт мөрдөн байцаалт явуулснаас 8 хэргийг шүүхэд шилжүүлж, 1 хэрэг нэгтгэгджээ.

График 9. Шүүхэд хүлээн авсан хэрэг




2017-2021 онд нийт 28 хэргийг шүүхэд хүлээн авсан бөгөөд шүүхэд хүлээн авсан хэргийн тоо жил бүр нэмэгдсэн байна. Тухайлбал, 2017 онд 1 хэрэг, 2018 онд 4 хэрэг, 2019 онд 5 хэрэг, 2020, 2021 онд тус бүр 9 хэрэг шүүхэд шилжжээ.

### 2.3 Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх мэдээлэл

2018-2021 онд Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэвэл зохих “Хүн худалдаалах” 86 холбогдогчтой 36 хэрэг бүртгэгджээ.


График 10. Шүүхийн ерөнхий зөвлөлд шийдвэрлэвэл зохих хэрэг болон хүний тоо



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2018 онд 9 холбогдогчтой 4 хэрэг бүртгэлтэй байсан бөгөөд 2019-2021 онд тус үзүүлэлт тогтмол нэмэгдсэн байна. 2019 онд 8 хэрэг, 2020 онд 11 хэрэг, 2021 онд 13 хэрэг Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдэхээр бүртгэгджээ.


График 11. Нийт бүртгэгдсэн хэргийн шийдвэрлэсэн байдал, тайлангийн үлдэгдэл



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2018-2021 онд бүртгэгдсэн нийт хэргийн 74.4 хувийг шийдвэрлэгдэж, 25.6 хувь нь тайлант хугацаанд шийдвэрлэгдээгүй үлджээ. 2018 онд бүртгэгдсэн 4 хэргийн 3 (75%) нь шийдвэрлэгдэж 1 нь үлдсэн бол 2019 онд бүртгэгдсэн 8 хэргийн 5 (62.5%) нь шийдвэрлэгдэж, оны эцэст 3 хэрэг үлджээ. 2020 онд 1 (9.1%) хэрэг, 2021 онд 4 (30.8%) хэрэг үлдсэн байна.


График 12. 2018-2021 онд хэргийн шийдвэрлэгдсэн байдал



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2018-2021 онд шийдвэрлэсэн хэргийн 52.8 хувь буюу 41 холбогдогч бүхий 19 хэрэг хянан шийдвэрлэгдэж, 16.7 хувь буюу 14 холбогдогч бүхий 6 хэргийг прокурорт буцаасан байна. Түүнчлэн 2 холбогдогч бүхий 1 хэргийг түдгэлзүүлж, мөн адил хэргийг харьяаллын дагуу шилжүүлжээ.


График 13. Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэгдсэн байдал



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Түдгэлзүүлсэн, харьяаллын дагуу шилжүүлсэн 4 холбогдогч бүхий 2 хэрэг нь 2021 онд бүртгэлтэй байна. Хянан шийдвэрлэсэн болон, прокурорт буцаасан хэргүүдийг оноор нь харьцуулбал 2018 онд 3, 2019 онд 2, 2020 онд 8, 2021 онд 6 хэргийг тус бүр хянан шийдвэрлэжээ. Харин 2019 онд 3, 2020 онд 2, 2021 онд 1 хэргийг прокурорт буцаасан байна.


График 14. Шүүхээр дангаар болон бүрэлдэхүүнээс шийдвэрлэгдсэн хэргийн тоо



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2018-2021 онд хянан шийдвэрлэсэн нийт 19 хэргийн 89.5 хувь буюу 17 хэргийг бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэжээ. 2019 онд 1 хэрэг, 2021 онд 1 хэрэг, нийт 2 хэргийг дангаар хянан шийдвэрлэсэн байна.


График 15. Өмгөөлөгч оролцсон шүүх хурлын тоо



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2018-2021 онд нийт 22 өмгөөлөгч шүүх хуралд оролцсон бөгөөд 2018 онд 7 шүүх хурал 2019 онд хамгийн цөөн буюу 2 шүүх хуралд, 2020 онд 7, 2021 онд 6 шүүх хуралд тус бүр өмгөөлөгч оролцжээ.


График 16. Ял шийтгүүлсэн хүний тоо, хүйсээр



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2018-2021 онд нийт 41 хүнд ял оноосон байна. Тэдгээрийн 12 (29.3%) нь эмэгтэй, 29 (70.7) нь эрэгтэй байна. 2020 онд нийт 19 хүн хорих ял шийтгүүлсний 18 нь эрэгтэй байсан бол 2021 онд 10 хүн хорих ял шийтгүүлсний 3 нь эрэгтэй нь эмэгтэй байна.

График 17. Хорих ял шийтгүүлсэн хүмүүс, насны ангиллаар




Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2018-2021 онд нийт 10 хүн давхар зүйл ангиар ял шийтгүүлжээ. Тэдгээрийн 70.0 хувь нь 2020 онд, 20.0 хувь нь 2021 онд ял шийтгүүлсэн байна.

2018-2021 онд хүн худалдаалах гэмт хэргээр хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн 73.2 хувь нь 30-аас дээш насныхан байна. Хорих ял шийтгүүлсэн 18-21 насны 3 (7.3%) хүн байгаа нь бүгд 2021 онд шийтгүүлжээ. 2021 оноос өмнө 21-ээс доош насны хорих ял шийтгүүлсэн хүн байхгүй байна. 22-29 насны иргэдийн хувьд 2018-2021 онуудад тус бүр 2 хүн хорих ял шийтгүүлжээ.


График 18. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн боловсролын түвшин



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

Хүн худалдаалах гэмт хэргээр хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн 95.1 хувь нь бүрэн дунд буюу түүнээс доош боловсролтой байна. Хорих ял шийтгүүлсэн иргэдийн 63.5 хувь нь бүрэн дунд, 24.4 хувь нь суурь, 2.4 хувь нь бага, 4.9 хувь нь боловсролгүй. Түүнчлэн хохир ял шийтгүүлсэн хүмүүсийн 80.5 хувь нь тодорхой ажил хөдөлмөр эрхэлдэггүй байна.


График 19. Давхар зүйл ангиар ял шийтгүүлсэн хүн



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

2018-2021 онд хүн худалдаалах гэмт хэргээр хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн 24.3 хувь нь давхар зүйл ангиар ял шийтгүүлжээ. Нийт давхар ял шийтгүүлсэн хүмүүсийн 70.0 хувь нь 2020 онд хянан шийдвэрлэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

График 20. Хорих ялын хугацаа



2018-2021 онд 41 хүн хүн худалдаалах гэмт хэргээр хорих ял шийтгүүлсний 9.8 хувь нь хөнгөн гэмт хэргээр буюу 6 сараас 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгүүлсэн бол үлдсэн 90.2 хувь нь хүнд гэмт хэргээр ял шийтгүүлсэн байна. Хүнд гэмт хэргээр хорих ял шийтгүүлсэн 3 хүн тутмын нэг нь 5-8 жилээр, 49.0 хувь нь 10-20 жилээр, 2.4 хувь нь бүх насаар хорих ялаар шийтгүүлжээ. Хорих ял эдэлж байгаа хүмүүсийн 56.1 хувь нь нээлттэй, 43.9 хувь нь хаалттай хорих ангид ял эдэлж байна.

#### 2.4 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ял эдэлж буй иргэдийн мэдээлэл

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан (хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан) хорих ял эдэлж байгаа хүмүүсийн тоо сүүлийн жилүүдэд өссөн байна. 2021 оны 12 дугаар сарын байдлаар тус зүйл ангиар нийт 18 хүн ял эдэлж байсан бөгөөд энэ нь 2017 онтой харьцуулахад 3 дахин өсжээ.

График 21. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хорих ял эдэлж байсан хүмүүсийн тоо, хүйсээр



Хүйсээр нь харьцуулбал, 2017, 2019, 2020 онд ял эдэлж байсан хүмүүсийн ихэнх нь эрэгтэй, 2018 онд ял эдэлж байсан хүмүүсийн ихэнх нь эмэгтэй байна. Харин 2021 онд ял эдэлж байсан хүмүүсийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа тэнцүү, тус бүр 9 байна.

График 22. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хорих ял эдэлж байсан хүмүүсийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл ангиар



Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас буюу Эрүүгийн хуулийн 13.1.1 дүгээр зүйлд зааснаар хорих ял авч байсан этгээд 2017 онд байхгүй бол 2018 онд 1, 2019 онд 11 болон өссөн байна.<sup>10</sup>

Харин 13.1.2 дахь хэсэгт зааснаар ял эдэлж байсан иргэдийн тоо 2017 онд 6, 2018 онд 4, 2019 онд 2 байсан бол 2020 онд 11, 2021 онд 13 болж нэмэгдсэн байна.<sup>11</sup>

Зохион байгуулалттай, хүн худалдаалах гэмт хэрэг байнга үйлдэж байсан гэх нийт 7 этгээд 2020, 2021 онд Эрүүгийн хуулийн 13.1.3 дахь хэсэгт зааснаар хорих ял шийтгүүлсэн байна. Энэхүү зүйлд зааснаар өмнөх онуудад нь хорих ял шийтгүүлсэн хүн байхгүй байна.<sup>12</sup>

График 23. Бэлгийн мөлжлөгтэй холбоотой ял эдэлж байсан хүмүүсийн тоо, хүйсээр



Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл болох бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй холбоотой ял эдэлж байсан этгээдүүдийн тоо жил тутам тогтмол нэмэгдсэн үзүүлэлтэй байна. 2017 оны 12 дугаар сард тус зүйл ангиар ял эдэлж байсан хүн байгаагүй бол 2021 оны 12 дугаар сарын байдлаар ял эдэлж байсан 3 этгээд бүртгэгджээ. Тэднийг хүйсээр нь ангилбал, 2018 онд ял эдэлж байсан нэг эмэгтэй байна. 2019-2021 онд ял эдэлж байсан хүмүүс бүгд эрэгтэй байжээ.

<sup>10</sup> Эрүүгийн хууль, 13.1.Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>11</sup> Эрүүгийн хууль, 13.1.2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйд мэдсээр байж; 2.2.хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; 2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>12</sup> Эрүүгийн хууль, 13.1.3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга тогтвортой; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

График 24. Бэлгийн мөлжлөгтэй холбоотой ял эдэлж байсан хүмүүсийн тоо, Эрүүгийн хуулийн зүйл ангиар




Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл (бэлгийн мөлжлөг)-ийн 12.3.1 дэх хэсэгт зааснаар 2019-2021 онд 1 этгээд ял эдэлж байжээ.<sup>13</sup>

Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр 2021 онд ял эдэлж байсан 3 хүний 2 нь Эрүүгийн хуулийн 12.3.2 дахь хэсэгт зааснаар ял шийтгэгджээ. Дээрх графикаас харахад энэ зүйлээр өмнө нь ял шийтгүүлж байсан хүн байхгүй байна.<sup>14</sup> Эрүүгийн хуулийн 12.3.3 дахь хэсэгт зааснаар 2018 болон 2020 онд тус бүр нэг хүн ял эдэлж байжээ.<sup>15</sup>

## 2.5 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох дуудлага, мэдээлэл

График 25. Хүүхдийн тусламжийн 108 утсанд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой ирсэн дуудлагын тоо



Эх үүсвэр: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

<sup>13</sup> Эрүүгийн хууль, 12.3.1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>14</sup> Эрүүгийн хууль, 12.3.2. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор 12.3.2.1, 12.3.2.2, 12.3.2.3, 12.3.2.4, 12.3.2.5, 12.3.2.6 дугаар зүйл заалтуудыг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>15</sup> Эрүүгийн хууль, 12.3.3. Энэ гэмт хэргийн улмаас: 3.1. ураг зулбасан; 3.2. арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох дуудлага мэдээлэл сүүлийн жилүүдэд өссөн байна. 2016 онд ГБХЗХГ-ын дэргэдэх хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох 1 дуудлага ирсэн бол 2017 онд 6 болон өсжээ. 2021 онд тус гэмт хэрэгтэй холбоотой 5 дуудлага ирсэн байна. Хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт ирж буй дуудлагын тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

## 2.6 Дүгнэлт

Монгол Улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд тухайлан заасан бөгөөд 2017-2021 оны байдлаар цагдаагийн байгууллагад хүн худалдаалах гэмт хэрэг болон түүнтэй холбогдох 76 гэмт хэрэг бүртгэгдэж, улмаар прокурорын байгууллагаас 81 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 31 хэрэгт шинээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан байна.

Харин 2018-2021 онд Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэвэл зохих хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох 36 хэрэг бүртгэгдэж, 19 хэргийг хянан шийдвэрлэжээ..

2017-2021 онд Монгол Улсад бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын 40.1 хувь нь насанд хүрээгүй иргэд байгаа бол сүүлийн жилүүдэд насанд хүрээгүй хохирогч нэмэгдэх хандлагатай байна. Мөн энэ төрлийн гэмт хэргээр хорих ял шийтгүүлсэн яллагдагчдын 70 хувь нь эрэгтэй, ихэнх нь 30-аас дээш насны иргэд байна.

Түүнчлэн Цагдаагийн байгууллагын мэдээллээр 2020 оноос эхлэн илрүүлсэн хүн худалдаалах гэмт хэргийн тоо буурч байгаа бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн мэдээллээр Эрүүгийн хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдуулан ял эдэлж байгаа хүмүүсийн тоо сүүлийн жилүүдэд тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн жилүүдэд хүн худалдаалахтай холбогдох хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт ирэх дуудлагын тоо нэмэгджээ.



---

**ГУРАВДУГААР БҮЛЭГ.  
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Их Хурлаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан.

Тус хөтөлбөрийн зорилго нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн.<sup>16</sup> Энэхүү үндсэн зорилгын хүрээнд 4 зорилт, 26 үйл ажиллагааг 2017-2021 онд хэрэгжүүлэхээр тусгасан.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн **ерөнхий үнэлгээ 91.6 хувь** байна. Үүнийг зорилт тус бүрээр нь авч үзвэл:


**Нэгдүгээр зорилт** болох “Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах” ажил **92.8** хувь,

**Хоёрдугаар зорилт** болох “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх” ажил **94.6** хувь,

**Гуравдугаар зорилт** болох “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах” ажил **81.6** хувь,

**Дөрөвдүгээр зорилт** болох “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх” ажил **93.3** хувийн биелэлттэй байна.


График 26. Хөтөлбөрийн ерөнхий үнэлгээ



<sup>16</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 2.1 дэх заалт

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд хугацааны үнэлгээг 2019 онд хийсэн байна. Энэ удаагийн үнэлгээ 2019 оноос 8.9 нэгж хувиар нэмэгдсэн байна. Зорилт тус бүрээр авч үзвэл 1 дүгээр зорилтын үнэлгээ хамгийн өндөр буюу 17.4 нэгж хувиар өссөн байна.

График 27. Хөтөлбөрийн ерөнхий үнэлгээ, 2019 оны үнэлгээтэй харьцуулсан байдал



Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үндсэн 4 зорилгын хүрээнд 26 үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн.

Хүснэгт 6. Зорилт тус бүрийн үйл ажиллагааны үр дүн, тоогоор

№	Зорилт	Үр дүнтэй	Тодорхой үр дүнтэй	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	Нийт
1	1-р зорилтын хүрээнд	4	5	-	-	9
2	2-р зорилтын хүрээнд	2	4	-	-	6
3	3-р зорилтын хүрээнд	3	3	2	-	8
4	4-р зорилтын хүрээнд	2	1	-	-	3
<b>Нийт</b>		<b>11</b>	<b>13</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>26</b>

1 дүгээр зорилтын хүрээнд төлөвлөсөн 9 үйл ажиллагаа төлөвлөгдсөн бөгөөд 5, 6, 8 дугаар үйл ажиллагаа нь дэд үйл ажиллагаануудаас бүрдэнэ. 5 дугаар үйл ажиллагаа нь 4 дэд үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд тэдгээрийн 4 дэх дэд үйл ажиллагаа "Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулах" эрчимжүүлэх шаардлагатай бусад нь үр дүнтэй. 6 дугаар үйл ажиллагааны хүрээнд 2 дэд үйл ажиллагаа, 8 дугаар үйл ажиллагааны хүрээнд 4 дэд үйл ажиллагаа төлөвлөгдсөн, эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа байхгүй байна.

2 дугаар зорилтын хүрээнд нийт 6 үйл ажиллагаа төлөвлөгдсөн бөгөөд үйл ажиллагаа 6 нь 4 дэд үйл ажиллагаанаас бүрдэнэ. Эдгээрт эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа байхгүй.

3 дугаар зорилтын хүрээнд 8 үйл ажиллагаа төлөвлөгдсөн бөгөөд дэд үйл ажиллагаа байхгүй. Эрчимжүүлэх шаардлагатай 3 "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагыг холбогдох бусад байгууллагатай мэдээллийн нэгдсэн сүлжээгээр холбож мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн шаардлагатай техник хэрэгслээр хангах, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажиллах

ажилтныг бэлтгэх" болон " 7 "Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх төвийг байгуулах" дугаар үйл ажиллагаа байна.

4 дүгээр зорилтын хүрээнд 3 үйл ажиллагаа төлөвлөсөн бөгөөд эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа байхгүй байна.

### 3.1. Нэгдүгээр зорилтын үйл ажиллагаануудын үнэлгээ, үр дүн

Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах нэгдүгээр зорилтын хүрээнд дараах 9 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 7. Нэгдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн үнэлгээ	Ангилал
1	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, хөтөлбөрийг сурталчлах, энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдээллийн санг бий болгох;	80 хувь	Үр дүнтэй
2	Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар судалгаа хийж, судалгааны үр дүнд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлын агуулга, хэлбэрийг тодорхойлох;	100 хувь	Үр дүнтэй
3	Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилго бүхий сургалтын гарын авлага бэлтгэх, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;	100 хувь	Үр дүнтэй
4	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд дүн шинжилгээ хийж үнэлгээ өгөх;	100 хувь	Үр дүнтэй
5	Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;	90 хувь	Тодорхой үр дүнд хүрсэн
5.1	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, энэ төрлийн гэмт хэргийн сэжиг илэрсэн тохиолдолд хандах байгууллагын талаар мэдлэг олгох, тухайлбал, уг гэмт хэргийн хор уршгийн талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхэлдэйн кино, нэвтрүүлэг, цахим хичээл, зөвлөмж, сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас, сургалтын гарын авлага, сурталчилгааны материал зэргийг бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, цахим орчин, сургууль, олон нийтийн газраар түгээх;	100 хувь	Үр дүнтэй
5.2	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхэд, залуучуудад зориулсан сургалт явуулах, сургагч багш нарыг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэн сургууль, хүүхдийн асрамжийн төвүүдэд сургагч багш нарыг бэлтгэх;	100 хувь	Үр дүнтэй
5.3	Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бүх шатны боловсролын байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн байгууллага, төрийн бус байгууллагын ажилтнуудыг хүн	100 хувь	Үр дүнтэй

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн үнэлгээ	Ангилал
	худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах, хүүхдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхийн тулд эцэг, эхтэй хамтран ажиллах;		
5.4	Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулах;	60 хувь	Эрчимжүүлэх шаардлагатай
6	Бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зорилтот бүлгийг тодорхойлж, тэдгээрт чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:	90 хувь	Тодорхой үр дүнтэй
6.1	Жил тутам зорилтот бүлгийн 20 –оос доошгүй иргэнийг мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцуулан мэргэжил эзэмшүүлэх, ажлын байраар хангах;	100 хувь	Үр дүнтэй
6.2	Оролцоонд суурилсан бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, семинар, арга хэмжээг зохион байгуулах;	80 хувь	Тодорхой үр дүнтэй
7	Хөдөлмөрийн мөлжлөгийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээ зохион байгуулах;	88 хувь	Тодорхой үр дүнтэй
8	Хүний эд эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;	87.5 хувь	Тодорхой үр дүнтэй
8.1	Хил хяналтын болон эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах;	100 хувь	Үр дүнтэй
8.2	Хүний эд эрхтэн, ялангуяа эхэс, ураг худалдах, худалдах зорилгоор тээх гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох чиглэлээр олон улсын туршлагыг судлах, мэргэжилтэн бэлтгэх;	70 хувь	Тодорхой үр дүнтэй
8.3	Хилийн хяналтын байгууллагуудыг орчин үеийн техник хэрэгслээр хангах;	100 хувь	Үр дүнтэй
8.4	Зорилтот бүлгийн иргэдийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах, энэ чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажиллах;	80 хувь	Тодорхой үр дүнтэй
9	Хүүхэд хууль бусаар үрчлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хүүхэд үрчлэлт, гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах ажилд тавих хяналтыг сайжруулах;	100 хувь	Үр дүнтэй
<b>Дундаж үнэлгээ</b>		<b>92.8 хувь</b>	<b>Тодорхой үр дүнтэй</b>



**Үйл ажиллагаа 1:**<sup>17</sup> Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, журам, хөтөлбөрийг сурталчлах, энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээллийн санг бий болгох үйл ажиллагааг “**тодорхой үр дүнтэй**” байна гэж үнэлэв.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас үзэхэд 2018 онд хүн худалдаалахтай холбогдох мэдээллийг хүлээн авч боловсруулах цахим мэдээллийн санг бий болгож ээ. 2019 онд мэдээллийн санг өргөтгөх зорилгоор Өмгөөллийн Заяа энд Золо төвтэй хамтран ажилласан байна. Цагдаагийн байгууллагаас Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх цахим санд 2020 оны эхний хагас жилийн байдлаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, холбогдогч, энэ төрлийн гэмт хэрэгт өртөж болзошгүй давхардсан байдлаар 1700 орчим хүний мэдээллийг оруулснаас давхцалыг арилгаж, 1520 хүний мэдээллийг оруулжээ. Мөн тус цахим санг хөгжүүлэх чиглэлээр тээврийн хэрэгсэл, гэр бүлийн байдал, жолооны үнэмлэх, үл хөдлөх хөрөнгө, нийгмийн даатгал, хилийн лавлагаа, ял шийтгэл зэрэг дамжуулах серверүүдийг байршуулсан “ХУР” системтэй холбосон байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүрэг бүхий Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба нь дотоод бүртгэлийн цахим сантай болсон бөгөөд тус сан нь энэ төрлийн гэмт хэргийн холбогдогч талуудын бүхий л мэдээллийг бүртгэдэг байна. 2022 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 1870 иргэний мэдээлэл тус цахим мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

Ийнхүү мэдээллийн сан бий болсон ч зөвхөн цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа нь учир дутагдалтай юм. Дээрх мэдээллийн санг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн байгууллагуудыг ашиглах боломжтойгоор хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

**Үйл ажиллагаа 2:**<sup>18</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар судалгаа хийж, судалгааны үр дүнд суурилсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлын агуулга, хэлбэрийг тодорхойлох үйл ажиллагааны хүрээнд “**үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дурдсанаар дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

- 2021-2022 онд Бадамлянхуа сангийн санхүүжилттэй Азийн сан олон улсын байгууллага, “Хүйсийн тэгш эрх төв” ТББ “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал”;
- 2021-2022 онд “Хүүхэд хамгааллын компакт гэрээ”-ний төслийн санхүүжилттэй ИРИМ судалгааны хүрээлэнгээс хийсэн Хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн суурь судалгаа;
- 2021-2022 онд “Гэмт хэрэг, зөрчил, урьдчилан сэргийлэх ажлын талаарх хүн амын ойлголт, хандлага” судалгаа;

---

<sup>17</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.1 дэх заалт

<sup>18</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.2 дахь заалт

- 2021 онд Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын санхүүжилтээр судалгааны ИРИМ компани "Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа";
- 2020 онд ДХИС-аас "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ өгөх" ажлын хэсгийг байгуулж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс хэрэгжүүлж буй "Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй хийх тэмцэл", "Цахим мөнгөний олон улсын зах зээл, түүнтэй холбогдох болзошгүй эрсдэлүүд, баримтлах стратеги", "Терроризмтой хийх тэмцэл", "Мансууруулах бодистой хийх тэмцэл", "Үндэстэн дамнасан гэмт хэрэг", "Хүний наймаатай хийх тэмцэл" зэрэг судалгаа;
- 2019 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр "Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам" сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэсэн;
- 2019 онд Монголын Хуульчдын холбооны Хөдөлмөрийн эрх зүйн дэд хороо, Европын холбооны дэмжлэгтэйгээр "Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын "Албадан хөдөлмөрийн тухай" 29 дүгээр протоколд Монгол Улс нэгдэн орсноор гарах үр дагавар хэрэгцээ шаардлагын талаарх судалгаа";
- 2017 онд Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын санхүүжилтээр судалгааны Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ "Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, хэрэгжилтэд тулгарч буй асуудлыг тодорхойлох" суурь судалгааг хийсэн;
- 2018 онд Азийн эмэгтэйчүүдийн сан, "Хүйсийн тэгш эрх төв" ТББ, Жендерт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой эрүүгийн хэрэгт хууль зүйн дүн шинжилгээ хийсэн;
- 2017 онд Азийн сан, "Хүйсийн тэгш эрх төв" ТББ "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгаа"-ны тайлан;
- 2020-2022 оны эхний 9 сарын байдлаар цахим орчинд биеэ үнэлэхийг зохион байгуулж буй нийт 243 фейсбүүк групп, чат, вэб хуудас /мессеж зар/ -ийг илрүүлж, шалган домэйн хаягийн хандалтыг хязгаарласан байна. Тухайлбал, 2020 онд 120, 2021 онд 45, 2022 оны эхний 9 сарын байдлаар 78 хаягт хязгаарлалт тавьсан байна.
- 2020 онд ХНХЯ, ГХУСАЗЗАА, "Хүйсийн тэгш эрх төв" ТББ-тай хамтран БНСУ-ын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй "Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх төслийн" хүрээнд ХНХЯ-аас "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх хамтын ажиллагааг бэхжүүлэх нь" сэдэвт цахим хэлэлцүүлгийг зохион байгуулсан;
- 2020 онд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс ГХУСАЗЗАА, ХНХЯ-тай хамтран хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэлтээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд эрдэмтэн, судлаачдын дуу хоолойг сонсох, энэ асуудлаарх бодлого, хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хуульч, нийгмийн салбарын ажилтнуудын дунд эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулсан;



- 2020 онд “Цахилгаан халаагуур бүхий сауны газар болон цахилгаан халаагуур бүхий саунтай аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5164:2010 -ын 9.3 дахь заалтыг<sup>19</sup> хангаж тодорхойлолт өгсөн;

2018 онд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад шаардлагатай суурь мэдээллийг цуглуулж судалгаа явуулах ажлын хэсгийг байгуулан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий гудамж талбай, саун массаж, караоке бааранд биеэ үнэлж байгаа 580 охид, эмэгтэйчүүдийг бүртгэн, судалгаанд хамруулсан байна. Түүнчлэн ХЗДХЯ, Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд ХХГХ-тэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбогдуулан Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгаа хийжээ. Мөн хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох зорилго бүхий гарын авлагыг боловсруулж хэвлүүлсэн. 2019 онд Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн бөгөөд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн дунд шатны хэрэгжилтийн үнэлгээг хийжээ.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад ГХУСАЗЗАА-наас жил бүр “Гэмт хэргийн цагаан ном”-ыг гаргадаг бөгөөд тухайн номын нэг бүлэг нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой суурь судалгааны үзүүлэлтүүд тусгасан байдаг. Мөн хөтөлбөрийн хүрээнд оролцогч талууд суурь болон хавсарга судалгааны ажлуудыг гүйцэтгэж, судалгааны үр дүнд суурилан ажлаа төлөвлөж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа талаар дурдсан байна. Жишээ нь Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын санхүүжилтээр “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа” 2022 онд хэвлэгдэн гарсан. Мөн Хүйсийн тэгш эрх төв, Азийн сангийн санхүүжилтээр “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” судалгааны тайланг 2021 онд боловсруулсан бөгөөд дээрх судалгааны тайлан олон албан хаагчийн ширээний ном болон ашиглагдаж байна. Ийнхүү суурь, хавсарга судалгааны ажлууд хийгдэж байгаа нь сайшаалтай. Гэвч цаашид судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан арга хэмжээ авч, үйл ажиллагааны үр дүнд гарч буй өөрчлөлтөд анализ хийн, хариу арга хэмжээгээ тогтмол сайжруулах нь чухал юм.

Хөтөлбөр хэрэгжих хугацаанд хийсэн судалгаанууд ихэвчлэн хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлсон, өргөн хүрээний судалгаанууд байна. Тиймд цаашид хүн худалдаалах гэмт хэргийг төрөл, оролцогч талуудаар нь нарийвчилсан судалгаа, шинжилгээг түлхүү хийх хэрэгтэй. Учир нь нарийвчилсан судалгаа нь тухайн асуудлыг илүү гүнзгий, олон талаас нь харах боломжийг бий болгодог бөгөөд судалгааны хамрах хүрээ өргөсөх тусам нарийн асуудлыг орхигдуулах хандлагатай байдаг. Цаашид хийвэл зохих зарим судалгааны сэдвийг тодорхойлбол,

---

<sup>19</sup> Сауны үйл ажиллагаа эрхлэгч болон ажиллагсад нь биеэ үнэлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулсан болон садар самуунтай холбоотой аливаа хэрэг зөрчилд холбогдоогүй талаар цагдаагийн байгууллагаас тодорхойлолт авсан байна.

- Хилийн орчим амьдардаг иргэдийн хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх магадлал, шалгаан, хариу арга хэмжээ;
- Хурдан морины уралдаанч хүүхдүүдийн хөдөлмөрийн мөлжлөг, кейс судалгаа;
- Хүн худалдаалах гэмт хэрэгт үйлдсэн этгээдүүдийн гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа;
- Бэлгийн мөлжлөгт өрсөн иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, түүний урт болон богино хугацааны үр дүн (үр дүн өндөртэй үйлчилгээг тодорхойлох судалгаа);
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын сэтгэл зүйн гэмтэл, хариу үйлчилгээний судалгаа;
- Монгол Улсын иргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох магадлалтай улс орнуудын судалгаа;
- Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөх, илрүүлэх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж буй албан хаагчдын хөдөлмөр эрхлэлт, ажлаас халшрах хам шинжийг тодорхойлох судалгаа” г.м байна.

**Үйл ажиллагаа 3:**<sup>20</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилго бүхий сургалтын гарын авлага бэлтгэх, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах үйл ажиллагааг “**үр дүнтэй**” гэж үзэв.

2017-2021 онд их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, ерөнхий боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөр, агуулгад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Тухайлбал, БСШУСЯ-наас аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт ЕБС-ийн сурагчдын дунд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулах, долоо хоног бүрийн мягмар гарагийн сүүлийн цагийн хичээлийн 5 минутад сурагчдад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл өгөх талаар зөвлөмж, чиглэл хүргүүлсэн байна.

Мөн 2017 оны 4 дүгээр улиралд ХСИС (хуучин нэрээр)-ийн 500 оюутанд хүн худалдаалах гэмт хэргийн анхан шатны мэдлэг олгох 4 цагийн сургалт зохион байгуулж, хүн худалдаалахтай тэмцэх дэлхийн өдөр “Хөх зүрхний аян”-ы хүрээнд 12 их, дээд сургуулийн 674 оюутан залуус, нийслэлийн 3 дүүргийн ЕБС-ийн ахлах ангийн 130 багшийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтад хамруулсан байна. Түүнчлэн БНСУ-ын Жендерийн тэгш эрх, гэр бүлийн яамнаас боловсруулсан “Бэлгийн мөлжлөгийн хохирогчийн хүний эрхийн хамгааллын тухай” гарын авлагыг Монгол хэлнээ орчуулсан. Уг гарын авлагын загварт үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тугаалаар Монгол Улс дахь бэлгийн мөлжлөгийн хохирогчийг таньж тогтоох, илрүүлэх гарын авлагын төслийг боловсруулан танилцуулж холбогдох мэргэжилтнүүдээс санал авч нэгтгэсэн. АНУ-ын төрийн департаментаас санхүүжүүлж Азийн сангаас хэрэгжүүлсэн “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, алба хаагчдыг чадавхжуулах нь” төслийн хүрээнд хийгдсэн 320 ширхэг сургалтын номыг

<sup>20</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.3 дахь заалт

тараасан. “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга зүй” хэрэг бүртгэгч, мөрдөгчдөд зориулсан цахим гарын авлагыг боловсруулсан. Дээрх гарын авлага, сургалтын материалыг үндэслэн хил гааль болон цахимаар ард иргэдийн энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалсан нөлөөллийн ажлуудыг төрийн бус байгууллагууд болон холбогдох төрийн байгууллагууд хамтран гүйцэтгэж байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад холбогдох байгууллагын төлөөллүүд хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд маш сайн хүргэж байгаа талаар дурдсан. Жишээ нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл түгээх зорилготой “Миний хотод биш”, “Мөрөөдлийн шүхэр” зэрэг нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан байна. Түүнчлэн хил хамгаалах байгууллагатай хамтран хилээр нэвтэрч буй иргэдэд ажиглалт хийж, мэдээллийг түгээсэн байна. Арга хэмжээний явцад 2017 болон 2018 онд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч байх магадлалтай, өртөх эрсдэл бүхий 3600 хүнтэй ярилцаж мэдээлэл өгчээ.

Мөн судалгаанд хамрагдсан төлөөллүүдийн хувьд энэ төрлийн гэмт хэргийн холбогдогч /гэрч, хохирогч г.м/ талаас ирэх дуудлага, мэдээллийн хандалт нэмэгдсэн нь нөлөөллийн ажлын үр дүн гэж үзэж байна. Түүнчлэн хилээр нэвтэрч буй иргэдэд тараасан гадаад дахь Монголын дипломат, төлөөлөгчийн газар, төрийн бус байгууллагуудтай холбогдох утасны дугаар, холбоо барих мэдээлэл агуулсан “Паспортын хавчуурга”-аар дамжуулан энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж байсан иргэнд туслалцаа үзүүлж чадсан зэрэг үр дүнг онцлон дурджээ.

Ийнхүү холбогдох гарын авлага сургалтын материалуудыг боловсруулж нөлөөллийн ажлуудыг төрийн, төрийн бус байгууллагууд хамтран хийж гүйцэтгэжээ.

**Үйл ажиллагаа 4:**<sup>21</sup> Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд дүн шинжилгээ хийж үнэлгээ өгөх үйл ажиллагааг “**үр дүнтэй**” гэж үнэлэв.

ХЗДХЯ нь НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийлгэж зөвлөмж, дүгнэлт боловсруулсан.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийн хуралдааныг мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллага болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж өргөтгөсөн байдлаар зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийн явцын талаар хэлэлцүүлсэн. Охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий “Мөрөөдлийн шүхэр” мэдээллийн аяныг 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 21 хоногийн хугацаанд зохион байгуулсан. Мэдээллийн аяны турш иргэд, олон нийтэд хүргэсэн урьдчилан сэргийлэх агуулга бүхий сэрэмжлүүлэг нь давхардсан тоогоор нийт 26 сая хүнд хүрсэн бөгөөд мэдээллийн аяны дараа үр дүнгийн үнэлгээг “КАР:

---

<sup>21</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.4 дэх заалт

Knowledge, Attitude, Practice” аргачлалаар хийж иргэд, олон нийтийн мэдлэг, хандлага, ойлголтын өөрчлөлтийг үнэлсэн байна. Энэхүү үнэлгээгээр иргэд, олон нийтийн ойлголт, хандлага 5 хувиар өссөн гэж дүгнэгдсэн байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 2019 болон 2022 онд хийсэн.

Мөн энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд мэдлэг мэдээлэл өгөх, хохирогчдын буруутгах хандлагыг өөрчлөх зорилгоор бодит хохирогчид тохиолдсон явдалд үндэслэсэн “**Даван туулагчийн хүч**” баримтат киног Эрхэст энтертейнмент ХХК-ын хамтран бүтээж, 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн өргөн нэвтрүүлгийн телевиз болон цахим сүлжээгээр цацаж олон нийтэд хүргэсэн.

**Үйл ажиллагаа 5:**<sup>22</sup> Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ “**тодорхой үр дүнтэй**” байна.

**Үйл ажиллагаа 5.1:**<sup>23</sup> Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, энэ төрлийн гэмт хэргийн сэжиг илэрсэн тохиолдолд хандах байгууллагын талаар мэдлэг олгох, тухайлбал, уг гэмт хэргийн хор уршгийн талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхэлдэйн кино, нэвтрүүлэг, цахим хичээл, зөвлөмж, сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас, сургалтын гарын авлага, сурталчилгааны материал зэргийг бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, цахим орчин, сургууль, олон нийтийн газраар түгээх үйл ажиллагаа “**үр дүнтэй**” байна

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас үзэхэд дараах ажлуудыг хийсэн байна.

- 2018 онд Хүүхэд залуучуудын тусгай цогцолборын эцэг эхийн хараа хяналтаас гарсан, гэр оронгүй 55 хүүхдийг “Хүн худалдаалах гэмт хэргийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвийн хүрээнд сургалтад хамруулав. Мөн гудамж талбай, зочид буудал, цахим орчинд биеэ үнэлдэг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий 46 хүнийг “Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургажээ.
- “Хүйсийн тэгш эрх төв” ТББ нь Төгс бүсгүй ТББ-ын захиалгаар 2019 онд улирал тутамд 2 удаа зорилтот бүлгийн 100 орчим охид, эмэгтэйчүүдэд хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, мэдээлэл өгөх зорилготой тус бүрийн 4 цагийн сургалтад сургагч багшаар ажилласан.
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар цэцэрлэг, ЕБС-д хэрэгжүүлэх “Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөр”-ийг батлуулж, 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийг сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд хэрэгжүүлэх бөгөөд ахуйн орчны аюулгүй байдал, нийгмийн орчны аюулгүй байдал, байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл, хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл гэсэн 4 бүлэг агуулгын хүрээнд орж байна. Үүнээс нийгмийн орчны

<sup>22</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.5 дахь заалт

<sup>23</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.5.1 дэх заалт

аюулгүй байдал бүлэгт гэр, сургууль болон олон хүнтэй газар тохиолдож болох аюул, ослыг мэдэх, үл таних хүн, бусдын нөлөөнд автахгүй байх, гэмт халдлага хүчирхийлэлтэй холбогдох тохиолдлын талаар мэдээллийг судлах зэрэг агуулга тусгасан.

- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Монгол HD, NTV зэрэг телевизүүдээр хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой мэдээ мэдээллийг ЦЕГ болон холбогдох бусад байгууллагаас өгч, урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг тогтмол хийжээ.
- ЭКПАТ ТББ -аас Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн захын хороод болон МСҮТ-ийн дотуур байранд амьдардаг шилжин суурьшсан, эмзэг бүлгийн, бэлгийн мөлжлөг, хүний наймаа, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах шаардлагатай өсвөр насны 25 охидыг хамруулж, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж байна.
- 2019 онд МҮИС-ийн 15 оюутныг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэсэн.
- ГХЯ болон Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын хөтлөн явуулдаг цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд орчин үеийн мэдээ мэдээлэл, урьдчилан сэргийлэх агуулга бүхий богино хэмжээний шторк, контентыг тогтмол хүргэсэн.
- 2020 оны 04 дүгээр сараас нийгмийн сүлжээгээр хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий 4 төрлийн сурталчилгааг цахим сүлжээгээр түгээж, 871,578 иргэнд хүргэсэн.
- “Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөр”-ийг сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд:
  - Ахуйн орчны аюулгүй байдал,
  - Нийгмийн орчны аюулгүй байдал,
  - Байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл,
  - Хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл гэсэн 4 бүлэг агуулгын хүрээнд орж байна.
- “ЕБС-ийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэх “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж” гарын авлагыг боловсруулж, “Цахим сургалт” зохион байгуулсан.
- Цэцэрлэг, сургуулийн насны хүүхэд эрсдэлд өртөх нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд цэцэрлэг, сургууль, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн хариуцлагыг тодорхой болгох, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр хамтын ажиллагааг сайжруулах шаардлага үүссэнтэй холбоотойгоор “Цэцэрлэг, ЕБС-ийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг баталсан бөгөөд хэрэгжилтийг ЕБС бүр ханган ажиллаж байна.
- Номын сангуудад “Гэмт хэрэг, зөрчил, урьдчилан сэргийлэх ажлын талаарх хүн амын ойлголт, хандлага” судалгааны тайлан болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий тараах материалыг их, дээд, ЕБС-ийн номын санд тараасан.
- Цагдаагийн байгууллагаас хүн худалдаалах, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарын авлага 9, зурагт хуудас 40,

санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж 20, нийт 4047 ширхгийг, нисэх буудал болон олон улсын чанартай хилийн боомтууд, төмөр зам, автобусны буудал, томоохон худалдаа үйлчилгээний иргэд, олон нийтэд тарааж сурталчилсан.

- “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр “Not in my city” /Миний хотод биш/ нөлөөллийн аяны хүрээнд хийгдсэн 3 төрлийн видео шторкийг Цагдаагийн ерөнхий газрын цахим хаягаар олон нийтийн цахим сүлжээнд 3 удаа байршуулж, “Амрыг эрье” нэвтрүүлгээр 2 удаа цацсан.
- Цагдаагийн байгууллагаас хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 21 удаа, 96 минутын хугацаатай нэвтрүүлэг, ярилцлага, сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээллээр 31 удаагийн давталттайгаар иргэд, олон нийтэд хүргэжээ. Радиоогоор 1 удаа, 10 минутын хугацаатай ухуулга, сурталчилгааг 2 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлсэн. Цахим хуудсаар: Нийт 599 мэдээ, мэдээллийг цахим хуудаснууд болон олон нийтийн сүлжээнд байршуулсныг давхардсан тоогоор 2.037.288 иргэн үзэж, сэтгэгдэл бичжээ.
- Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг бүхий богино хэмжээний нэвтрүүлэг, шторк бэлтгэн хүргүүлсэн.
- 96 их, дээд болон ЕБС-ийн нийгмийн ажилтнуудтай сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн талаар бодит кейс дээр тулгуурласан хэлэлцүүлэг хийж, сурагчдад мэдээлэл өгсөн. Нийт 915 санамжийг сургуулийн мэдээллийн самбарт байрлуулсан байна.
- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг тарааж, зөвлөгөө өгсөн.
- “Гэр бүлийн радио 104.5” хамтран 5 удаагийн 2 минутын хугацаатай ухуулга, сурталчилгааг 15 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж ажилласан байна.
- ЕБС-ийн Сурагчдыг хууль, эрх зүйн мэдлэг, чадвартай болгох, гэмт хэрэг, хүчирхийлэл, тэдгээрийн хор уршгийг таньж мэдэх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сурагчдын сайн дурын клубүүдийг ажиллуулж, мэдээлэл сурталчилгааг тогтмол өгсөн.
- Дунд, ахлах ангийн нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрт “Хувь хүн ба нийгэм”, “Нийгмийн харилцаа, хувь хүн” “Хувь хүн ба соёл”, “Хүний эрх ба хууль” сэдвүүдийг багтаан хичээл орж байна.

Цахим судалгааны дүнгээс харахад нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 48 хувь нь хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, ойрын хүмүүсээ хамгаалах талаар ямар нэг мэдээ мэдээлэл сонсож, уншиж байсан гэж хариулжээ. Иргэд энэ төрлийн мэдээллийг ихэвчлэн интернэт орчин, телевиз, радиоогоос, хэвлэмэл материалаас авдаг бол цөөн тохиолдолд хичээлээс, сургалт семинарт хамрагдаж авч байсан байна. Түүнчлэн хүүхэд хамгааллын 108 утсанд хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой дуудлагын тоо нэмэгдсэн, брошур дээрх утасны дагуу холбогдож гэмт хэргийг таслан зогсоосон гэх мэт үр дүнгээс холбогдох байгууллагын төлөөллүүд дурдсан.

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх иргэд өөрийгөө болон бусдыг хамгаалах чиглэлийн нөлөөллийн ажлууд хийгдсэн төдийгүй тухайн ажлыг үр дүнгээр дуудлагын тоо нэмэгдсэн, брошур гэх мэт хэвлэмэл материалын тусламжтай энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалсан зэрэг үр дүн гарсан байна.

**Үйл ажиллагаа 5.2:**<sup>24</sup> Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхэд, залуучуудад зориулсан сургалт явуулах, сургагч багш нарыг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэн сургууль, хүүхдийн асрамжийн төвүүдэд сургагч багш нарыг бэлтгэх үйл ажиллагаа “**тодорхой үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад

- ХНХЯ нь “Хүүхдэд нийгмийн харилцааны чадвар олгох арга зүй” сэдэвт цуврал сургалтыг зохион байгуулж, тус сургалтад асрамжийн төвийн 75 багш оролцсон байна. Үүнд:
  - Өнөр бүл хүүхдийн төвд 3 удаагийн сургалт хийж нийт 60 багш,
  - Вербист асрамжийн төвд 2 удаагийн сургалт зохион байгуулан 15 багш оролцсон.
- ХНХЯ-наас БНСУ-ын Жендерийн тэгш эрх, гэр бүлийн яамтай хамтран “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-ийн хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх” төслийн хүрээнд “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчдод туслалцаа үзүүлэх” сэдэвт 19 удаагийн сургалтаар сургагч багш нарыг бэлдэж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн.
- “Хүмүүжлийн эерэг арга”-ын сургагч багшаар ЕБС-ын 353 бага ангийн багшийг бэлтгэсэн.
- Хуульчдад зориулсан сургагч багш бэлдэх ажлыг хүрээнд “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа-Хохирогчтой төвтэй хандлага” сургалтыг зохион байгуулсан “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн агуулга, үзэл баримтлал”, “Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг”, “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг” сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан байна.
- Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Мөрөөдлийн шүхэр” мэдээллийн аяныг 21 хоногийн хугацаанд орон даяар зохион байгууллаа. Аяны гол зорилго нь Улаанбаатар ба Дархан хотод оршин суудаг, эрсдэлд өртөх магадлал өндөртэй 18–27 насны залуу охид, эмэгтэйчүүд, тэдний эцэг эхчүүдэд мэдээлэл олгох замаар хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх юм.
- Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд мэдлэг мэдээлэл өгөх, хохирогчдын буруутгах хандлагыг өөрчлөх зорилгоор ХХГХ-ийн тухай бодит хохирогчид тохиолдсон явдал дээр үндэслэсэн баримтат кино /Даван туулагчийн түүх/ хийсэн.
- Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар байгууллагын 90 албан хаагчид цахим сургалт зохион байгуулсан.
- Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх Итгэлийн утас 1800-1903-ийг сурталчилсан 7000 ширхэг балыг хэвлүүлсэн.
- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх анхан шатны ойлголт, мэдээлэл өгөх зорилго бүхий 4 цагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан.

<sup>24</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.5.2 дахь заалт

Чанарын судалгааны үр дүнгээс харахад олон улсын, төрийн, төрийн бус байгууллагуудын зүгээс хил, гааль, шүүх, прокурор зэрэг хууль сахиулах байгууллагуудаас гадна өмгөөлөгч, сэтгүүлчид, нисэх гэх мэт холбогдох байгууллагуудын албан хаагчдад зориулсан сургалтыг жил бүр төлөвлөн зохион байгуулдаг байна. Сургалтууд нь байгууллагын бүх ажилтанд, эсхүл байгууллагын тодорхой тооны төлөөллүүдийг хамруулах гэх мэтээр ялгаатай зохион байгуулагддаг. Байгууллагын тодорхой төлөөллүүдэд зориулсан сургалтын хувьд байгууллага төлөөлөн сургалтад хамрагдсан албан хаагчид сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвараа цааш байгууллага дотроо түгээдэг эсэхийг тогтооход хүндрэлтэй байдаг гэж сургалт зохион байгуулагч тал үзсэн байна.

**Үйл ажиллагаа 5.3:**<sup>25</sup> Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бүх шатны боловсролын байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн байгууллага, төрийн бус байгууллагын ажилтнуудыг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах, хүүхдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэхийн тулд эцэг, эхтэй хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээнд “**үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад

- Монголын аялал жуулчлалын холбооноос 2019 оны 08 дугаар сарын байдлаар нийт 150 гаруй аж ахуйн нэгжид аялал жуулчлалын чиглэлээр шинээр гэрчилгээ олгосон, 152 ААНБ гэрчилгээ сунгуулсан бөгөөд гэрчилгээ олгох явцдаа Хүн худалдаалахтай тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх чиглэлээр чиглэл өгч ажилласан;
- ХЗДХЯ Худалдаа, хөгжлийн банкны 300 ажилчдад 2019 оны 06 дугаар сарын 08-ний өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн талаарх мэдлэг, ойлголт өгөх сургалт хийсэн;
- ГХУСАЗЗАА, ГБХЗХГ-тай хамтран “Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд нийгмийн хамгааллын салбарын оролцоо” сэдэвт зөвлөгөөнийг 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 80 нийгмийн ажилтан хамрагдаж хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээтэй холбоотой шинэ мэдлэг, ур чадварт суралцсан;
- ХЗДХЯ Хүн худалдаалахтай тэмцэх дэлхийн өдөр “Хөх зүрхний аян”-ын хүрээнд 12 их, дээд сургуулийн 674 оюутан залуус, нийслэлийн 3 дүүргийн ЕБС-ийн ахлах ангийн 130 багшид энэ төрлийн гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтад хамруулсан;
- Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран ГХЯ-ны Консулын газрын 40 ажилтанд хүн худалдаалахын хохирогчдод туслалцаа үзүүлэх арга барил эзэмшүүлэх сургалтыг 2018, 2019 онуудад зохион байгуулсан. Сургалтыг хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр мэргэшсэн Украин улсын сургагч багш Ханна Антонова удирдан явуулсан;

<sup>25</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.5.3 дахь заалт



- Цагдаа, хил хамгаалах байгууллагын албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, хохирогч төвтэй арга барим ашиглах чиглэлээр сургалтууд зохион байгуулсан;
- Прокурор, цагдаагийн албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалтууд зохион байгуулсан;
- Орон нутгийн цагдаа нарт хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн мөрдөх арга зүйн талаар сургалтууд зохион байгуулсан;
- Гадаад улсад суух дипломат төлөөлөгчийн газрын алан хаагчдад энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдлэг мэдээлэл олгох чиглэлээр сургалтууд зохион байгуулсан;
- Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор, хүүхдийн асрамж халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтууд зохион байгуулсан;
- Сургууль, дотуур байрын орчинд суралцагчдыг аливаа болзошгүй эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд сургуулийн удирдах ажилтны чадавхыг бэхжүүлэх, арга зүйгээр хангах сургалтыг зохион байгуулсан;
- Сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулахтай холбогдуулан танхимын сургалтыг хэвийн хэмжээнд үргэлжлүүлэхийн тулд “Хүүхэдтэй боловсрол” нийгэм, сэтгэл зүйн нөлөөллийн 2 сарын аяныг гэр бүлд түшиглэн зохион байгуулсан;
- Нийгмийн ажилтнуудад “Ковид-19 цар тахлын үед иргэдийг болзошгүй эрсдэл хүчирхийлэл, хүний наймааны гэмт хэргээс ангид байлгахын тулд “Иргэдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, иргэдийн сэтгэл зүйн дархлааг дэмжих” сэдэвт сургалтыг зохион байгуулсан;
- “Хүмүүжлийн эерэг арга”-ын сургагч багшаар ЕБС-ын 353 бага ангийн багшийг бэлтгэж, “Хүмүүжлийн эерэг арга” сургалтыг эцэх эх, асран хамгаалагч, багш нарт зохион байгуулжээ;
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдаж буй 413 хүүхдийн 425 эцэг, эхийг “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга”-ын сургалт, зөвлөгөөнд хамрагдсан;
- “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага” “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” өгүүллийг сэтгүүлүүдэд нийтлүүлэв Эцэг, эх, асран хамгаалагч нарт зохих мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан;
- Энэ төрлийн гэмт хэргийн талаар болон хохирогчдын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхэд анхаарах асуудал сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулсан;
- Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр хуульч, өмгөөлөгчдөд зориулсан сургалт зохион байгуулсан;
- Хамгаалах байрны ажилтан, албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын онцлог, тэдэнд үзүүлэх үйлчилгээний тусгай шаардлагын талаар сургалтыг зохион байгуулж, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлсэн байна..

Чанарын судалгааны үр дүнгээс харахад холбогдох бүх байгууллагын албан хаагчид хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой мэдлэг мэдээлэл олгох сургалтад хамрагдаж байгаа бөгөөд энэ төрлийн ажил тогтворжих хандлагатай байгаа талаар дурдсан. Мөн хууль хүчний болон бусад байгууллагын анхан шатанд ажиллаж байгаа албан хаагчдын хувьд

хохирогч төвтэй хандлага хангалттай төлөвшөөгүй байгаа тул энэ чиглэлийн ажлыг илүүтэй хийх хэрэгтэй гэж холбогдох байгууллагын төлөөллүүд үзэж байна.

Ийнхүү хөтөлбөрийн хүрээнд байгууллагуудын албан хаагчдад мэдлэг мэдээлэл түгээх, тэднийг чадваржуулах ажил хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдох байгууллагуудад орж, сургалт мэдээлэл өгөх дараа дараагийн ажлыг холбогдох байгууллагууд төлөвлөж ажиллаж байх тул дээрх үйл ажиллагааг “үр дүнтэй” гэж үзэж байна.

**Үйл ажиллагаа 5.4:**<sup>26</sup> Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулах үйл ажиллагааны хүрээнд **“эрчимжүүлэх шаардлагатай”** байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад хувийн хэвшлийн байгууллагуудын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүрэгт үй ажиллагаа явуулдаг зочид буудал, баар, ресторан, саун, массажны газрын 50 ажилтныг (захирал, менежер, зохион байгуулагч г:м) хамруулан 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдөр “Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөр, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь, Хөдөлмөрийн харилцааны талаар ажил олгогчийн анхаарах асуудал” сэдэвт сургалтыг Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай хамтран зохион байгуулсан;
- Зочид буудал, ресторан, караоке, баар, саун массажны үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийх ажлын хүрээнд нийт 49 хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 184 газрыг шалгаж, холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцсон;
- Монголын Аялал жуулчлалын холбооноос 2020 онд шинээр гэрчилгээ авсан 80 ААНБ гэрчилгээ сунгуулсан, 280 ААНБ-д зориулан гэмт хэргийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад албан байгууллагуудын хувьд хөдөлмөрийн мөлжлөгийн асуудал хамгийн түгээмэл байх хандлагатай байдаг бөгөөд энэ чиглэлээр байгууллага болон албан хаагчдад тодорхой мэдээлэл түгээх сургалтыг орж байна хэмээжээ. Мөн хөдөлмөрийн, бэлгийн мөлжлөг үйлдэгдэх магадлал өндөртэй үйл ажиллагаа эрхэлдэг салбар болох зочид буудал, саун, массажны үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохих тусгай зөвшөөрлийг авдаг байсан. Гэвч тусгай зөвшөөрөл авахыг 2021 онд болиулсантай холбоотой энэ төрлийн байгууллагуудыг хянах ажил зогссон гэж холбогдох байгууллагын төлөөллүүд үзэж байна.

Ийнхүү хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгжүүдийн хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оруулах ажил тодорхой хэмжээнд хийгдсэн боловч

<sup>26</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.5.4 дахь заалт

цаашид илүүтэй анхаарч ажиллах хэрэгцээ байна гэж үзэж буй тул дээрх үйл ажиллагааг “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлсэн.

**Үйл ажиллагаа 6:**<sup>27</sup> Бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зорилтот бүлгийг тодорхойлж, тэдгээрт чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд “**тодорхой үр дүнтэй**” байна.

**Үйл ажиллагаа 6.1:**<sup>28</sup> Жил тутам зорилтот бүлгийн 20–оос доошгүй иргэнийг МСҮТ-д суралцуулан мэргэжил эзэмшүүлэх, ажлын байраар хангах үйл ажиллагааны хүрээнд “**үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харвал зорилтот бүлгийн иргэдэд мэргэжил, боловсролын үйлчилгээг дараах байдлаар хүргэсэн байна.

- Хорих ял эдэлж байгаа болон суллагдсан 200 залуучуудад нийгмийн үйлчилгээг цогцоор үзүүлэн ажиллаж 10 залууг байнгын ажлын байранд 50 залууг боловсролын үйлчилгээнд холбон зуучилсан.
- Хүн худалдаалах гэмт хэргийн 10 хохирогчийг мэргэжлийн сургалтад хамруулсан.

Чанарын судалгааны үр дүнгээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод мэргэжлийн сургалт орох, мэргэшүүлэх ажлыг төрийн, төрийн бус байгууллагууд хамтран үр дүнг голчлон анхаарч хийдэг нь харагдаж байна. Нэг хүнд мэргэжил олгохдоо тухайн хүний суралцах хугацааны урсгал зардал, ажлын байраа олох, ажлын байранд гараад орлого олж эхлэх хүртэл нь хохирогч болон хохирогчийн ар гэрт дэмжлэг үзүүлж, хэвийн амьдралдаа ортол нь үйлчилгээ үзүүлэг тухай холбогдох байгууллагын төлөөлөл дурдсан. Энэ төрлийн гэмт хэрэг шийдвэрлэгдэх болон хохирогч нөхөн сэргээгдэх хугацаа нь харьцангуй урт байдагтай холбоотой хурдан хугацааны үр дүн гардаггүйг анхаарах хэрэгтэй.

ШШГЕГ нь өөрийн МСҮТ-тэй бөгөөд тухайн төвд хорих ял шийтгүүлсэн иргэд мэргэжил эзэмшиж, хорих ял дуусаж суллагдахад нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас ажилд зуучилж өгдөг байна.

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэдэд үйлчилгээ үзүүлж хэвийн амьдралдаа ороход нь туслалцаа үзүүлж, хохирогч бүр дээр анхаарч ажиллаж байгаа дээрх үйл ажиллагааг “үр дүнтэй” гэж үзэж байна.

**Үйл ажиллагаа 6.2:**<sup>29</sup> Оролцоонд суурилсан бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, семинар, арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд “**тодорхой үр дүнтэй**” байна.

Дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэжээ.

---

<sup>27</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.6 дахь заалт

<sup>28</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.6.1 дэхь заалт

<sup>29</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.6.2 дахь заалт

- Хүн худалдаалах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг /паспортын хавчуурга/ бэлтгэн 120.000 ширхгийг хэвлүүлж хилээр нэвтэрч буй иргэдэд тогтмол тараах ажлыг зохион байгуулсан;
- ХЗДХЯ, ЦЕГ, ЗТХЯ, ГХУСАЗЗАА, БОАЖЯ: -Орон нутгийн тээврийн хэрэгслийн /галт тэрэг/ сурталчилгааны дэлгэцээр хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий нэвтрүүлэг, видео сурталчилгааг өдөр бүр 44 вагоны 396 бүхээгт 3 төрлийн шторкийг 10 удаагийн давтамжтайгаар нийт давхардсан тоогоор 15.840 хүнд хүргэж энэ төрлийн гэмт хэргийн мэдлэг, ойлголт өгч, сэрэмжлүүлсэн;
- Монголын аялал жуулчлалын холбооноос 150 аж ахуйн нэгжид аялал жуулчлалын чиглэлээр шинээр гэрчилгээ олгоходоо хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэл өгсөн;
- Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдсэн сэрэмжлүүлэг, видео мэдээллүүдийг нисэх онгоцны буудал болон олон улсын чанартай хилийн боомтууд, орон нутаг, олон улсын зорчигч тээврийн төв Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төмөр замын вокзал, хүлээлгийн танхим зэрэг үйлчилгээний байгууллагуудын заал, гудамж талбайд байрлах сурталчилгааны дэлгэцээр дамжуулан өдөрт 5-20 удаагийн давтамжтайгаар олон нийтэд түгээсэн, “Автобус нэгдэл” ХХК-тай хамтран хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс орон нутаг болон олон улсын зорчигч тээврийн төвийн 100 автобусны дэлгэцээр сэрэмжлүүлэг богино хэмжээний видео сурталчилгааг явуулжээ;
- Олон улсын уралдаан тэмцээн, соёлын бусад арга хэмжээнд оролцохоор итгэмжлэхээр гадаад улсад зорчиж байгаа 412 хүүхдэд хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, Монгол Улсаас гадаад улсад суугаа ЭСЯ, Консулын газрын хаяг, байршил, холбогдох утасны дугаартай мэдээлэл, сэрэмжлүүлэг бүхий гадаад паспортын хавчуурга /гарын авлага/-ыг тараасан;
- Улсын хилийн боомт, Төмөр зам, Автозам, Нисэх онгоцны буудлуудад гарын авлага боловсруулж тараах, байрлуулах, шторк, видео контент нэвтрүүлэх ажлыг Тээврийн цагдаагийн алба болон Дундговь, Дорнод, Сэлэнгэ, Өмнөговь, Баян-Өлгий, Ховд зэрэг аймгуудад тасралтгүй зохион байгуулж байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад 2017-2020 он хүртэл АНБАУНД ТББ–аас хил хамгаалах байгууллагатай хамтран “Замын-Үүд” боомт дээр дамжин өнгөрөх ажиглалт буюу бодит урьдчилан сэргийлэх ажлыг хийсэн байна. Тухайн үйл ажиллагаа нь хохирогчийг хил дээр таньж илрүүлэх зорилготой хийгдэж байсан тул нэг талаараа хохирогчийг илрүүлэх, нөгөө талаараа хилийн боомт дээр ажилладаг албан хаагчдыг чадваржуулахад томоохон нөлөө үзүүлсэн байна. Түүнчлэн АНУ–аас хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд хүрэлцэн ирж оролцоонд суурилсан сургалт зохион байгуулсан нь үр дүнтэй байсан талаар холбогдох байгууллагуудын төлөөллүүд дурдсан. Гадаад улсад туршлага судлах сургалтууд нь энэ чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдыг чадваржуулахад томоохон дэмжлэг болж байгаа ч албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах асуудал хамгийн хүндрэлтэй байдаг байна. Жишээ нь ЦЕГ–аас хөтөлбөрийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг албан хаагчид 5 удаа туршлага солилцох сургалтад гадаад улсад хамрагдсан байна. Гэвч тухайн сургалтуудад хамрагдсан хүмүүсээс одоогийн байдлаар хүн худалдаалах гэмт

хэрэгтэй тэмцэх чиглэлээрээ ажиллаж байгаа албан хаагч байхгүй гэдгийг байгууллагын төлөөлөл дурдсан байна.

Ийнхүү оролцоонд суурилсан сургалтын үйл ажиллагаа хийгдсэн боловч ажилтан албан, хаагчдын ажлын байрны тогтвортой байдалд онцгой анхаарах шаардлагатай тул дээрх үйл ажиллагааг “тодорхой үр дүнтэй” гэж үзэж байна.

**Үйл ажиллагаа 7:**<sup>30</sup> Хөдөлмөрийн мөлжлөгийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээ зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд “**тодорхой үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад дээрх үйл ажиллагааны хүрээнд 2018 онд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөрийн хяналтын байцаагчийн эрх, үүргийг тогтоосон. Мөн хүүхэд тэвчишгүй хөдөлмөр эрхэлж буй салбарууд болон хөдөлмөрийн мөлжлөг үйлдэгдэх магадлал хамгийн өндөр салбаруудын байгууллагуудад хяналт шалгалт хийж ажилласан байна. Тухайлбал, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулалтай ААНБ, гадаадаас иргэдийн урьж авч ирж байгаа байгууллагуудад хяналт тавьж гадаадаас ирсэн иргэдийн хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлыг хийж, хөдөлмөрийн мөлжлөгт өртөж байсан 3 гадаад иргэнийг тогтоож, эрх зүйн туслалцаа үзүүлэн эх оронд нь буцаасан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (хуучин нэрээр)-аас “Насанд хүрээгүй хүүхэд ажиллуулахыг хориглосон ажлын байр”-ны жагсаалтын дагуу тандалт судалгаа хийхэд албан бус секторт нийт 495 хүүхэд хөдөлмөр эрхэлж байна. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай” 182 дугаар конвенцод заасан хэлбэрүүдэд нийт 27 хүүхэд тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байгааг илрүүлжээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу “Хуулиа мөрдье-21” арга хэмжээний хүрээнд “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Хүн худалдаалахтай тэмцэх тухай”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулиуд болон түүнтэй нийцүүлэн гарсан хууль, эрх зүйн актын хэрэгжилтийг шалгах, зөрчил дутагдлыг арилгах зорилгоор Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчид 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ны хооронд нийт 2,372 ААНБ-д хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аяны хүрээнд 16 байгууллагын 200 ажилтанд олгогдоогүй байсан илүү цагийн нэмэгдэл хөлс болох 31,400.0 мянган төгрөгийг нөхөн олгуулахаар улсын ахлах байцаагчийн акт гаргасан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019 оны 01/41 дугаар удирдамжаар “Морь унаач хүүхдийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамж”-ыг батлуулан аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газруудад хүргүүлсэн. Үндэсний их баяр наадамтай холбогдуулан унаач хүүхдийн эрүүл мэнд, амь нас эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлыг бүрэн хангах зорилгоор хяналт тавьж ажиллах, Үндэсний морин

<sup>30</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.7 дахь заалт

уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2018 стандартыг хэрэгжүүлж ажиллах талаар 7 заалт бүхий улсын ахлах байцаагчийн 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01-06-078/117 дугаартай зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Зөвлөмжийг мэргэжлийн хяналтын вэбсайт хуудсанд байрлуулж 546 хүн үзэж, байгууллагын Фейсбүүк хуудсанд байршуулсан нь 4,400 хүнд хүрчээ.

Монголын Хуульчдын холбооны Хөдөлмөрийн эрх зүйн дэд хорооны чиглэл хариуцсан 2 алба хаагч 2018 оны 12 дүгээр сарын 12-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд зохион байгуулсан “Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцын нэмэлт протоколын судалгаа” уулзалт, ярилцлагад оролцож санал солилцсон. Монголын Хуульчдын холбооны Хөдөлмөрийн эрх зүйн дэд хороо Европын холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр “Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын “Албадан хөдөлмөрийн тухай” 29 дүгээр протоколд Монгол Улс нэгдэн орсноор гарах үр дагавар хэрэгцээ шаардлагын талаар судалгаа”-г 2019 онд хийж гүйцэтгэсэн.

Аймаг, нийслэлийн хэмжээнд Үндэсний их баяр наадамд 13,519 хүүхдийн мэдээллийг ABLE мэдээллийн системд бүртгэж, давхардсан тоогоор 30,990 хүүхдэд “Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага MNS 6264:2018” стандартын дагуу хяналтыг зохион байгуулсан байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад 2021 онд хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэн найруулагдаж, хүнд илүү ээлтэй болсон тухай, түүнчлэн хүний хөдөлмөрийн мөлжиж байсан уламжлалт ажлууд болох айлд мал маллах, хамаатны айлд амралтаараа байж хүүхэд харах, ажил хийх, морь унах зэрэг ажлуудыг хүний эрхийн суурь зарчмын зөрчсөн үйл ажиллагаа юм байна гэж бүх нийтээрээ хардаг болсон нь энэ салбарт гарсан хамгийн том дэвшил юм. Хэдий дэвшил гарч байгаа ч цаашид энэ салбарт хийх зүйлс чамгүй их байгаа талаар дурдсан юм. Жишээ нь унаач хүүхдийн асуудалд илүү анхаарч бага насны хүүхдийг морь унуулж ямар нэг байдлаар хохирол үүсгэвэл эрүүгийн хариуцлага авах хүртэл арга хэмжээг авч энэ төрлийн хөдөлмөрийн мөлжлөгийг таслан зогсоох хэрэгтэй байна гэжээ.

Ийнхүү хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэж, холбогдох бусад дүрэм журам, стандартууд гарч энэ төрлийн асуудалд иргэд олон нийт илүүтэй анхаарах болсон тул дээрх үйл ажиллагааг “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэв.

**Үйл ажиллагаа 8:**<sup>31</sup> Хүний эд эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний хүрээнд “**тодорхой үр дүнтэй**” байна.

**Үйл ажиллагаа 8.1:**<sup>32</sup> Хил хяналтын болон эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах үйл ажиллагааны хүрээнд “**үр дүнтэй**” байна.

---

<sup>31</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.8 дахь заалт

<sup>32</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.8.1 дэх заалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажилладаг холбогдох байгууллагын албан хаагчдын сургалтад хамруулсан байх бөгөөд тухайн сургалтуудад хүний эд эрхтний наймаатай холбоотой агуулгыг багтаасан байдаг байна. Жишээ нь ГХУСАЗЗ, ГБХЗХГ-тай хамтран “Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд нийгмийн хамгааллын салбарын оролцоо” сэдэвт зөвлөгөөнийг 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус зөвлөгөөнд ГБХЗХГ-ын 80 нийгмийн ажилтан хамрагдсан. “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийн хүрээнд шүүх, прокурор, цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтын гарын авлагыг тухайн байгууллагуудын саналыг тусган боловсруулж, 40 сургагч багш бэлтгэн нийслэлд 3 удаагийн, 7 аймагт 9 удаагийн сургалт зохион байгуулж 21 аймаг, нийслэлийн шүүх, прокурор, цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын байгууллагын нийт 353 албан хаагчийг хамруулжээ. Дээрх сургалтад хамрагдсан албан хаагчаар цагдаагийн байгууллага дотооддоо 28 удаагийн сургалт зохион байгуулж 1,392 албан хаагчийг хамруулсан. Түүнчлэн 9 дүүрэг, 21 аймгийн ГБХЗХГ, түр хамгаалах байр, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, ГССҮТ болон СБД-ийн ЭМТ-ийн 100 гаруй эмч, сэтгэл зүйч нийгмийн ажилтнуудад мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулсан. 2019 оны 03-р сарын 19-21-д Сэлэнгэ аймагт Австралийн хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран “Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн байгууллагын оролцоо” сэдэвт сургалтын зохион байгуулсан. “Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр Монгол Улс болон БНХАУ-ын хамтын ажиллагааг бэхжүүлэх” төслийн хүрээнд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, хамгаалах, туслалцаа үзүүлэх талаар хамтарсан сургалтыг Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Шивээхүрэн боомтод, Дархан-Уул аймагт, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сайншанд суманд тус тус зохион байгуулсан.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад холбогдох байгууллагын албан хаагчид өмнө нь хүн худалдаалах гэмт хэрэгт зөвхөн бэлгийн мөлжлөгийг хамааруулж ойлгодог байсан бол сургалт мэдээллийн ажил хийснээр хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь маш өргөн ойлголтыг агуулсан байдгийн мэддэг болсон гэж үзэж байна. Ийнхүү бэлгийн мөлжлөгөөс гадна хөдөлмөрийн мөлжлөг, хүний эд эрхний наймаа гэх мэт нь энэ төрлийн гэмт хэрэгт хамаардаг гэдгийг мэддэг болсон тул илүү сонор сэрэмжтэй байх болсон тухай холбогдох байгууллагын төлөөллүүд дурдсан байна.

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох сургалтыг хил гааль, эрүүл мэндийн байгууллагын ажилтан албан хаагчдад орж мэдлэгийг нь нэмэгдүүлж байгаа тул дээрх үйл ажиллагааг “үр дүнтэй” гэж үзлээ.

**Үйл ажиллагаа 8.2:**<sup>33</sup> Хүний эд эрхтэн, ялангуяа эхэс, ураг худалдах, худалдах зорилгоор тээх гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох чиглэлээр олон улсын туршлагыг судлах, мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг “**тодорхой үр дүнтэй**” гэж үзэж байна.

---

<sup>33</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.8.2 дахь заалт

2018 онд ХЗДХЯ, ЦЕГ Дэд зөвлөл: Хүний эд эрхтэн авах зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох чиглэлээр Тайланд Улсын Бангкок, БНСУ-ын Чезү хотод зохион байгуулагдсан 3 удаагийн сургалтад Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны 3 мөрдөгчийг хамруулж, гадаад орны сайн туршлагыг судалсан. 2019 онд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны зохицуулах албаны дарга Монгол Улсын гавьяат хүний их эмч П.Батчулуун “Тархины үхэлтэй донороос эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг өргөжүүлэх нь” сэдвээр 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Эрүүгийн цагдаагийн албаны алба хаагчдад дараах сургалтыг зохион байгуулсан. Үүнд:

- Монгол Улсын Донорын тухай хууль,
- Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний тухай,
- Монгол Улсын өвчлөлийн байдал, ЭШС эмчилгээний тухай,
- Донорын тухай ойлголт,
- Аль улсын загвар Монгол Улсад илүү тохирох в
- Яагаад Истанбулын тунхаглал батлагдан гарах болсон бэ
- Хийсэн ажил болон Шийдвэрлэх асуудал зэрэг сэдвээр сургалт орсон.

2019 онд ЦЕГ: Хүн худалдаалахтай тэмцэх тасгийн алба хаагчдын үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай, гэмт хэрэг илрүүлэхтэй холбоотой техник, тоног төхөөрөмжийн судалгаа, үнийн саналыг харьцуулан гаргах ажлыг 2019 оны 4 дүгээр улиралд хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгагдсан. Ковид-19 цар тахалтай холбоотой 2020, 2021 онуудад олон улсын туршлага судлах ажил түр хугацаагаар хойшилсон тухай тайланд дурджээ.

**Үйл ажиллагаа 8.3:**<sup>34</sup> Хилийн хяналтын байгууллагуудыг орчин үеийн техник хэрэгслээр хангах үйл ажиллагаа “**үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хилээр нэвтэрч буй зорчигчдыг хүний биометр мэдээллээр бүртгэх ажилд 250 сая төгрөгийн санхүүжилтээр Чингис хаан боомтод шаардлагатай техник хэрэгслийг худалдан авч, суурилуулсан байна. Мөн хилийн Цагааннуур боомтод 74 сая төгрөгийн үнэ бүхий Дохиолол хяналт хамгаалалтын систем, Буянт-Ухаа, Алтанбулаг, Сүхбаатар, Замын-Үүд боомтод хяналтын камерын нэгдсэн систем нэвтрүүлсэн. Улсын хилээр нэвтрэх гадаадын иргэний биеийн давхцахгүй өгөгдлийг авах ажиллагаанд шаардлагатай ухаалаг цахим технологийг хилийн Алтанбулаг боомтын 24 кабинд суурилуулах, хилийн 22 боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод мөрдөх журмыг сахиулах, хууль бус үйлдлийг илрүүлэх, баримтжуулах зорилгоор хилийн боомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчид болон тусгай томилгоот бүлгийг 120 ширхэг энгэрийн камераар хангах ажилд нийт 299 сая төгрөг зарцуулсан гэх зэргээр хүн худалдаалахаас урьдчилан сэргийлж, хилийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хэрэгжүүлсэн байна.

<sup>34</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.8.3 дахь заалт



**Үйл ажиллагаа 8.4:**<sup>35</sup> Зорилтот бүлгийн иргэдийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах, энэ чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээнд **“тодорхой үр дүнтэй”** байна.

Хөтөлбөрийн тайлангаас харахад Улаанбаатар хотын хэмжээнд 9 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион явуулж саун, массаж ажиллуулах нэрээр халхавчилж бусдыг зохион байгуулалттай биеийг нь үнэлүүлж байсан давхардсан тоогоор нийт 11 газрын 33 удаагийн хууль бус үйлдлийг таслан зогсоож массажист нэрээр, караоке бааранд ширээний хүүхэн нэрээр биеэ үнэлж байсан 541 иргэнийг тогтоож цахим санд бүртгэж, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулан, илэрсэн өвчинд үнэ төлбөргүй эмчилгээ хийлгэж харьяа дүүрэг дэх Цагдаагийн хэлтэст хүлээлгэн өгч холбогдох шалгалтын ажиллагааг хийлгүүлсэн байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэдэд эрүүл мэндийн үзлэг оношилгоо үйлчилгээнд хамруулахад тодорхой хүндрэлүүд гардаг байна. Жишээ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлнэ гэдэг боловч заавал эрүүл мэндийн даатгал төлсөн байх ёстой гэдэг шаардлагыг тавьдаг гэх мэт хүндрэлтэй асуудал үүсдэг тухай холбогдох байгууллагуудын төлөөлөл дурдсан байна.

Ийнхүү хүний наймааны хохирогч болсон 188 иргэнд эрүүл мэндийн үзлэг үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн байх буюу зарим үед зохицуулалтын асуудал гардаг гэх тул дээрх үйл ажиллагааг “тодорхой үр дүнтэй” гэж үнэллээ.

**Үйл ажиллагаа 9:**<sup>36</sup> Хүүхэд хууль бусаар үрчлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хүүхэд үрчлэлт, гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах ажилд тавих хяналтыг сайжруулах үйл ажиллагаа **“үр дүнтэй”** байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дурдсанаар хүүхэд үрчлэлттэй холбоотой “Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай” Гаагийн конвенцод 1998 онд нэгдэн орсноос хойш 273 хүүхдийг 17 орны иргэн, гэр бүлд үрчлүүлсэн. Үрчлэлтийн дараа хяналт тавих 2 ба 3 талт гэрээг “Хүүхдийн эрхийн тухай” конвенцын дагуу үрчлэгч эцэг эх, зуучлагч төрийн бус байгууллага болон ГИХГ хооронд байгуулж байна. Мөн дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

- АНУ-ын гэр бүлийн хүсэлтийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Н-г үрчлүүлж, 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Үрчлэлтийн дараа хяналт тавих 2 талт гэрээг байгуулсан.
- ХБНГУ -д үрчлэгдсэн 16, БНИУ -д үрчлэгдсэн 3, ИБУИНВУ-д үрчлэгдсэн 1, АНУ-д үрчлэгдсэн 6 хүүхдийн нийт 26 тайланг хүлээн авч мэдээллийн санд бүртгэсэн.
- 2020 онд үрчлэлтийн дараа хяналт тавих тайлан ирүүлээгүй 59 хүүхдийн жагсаалтыг гаргаж ГХЯ-д хүргүүлсэн.

<sup>35</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.8.4 дэх заалт

<sup>36</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.1.9 дэх заалт

- Монгол Улсын харьяат Э–г үрчлэх хүсэлт гаргасан БНИУХЯ-ын гэр бүлийн хүсэлтийг хүлээн авч 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр “Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журам”-ын дагуу ярилцлага хийсэн.
- Иргэний улсын бүртгэлийн газарт 2021 оны 11 сарын 15-ны байдлаар гадаадын иргэнд үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн нийт 11 бүртгэлийг хөтөлсөн. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд бүртгэгдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбоотой төрсний, гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн мэдээллийг холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлдэг.

Түүнчлэн Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/49 тоот тушаалаар баталсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ыг мөрдөн 130,330 хүүхэд нэвтэрснээс 15,421 хүүхэд итгэмжлэлээр, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүйгээр гадаад улсад зорчих гэж байсан 41 хүүхдийг хил нэвтрүүлэлгүй буцааж, улсын хил нэвтрээд буцаж ирээгүй хилийн чанадад үлдсэн 1,460 хүүхдийн бүртгэлийг хөтөлж, сар бүр ЦЕГ, ГБХЗХГ-т албан бичгээр хүргүүлсэн байна. Мөн тус журмын 2.1.4 дэх хэсэгт заасан “Олон улсын уралдаан, тэмцээн, урлаг соёлын бусад арга хэмжээнд оролцуулах бол хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагын /нэгжийн/ зөвшөөрөл” авах заалтын дагуу насанд хүрээгүй хүүхдийг хилээр гаргах, тэдгээрт зөвшөөрөл олгох, хяналт тавих асуудлыг хэрэгжүүлэн нийт 39 байгууллагын 412 хүүхдийн материалыг хүлээн авч судалгаа, шалгалтын ажиллагааг хийж гүйцэтгэн энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдсэн сэрэмжлүүлэг бүхий гадаад паспортын хавчуургыг өгч, хил нэвтрүүлэх зөвшөөрлийг Хил хамгаалах ерөнхий газарт албан бичгээр хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад хүүхэд үрчлэх, гадаад иргэд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэх асуудал дээр хяналт шалгалт тогтмол хийдэг, гуравласан гэрээг байгуулаад ажиллаж байна. Мөн хилээр урлаг, соёлын үйл ажиллагаатай холбоотой нэвтэрч буй хүүхдүүдийг шалгуулж, холбогдох нэгжээс зөвшөөрөл авах болсон энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж буй томоохон алхмуудын нэг болсон тухай холбогдох байгууллагын төлөөллүүд дурджээ.

Ийнхүү хүүхэд үрчлүүлэх асуудалд холбогдох хууль эрх зүйн дагуу хяналт шалгалт хэвийн үргэлжилж байна.

### 3.2. Хоёрдугаар зорилтын үйл ажиллагаануудын үнэлгээ, үр дүн

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх” хоёрдугаар зорилтын хүрээнд дараах 6 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгажээ.

*Хүснэгт 8. Хоёрдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн үнэлгээ*

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн үнэлгээ	Ангилал
1	Хохирогч хамгаалах байр байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах;	85 хувь	Тодорхой үр дүнтэй

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн үнэлгээ	Ангилал
2	Хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх бүтцийг бий болгож, үйл ажиллагааг эхлүүлэх;	88 хувь	Тодорхой үр дүнтэй
3	Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;	100 хувь	Үр дүнтэй
4	Гадаад улсад хохирогч болсон Монгол Улсын иргэнд туслалцаа үзүүлэх, эргүүлэн авчрах, Монгол Улсад хохирогч болсон гадаадын иргэнийг эх оронд нь буцахад туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;	100 хувь	Үр дүнтэй
5	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын 50 –аас доошгүй хувийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажлын байраар ханган нийгэмшүүлэх;	90 хувь	Тодорхой үр дүнтэй
6	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;	95 хувь	Тодорхой үр дүнтэй
6.1	Хүн худалдаалах гэмт хэрэгт, ялангуяа хөдөлмөрийн мөлжлөг (мал маллах, морь унах, айлын хүүхэд харах, гуйлга гуйх гэх мэт)-т өртсөн, өртөж болзошгүй хүүхдийн судалгааг гаргаж, дахин гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх;	80 хувь	Тодорхой үр дүнтэй
6.2	Нийгмийн халамжийн болон хүүхэд хамгааллын чиглэлийн төсөл, хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тусган хэрэгжүүлэх;	100 хувь	Үр дүнтэй
6.3	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалалтад авч эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд асрамжийн газар байлгах;	100 хувь	Үр дүнтэй
6.4	Хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөх сэтгэл зүйч, хуульч, багш нарыг сургаж мэргэшүүлэх;	100 хувь	Үр дүнтэй
<b>Дундаж үнэлгээ:</b>		<b>94.6 хувь</b>	<b>Тодорхой үр дүнтэй</b>

**Үйл ажиллагаа 1:**<sup>37</sup> Хохирогч хамгаалах байр байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах үйл ажиллагаа “**тодорхой үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харвал АНУ-ын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжсэн “Олон улсын манлайлал” хөтөлбөрийн хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр 2018 онд хийсэн уулзалтаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх хамтран ажиллах нь үр дүнтэй талаар хэлэлцжээ. Ийнхүү энэ чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг “Хүйсийн тэгш эрх төв”, Талита Ази Монгол зэрэг төрийн бус байгууллагатай хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. ,

Чанарын судалгааны үр дүнгээс харахад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлж байгаа түр хамгаалах байрын хүрэлцээ дээр холбогдох байгууллага бүрийн төлөөлөл харилцан адилгүй саналтай байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шууд үйлчилгээ үзүүлдэггүй байгууллагуудын төлөөллүүдийн хувьд манай улсын хэмжээнд буй нийт хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрын тоон дээр үндэслэн хангалттай байна гэж үзэж байгаа бол шууд үйлчилгээ үзүүлдэг, хэрэг дээр

<sup>37</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.1 дэх заалт

ажилладаг холбогдох байгууллагуудын төлөөллүүдийн хувьд хохирогчийг түр хамгаалах байрын хүрэлцээ хангалтгүй гэж үзжээ. Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон иргэдийг бусад төрлийн хүчирхийллийн хохирогч болсон хүмүүстэй нэг байранд байрлуулах нь тохиромжгүй байдаг. Тиймээс зөвхөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэдийг байрлуулж, үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байрыг сонгон хохирогчийг хамгаалалтад авахыг зорьдог байна. Гэвч нэн шаардлагатай үед бусад түр хамгаалах байруудад байрлуулдаг гэжээ. Бусад төрлийн түр хамгаалах байранд байрлуулах нь олон эрсдэлийг бий болгодог тухай дурдсан юм. Жишээ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч өөр бусад хүмүүсийг уруу татаж энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн тоог нэмэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн мэдээлэл хувийн нууц задрах зэрэг асуудал үүсдэг байна.

Ийнхүү хохирогчийн түр хамгаалах байр шинээр байгуулагдаагүй ч хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж байна.

**Үйл ажиллагаа 2:**<sup>38</sup> Хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх бүтцийг бий болгож, үйл ажиллагааг эхлүүлэх ажил “**тодорхой үр дүнтэй**” байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн сэтгэлзүйн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах стандартуудыг мөрдөн ажиллаж байна.

- Эрүүлийн хамгаалах технологи-Айдас, сэтгэл түгших эмгэгийн оношилгоо, эмчилгээ MNS 5481-5:2005
- Эрүүлийн хамгаалах технологи-Биеийн хэлбэрийн эмгэгийн оношилгоо, эмчилгээ MNS 5481-6:2005
- Эрүүл мэндийн технологи-Уй гашуу тохиолдох үеийн сэтгэлзүйн эмгэгийн оношилгоо, эмчилгээ MNS 5439:2008
- Эрүүл мэндийн технологи-Өөрийгөө сургах дасгал /тайвшруулах буюу булчин сулруулах/ MNS 5935:2008

Мөн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газруудыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх тухай удирдлага арга зүйгээр хангаж ажилладаг буюу одоогийн байдлаар тус ЭМТ-үүдэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ авсан тохиолдол гараагүй байна. Мөн “Хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчдэд сэтгэл заслын тусламж, үйлчилгээ үзүүлэх арга техник” сургалтыг зохион байгуулж, боловсруулсан гарын авлагыг хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд тараан өгчээ. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн хохирогч хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх стандартыг мөрдөх тухай заалтыг тусгах саналыг өгсөн байна. Стандартын агуулгын хувьд:

- Хэргийг шалгах, мэдүүлэг, байцаалт авах;
- Шүүх шинжилгээний дүгнэлт гаргах;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;
- Сэтгэл зүйн зөвлөгөө болон заслын үйлчилгээ үзүүлэх;

<sup>38</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.2 дахь заалт

- Нийгмийн ажлын цогц үйлчилгээ үзүүлэх;
- Аюулгүй байдлыг хангах, түр хамгаалан байрлуулах;
- Хууль эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн туслалцаа;
- Шүүх хуралдааны үед хүүхдийн эрхийг хангах;
- Боловсролын тасралтгүй байдлыг хангах;
- Хөгжлийн болон амьдрах ухааны чадамжуудыг эзэмшүүлэх;
- Гэр бүлтэй ажиллах гэсэн агуулгатай байхаар тогтоосон байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх биеийн эрүүл мэндийн үйлчилгээний хувьд бие махбодод үүссэн хохирлыг тооцоолж хэрэг үйлдэгч талаас бүрэн төлүүлж эмчилгээ үйлчилгээг үзүүлэх боломж бүрэн байдаг. Харин хохирогчийн сэтгэл зүйн хохирлын тооцох, тухайн хохирлыг хэрэг үйлдсэн талаар нөхөн төлүүлэх тогтолцоо Монгол Улсад хараахан бүрдээгүй байгаа нь сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд хамгийн том асуудал болдог гэж үзэж байна. Одоогийн байдлаар СЭМҮТ-ийн эмч нараар сэтгэл заслын үйлчилгээ хийлгэж байгаа хохирогчид байгаа бөгөөд тухайн үйлчилгээ нь үр дүнгээ өгч байгаа гэж холбогдох байгууллагын төлөөллүүд үзэж байна. Мөн СЭМҮТ-ийн эмч ГБХЗХГ-т ажиллаж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг тухай дурдсан.

Ийнхүү хохирогчид эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тодорхой дүрэм журам, стандартуудыг мөрдөн ажиллаж эмчилгээний тогтолцоог бүрдүүлж байгаа боловч сэтгэл зүйн гэмтлийн хэмжээг тогтоож, нөхөн төлбөр гаргуулах тал дээр хараахан бодит үр дүн гараагүй байгаа тул дээрх үйл ажиллагааг тодорхой үр дүнтэй гэж дүгнэлээ.

**Үйл ажиллагаа 3:**<sup>39</sup> Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд “**үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад ГБХЗХГ, Монголын хуульчдын холбоо хүүхдийн эсрэг бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч хүүхдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээ, туслалцаа шуурхай үзүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Тус санамж бичгийн хүрээнд 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 11 хэрэгт 7 өмгөөлөгчтэй эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллажээ. Дээрх үйл ажиллагаанд нийт 12.840.000 төгрөгийг зарцуулсан байна. 2022 онд нийт 20 гаруй хохирогчтой 11 хэрэг дээр 3 өмгөөлөгчтэй гэрээ байгуулж ажиллаж байна. Түүнчлэн 2018 оноос хойш Хууль зүй, дотоод хэргийн яамны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлэн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-ын дэргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зөвлөгөө өгөх төв байгуулж тусгай дугаарын утас /1800-1903/ ажиллуулж байна. Итгэлийн утас, хохирогчид зөвлөгөө өгөх төвийн танилцуулга бүхий тэмдэглэлийн дэвтэр, балыг хэвлүүлэн хохирогч болох эрсдэл бүхий иргэдэд тараажээ.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-тай

<sup>39</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.3 дахь заалт

хамтран хийдэг байна. Тус төв нь өөрийн санхүүжилтээр болон Хуульчдын холбоотой хамтран хохирогчид үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг. Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэшсэн өмгөөлөгчдийн хувьд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх явцын урсгал зардлаас бусад санхүүжилт авахгүйгээр жилдээ нийгмийн сайн сайхны төлөө энэ төрлийн хохирогчид өмгөөллийн үйлчилгээ үнэгүй үзүүлэх боломж байдаг талаар дурдсан юм. Мөн өөрсдийн сайн дураар урсгал бүх зардлыг өөрөөсөө гарган хохирогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байсан туршлагаасаа хуваалцжээ.

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-тай хамтран хэрэгжүүлж, гэмт хэргүүдийг шийдвэрлэж байна.

**Үйл ажиллагаа 4:**<sup>40</sup> Гадаад улсад хохирогч болсон Монгол Улсын иргэнд туслалцаа үзүүлэх, эргүүлэн авчрах, Монгол Улсад хохирогч болсон гадаадын иргэнийг эх оронд нь буцахад туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээнд **“үр дүнтэй”** байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн гадаад улсаас авч ирэх ажлыг ГХУСАЗЗАА, Гадаад хэргийн яам, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Хүйсийн тэгш эрх төв ТББ гэх мэт байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Жишээ нь Малайз Улс, Тайландын Хаант Улсад хүний наймааны хохирогч болсон байж болзошгүй Монгол Улсын 18 иргэнийг тусгай үүргийн нислэгүүдээр эх оронд нь эргүүлэн авч ирсэн. Эдгээр иргэдийг эх оронд нь эргүүлэн авчрах, холбогдох үйлчилгээг үзүүлэхэд хамтрагч байгууллагуудын 70,200,000 төгрөгийн зардлыг гаргажээ. Мөн Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй Холбооны Бүгд Найрамдах Мьянмар Улсын 3 иргэний талаарх гомдлыг хүлээн авч, шалгаж, “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-ын түр хамгаалах байранд байрлуулж, “Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр эх оронд нь буцаасан. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий Монгол Улсад оршин суугаа гадаад улсын иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын иргэдийг авч ирэх ажлын үр дүн нэмэгдсэн төдийгүй тэдгээр хохирогчид тусламж үйлчилгээ авч, мэргэжил эзэмшиж энгийн амьдрал, гэр бүлдээ эргэн нэгдсэн сайн үр дүнгүүд гарчээ. Түүнчлэн Монгол Улсын хилийн боомт дээр тараасан брошур дээрх утасны дугаараар холбогдож тусламж үйлчилгээ авч, эх орондоо ирсэн кейс гарсан тухай холбогдох байгууллагуудын төлөөллүүд дурджээ. Гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон болон эрсдэлтэй Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, холбогдох тусламж, дэмжлэгийг Монгол Улсаас хилийн чандад суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд үзүүлж байна.

---

<sup>40</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.4 дэх заалт

Ийнхүү иргэдийг гадаад улсад хүний наймааны хохирогч болохоос хамгаалах, эх оронд нь авч ирэх, гадаадын хохирогч иргэдийг эх оронд нь буцаах ажлыг амжилтай зохион байгуулж байна.

**Үйл ажиллагаа 5:**<sup>41</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын 50 –аас доошгүй хувийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажлын байраар ханган нийгэмшүүлэх үйл ажиллагаа “**тодорхой үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд "Монгол Улсад дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх" төслийн хүрээнд "Хүйсийн тэгш эрх төв" ТББ -ын түр хамгаалах байранд нийт 43 хүнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн ба 34 үйлчлүүлэгч нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоор тогтоогдсон байна. Үүнээс 33 нь дотооддоо бэлгийн мөлжлөгт өртсөн, үлдсэн нэг нь хилийн чанадад буюу Филиппин Улсад хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогч байжээ. Тэдгээрээс нийт 10 хохирогчийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, суралцах хугацаанд нь тэтгэлэг олгох ажлуудыг хийсэн байна. Сургалтын хугацаа нь 1-3 сар үргэлжилж байгаа бөгөөд суралцагчдын дийлэнх нь гоо сайхан, нягтлан, нярав, хүний нөөцийн менежерийн чиглэлээр суралцжээ. Мөн хорих ял эдэлж байгаа болон суллагдсан 200 залуучуудад нийгмийн үйлчилгээг цогцоор үзүүлэн ажиллаж 10 залууг байнгын ажлын байранд 50 залууг боловсролын үйлчилгээнд холбон зуучилсан байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь урт хугацаанд үргэлжилдэг. Үйлчилгээ нь олон талын хичээл зүтгэл, хамтын ажиллагааны үр дүнд амжилттай үргэлжилж хохирогч эргэн хэвийн амьдралдаа ордог байна. Эргэн хэвийн амьдралдаа орсон хохирогчид цөөнгүй байх бөгөөд мэргэжил эзэмшин мэргэжлээрээ ажиллаж, бусдыг ажлын байраар хангаж байгаа, эргээд хохирогч хүүхдүүдэд туслах үйл ажиллагаанд оролцдог талаар холбогдох байгууллагуудын төлөөллүүд жишээ дурдан ярьжээ.

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг мэргэжлийн сургалтад хамруулж ажлын байранд зуучлах үйл ажиллагаа хийгдэж 33 хохирогчоос 10 нь буюу 20 хувь нь мэргэжилтэй болсон тул дээрх үйл ажиллагааг “тодорхой үр дүнтэй” гэж үзэв.

**Үйл ажиллагаа 6:**<sup>42</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “**тодорхой үр дүнтэй**” байна.

**Үйл ажиллагаа 6.1:**<sup>43</sup> Хүн худалдаалах гэмт хэрэгт, ялангуяа хөдөлмөрийн мөлжлөг (мал маллах, морь унах, айлын хүүхэд харах, гуйлга гуйх гэх мэт)-т өртсөн, өртөж болзошгүй хүүхдийн судалгааг гаргаж, дахин гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх ажил “**тодорхой үр дүнд хүрсэн**” байна.

---

<sup>41</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.5 дахь заалт

<sup>42</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.6 дахь заалт

<sup>43</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.6.1 дэх заалт

2018 онд ГХУСАЗЗАА-аас хөдөлмөрийн мөлжлөгийн талаар тандалт судалгаа хийжээ, судалгааны дүнд Монгол Улсад хөдөлмөрийн мөлжлөг бодитой оршин байгаа, мөн өртөж буй шалтгааныг авч үзвэл иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байгааг онцолсон. Хүүхдийн хөдөлмөр, хүчирхийллийн асуудлаар хийх судалгааны удирдах хороог ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/136 дугаар тушаалаар төрийн болон төрийн бус байгууллага, судлаачдын төлөөллийг оролцуулан байгуулжээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас харахад “Хөдөлмөр эрхлэгч хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны удирдамж”-ийг 21 аймаг, нийслэлийн ГБХЗХГ-т хүргүүлсэн. Удирдамжийн дагуу 21 аймаг, нийслэлийн хэмжээнд Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран хүүхдийн хөдөлмөрийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, хүүхдийн хөдөлмөрийг илрүүлж, зөрчлийг арилгах, барагдуулах арга хэмжээг холбогдох хуулийн дагуу авч мэдээлэл, зөвлөмж өгсөн. Хяналт, шалгалтын явцад “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байр”-нд ажиллаж байсан 18 хүүхдийг илрүүлж, Мэргэжлийн хяналтын хөдөлмөрийн улсын ахлах байцаагч 43 ААНБ-д албан даалгавар, 1 ААНБ-ыг 1,5 сая төгрөгийн мөнгөн торгууль, Хүүхдийн эрхийн улсын байцаагч 2 ААНБ-д 3,0 сая төгрөгийн мөнгөн торгуулийг тус тус ногдуулсан байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад насанд хүрээгүй хүн хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлийн суурь судалгааг хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд суурилан гаргаж байгаа тухай холбогдох байгууллагын төлөөллүүд дурдсан бөгөөд тус судалгааны үр дүнд үндэслэн дараа дараагийн үйл ажиллагаагаа төлөвлөхөөр бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Түүнчлэн хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийн таслах зогсоох чиглэлээр тодорхой дэвшлүүд гарч байна хэмээжээ. Жишээ нь хурдан морь унаач хүүхдүүдийн насны доод хязгаарыг тогтоосон, унаач хүүхдүүдийн хувцас хэрэглэлийн стандартыг тогтоосон, ард иргэд хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийн уламжлалт /байх ёстой/ үйл ажиллагаа гэж хардаг байсан бол сүүлийн үед хөдөлмөрийн мөлжлөг гэх өнцгөөс харж эсэргүүцэх болсон зэрэг дэвшлүүд гарч байна. Цаашид харин энэ төрлийн хөдөлмөрийн мөлжлөгийг таслан зогсоохын тулд хууль эрх зүйн хэрэгжилтийн хангах, хяналт шалгалтыг сайжруулах, ард иргэдэд түгээх мэдээллийг нэмэгдүүлэх ажилд анхаарах хэрэгтэй гэжээ.

Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгаас Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/49 тоот тушаалаар баталсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын 2.1.4 дэх хэсэгт заасан “Олон улсын уралдаан, тэмцээн, урлаг соёлын арга хэмжээ, сурагч, оюутан солилцоогоор сургалтад хүүхэд оролцуулж байгаа сургууль, спорт клуб, урлаг соёлын байгууллагыг тухайн харьяа нэгжийн Цагдаагийн хэлтэс, тасаг нь шалгаж зөвшөөрөл олгоно. Орон нутгаас дээрх арга хэмжээнд хүүхэд оролцуулахаар бол тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл олгоно” гэсэн заалтын хүрээнд насанд хүрээгүй хүүхдийг хилээр гаргах, тэдгээрт зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг хариуцан 2017-2021 оны хооронд 1755 хүүхдэд хилээр нэвтрэх зөвшөөрөл олгосон байна.

Дээрх журам хэрэгжиж эхлэхээс өмнө иргэн, ААНБ-аас насанд хүрээгүй хүүхдүүдийг эцэг, эхийн аль нэгний зөвшөөрсөн итгэмжлэхээр гадаад улсад урлаг соёл, олон нийтийн арга хэмжээнд авч явах нэрээр халхавчлан БНХАУ, Сингапур, БНТУ, Энэтхэг зэрэг улсуудад



хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлж, хохироосон тохиолдол бүртгэгдэж байжээ. 2017 оноос цагдаагийн байгууллагын хяналтад орсноор энэ төрлийн гэмт хэрэг таслан зогсоогдсон гэдгийг цагдаагийн байгууллагын төлөөлөл дурджээ.

Ийнхүү холбогдох зарим арга хэмжээ авагдаж, хөдөлмөрийн мөлжлөгт өртөж байсан хүүхдүүдийг илрүүлэх таслан зогсоох, хүүхэд хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлууд тодорхой түвшинд хийгджээ. Гэвч насанд хүрээгүй хүнийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг нэмэгдүүлэх хэрэгцээ байсаар байна.

**Үйл ажиллагаа 6.2:**<sup>44</sup> Нийгмийн халамжийн болон хүүхэд хамгааллын чиглэлийн төсөл, хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тусган хэрэгжүүлэх ажил “**үр дүнтэй**” байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4-д заасан “Түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалах байрлуулах” үйлчилгээнд хүнд нөхцөлд байгаа хүүхдүүд хамрагдан үйлчлүүлдэг бөгөөд тус үйлчилгээг “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд гэрээ байгуулан үзүүлдэг. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1-д “бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа” иргэнд сар бүр 70.000 төгрөгийн асаргааны тэтгэмж олгохоор заасан. 2019 онд “Бид хамгаална” загварыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2015 онд Интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад өөрчлөлт оруулж +18 шүүлтүүртэй интернэтийг хэрэглэгчдэд хүргэх боломжийг бий болгосон. Үүний дагуу нийт 31 интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн дунд шалгалт явуулж, хангалттай 22, хангалтгүй 9 үйлчилгээ эрхлэгч илэрсний холбогдох үүрэг, анхааруулга өгч ажилласан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, ГБХЗХГ болон ХХЗХ хамтран Монгол Улсын хэмжээнд Цахим тоглоомын үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд 2013 оны Засгийн газрын 410 тоот тогтоолын хэрэгжилтийг шалгах, шаардлага хангаагүй, бүртгэлгүй газруудын үйл ажиллагааг зогсоох зорилго бүхий хяналт, шалгалтыг 2019 оны 04 сарын 15-аас 07 сарын 30-ны хооронд зохион байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар Улаанбаатар хотын 6-н дүүрэгт цахим тоглоомын газрын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, зөрчлийг арилгуулсан.

ХНХЯ-наас 2017-2021 онд хэрэгжүүлсэн “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн 4 болон 5 дугаар зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ.

4 дүгээр зорилт: Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаална.

5 дугаар зорилт: Тэгш боломж олгох нийгмийн хамгааллыг дэмжих замаар хүүхдийн орлогын болон орлогын бус ядуурлыг бууруулна. Ийнхүү хүүхэд хамгааллын чиглэлээр

<sup>44</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.6.2 дахь заалт

хэрэгжсэн үндэсний хөтөлбөрийн 2 зорилт хүн худалдаалах гэмт хэргээс хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад ХНХЯ-наас 2017-2021 онд хэрэгжүүлсэн “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”-т хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр ажилтан албан хаагчдын чадавхжуулах үйл ажиллагаануудыг тусган хэрэгжүүлсэн тухай дурдсан. Түүнчлэн салбар дундын хамтарсан багаараа жил бүрийн төлөвлөгөөгөө хамтран хэлэлцэж баталгаажуулдаг тул нийгмийн халамж, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй байгууллагуудын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх ажлын тусгадаг байна.

**Үйл ажиллагаа 6.3:**<sup>45</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалалтад авч эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд асрамжийн газар байлгах ажил “**үр дүнтэй**” байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдүүдийг “Хүйсийн тэгш эрх төв” ТББ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хамгаалах байр, ЭКПАТ ТББ-ын хамгаалах байранд байрлуулан шаардлагатай нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэнд, хууль эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлж байна. Тухайлбал 2019 онд ЭКПАТ ТББ-д Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн захын хороод, болон МСҮТ-ын дотуур байранд амьдардаг шилжин суурьшсан эмзэг бүлгийн, бэлгийн мөлжлөг, хүний наймаа, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах шаардлагатай өсвөр насны 25 охидод хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж байна. Охидын нөхцөл байдал:

- Сурч боловсрох эрх зөрчигдсөн, сургууль завсардсан-2
- Эрүүл мэндийн хэвийн байдал алдагдсан-4
- Амьдрах орчны байдал алдагдсан (өөрийн гэр байхгүй, айлд амьдардаг)-5
- Зан төлөв, сэтгэл зүйн буруу дадалтай, гадуур сэлгүүцдэг-8
- Насанд хүрсэн буруу зан үйлтэй хүнд уруу татагддаг-5
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн-2

Эдгээр охидод хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхдийн эрхийн сургалт, нөлөөллийн ажил, амьдрах ухаан, ур чадвар олгох, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгөх, нийгэмшүүлэх үйл ажиллагааг тодорхой төлөвлөгөө хуваарийн дагуу авч хэрэгжүүлжээ. Мөн Монголд анх удаа 2019 оноос “Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал” (Уур бухимдал, нойргүйдэл, сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, амиа хорлолт, донтолт, мансуурал, хүчирхийлэлтэй холбоотой сэтгэл санааны хямралд өртсөн)-тай үйлчлүүлэгчид мэдээлэл өгөх 24 цагийн 1800-2000 дуудлагын утсаар мэргэжлийн сэтгэцийн эмчээс мэдээлэл авах боломжтой үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Одоогийн байдлаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдүүдийн дунд асрамж, халамжийн газар луу зуучлуулсан тохиолдол гараагүй байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийг асрамж халамжийн төв рүү зуучлах шаардлага үүсвэл

<sup>45</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.6.3 дахь заалт

Хүүхэд хамгааллын хуулийн хүрээнд дүүрэг, хороо, аймаг, сумын засаг даргын тогтоолд үндэслэх асрамж халамжийн газарт зуучлах боломж байдаг ч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд энэ тухай тусгайлан заасан зүйл заалт байдаггүй тухай холбогдох байгууллагын төлөөллүүд дурдав.

**Үйл ажиллагаа 6.4:**<sup>46</sup> Хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөх сэтгэл зүйч, хуульч, багш нарыг сургаж мэргэшүүлэх үйл ажиллагаа “**үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дурдсанаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчдад /сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, хуульч, багш г.м/ энэ чиглэлийн сургалт, чадваржуулах ажлыг зохион байгуулж, сургалтын гарын авлага тараасан байна. Мөн аливаа төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлого, хөтөлбөрийн баталж, хэрэгжүүлж байгаа нь салбарын мэргэжилтнүүдийн бүх төрлийн хүчирхийллийн таних, илрүүлэх, хариу үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах ур чадвар мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж байна. Жишээ нь 2018 онд Хүүхэд хамгааллын бодлого баталсан нь нийгмийн ажилтан болон сум, хороо, сургуулийн хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах, аливаа төрлийн хүчирхийлэл, хүүхдийн (хүний) эрхийн зөрчлийг таньж, илрүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх хууль зүйн туслалцааг сайжруулах чиглэлээр Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран 20 өмгөөлөгчийг мэргэшүүлсэн. 2019 оны 06 дугаар сард Баруун, Хангайн, Төв, Зүүн бүсчилсэн, 21 аймгийн 210, 9 дүүргийн 160 өрхийн эмч нарт “Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, зөвлөгөө өгөх арга зүй” сэдвээр сургалт зохион байгуулж, “Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” гарын авлага 1500 ширхгийг тараасан. ГБХЗХГ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд болон тэдэнтэй ажиллаж буй ажилчдын ажлын байран дахь стресс бууруулах арт терапи буюу урлагийн сэтгэл заслын жишиг хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг хийж байна. “Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчдэд үзүүлэх сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ” эмнэлзүйн гарын авлагыг 5,200 ширхэг, “Хураангуй баримтын цомог хүчирхийлэл” 500 ширхэг, “Хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ, Хүчирхийлэл үйлдэгчдэд үзүүлэх сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ баримтын цомгууд” 3,000 ширхэг тус тус хэвлүүлж 15 аймаг нийслэлийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс тасгуудад тараасан. Жендерт суурилсан хүчирхийллийг таслан зогсооход эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар эрүүл мэндийн удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, хандлагыг зөв төлөвшүүлэхэд чиглэсэн гарын авлагыг гаргасан. ГБХЗХГ–аас Монголын хуульчдын холбооны гишүүн 12 өмгөөлөгчтэй хүүхдийн эсрэг бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч хүүхдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх, хохирогчийн бие амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээ, туслалцаа шуурхай үзүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан байна.

<sup>46</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.2.6.4 дахь заалт

Чанарын судалгааны үр дүнгээс харахад салбар бүрийн төлөөлөл, ажилтан албан хаагчдад үе шаттайгаар жил бүр сургалтын төлөвлөгөө гарган мэдээ мэдээлэл түгээх чиглэлд анхаарч ажиллаж байна гэжээ. Жишээ нь “Хүйсийн тэгш эрх төв” ТББ, НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, ЦЕГ зэрэг байгууллагууд хамтран хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой хэрхэн ажиллах талаар нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульч өмгөөлөгч, сэтгүүлчдэд сургалт ордог бөгөөд тухайн сургалтын үйл ажиллагаанууд нь жил бүр тогтмол зохион байгуулагддаг байна.

Ийнхүү нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид, хуульч, өмгөөлөгч, сэтгүүлчдэд сургалт мэдээллийн ажлыг хийх үйл ажиллагааг тогтмол хийгдэж байна.

### 3.3. Гуравдугаар зорилтын үйл ажиллагаануудын үнэлгээ, үр дүн

“Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах” гуравдугаар зорилтыг хүрээнд дараах 8 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 9. Гуравдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн үнэлгээ	Ангилал
1	Хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий бие даасан бүтцийг байгуулах;	100 хувь	Үр дүнтэй
2	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн алба хаагчийг бэлтгэн нийслэл болон хүн худалдаалах гэмт хэргийн гаралт өндөртэй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад ажиллуулах, цаашид тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;	75 хувь	Тодорхой үр дүнтэй
3	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагыг холбогдох бусад байгууллагатай мэдээллийн нэгдсэн сүлжээгээр холбож мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн шаардлагатай техник хэрэгслээр хангах, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажиллах ажилтныг бэлтгэх;	60 хувь	Эрчимжүүлэх шаардлагатай
4	Хүн худалдаадах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудад уг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, гэмт хэргийг таслан зогсоход орчин үеийн техник, хэрэгслийг ашиглах ур чадвар эзэмшүүлэх, бусад орны хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанаас туршлага судлах зэрэг сургалтад хамруулах;	83 хувь	Тодорхой үр дүнтэй
5	Хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, стандартыг баталж, мөрдүүлэн байгууллага хоорондын уялдаа, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;	75 хувь	Үр дүнтэй
6	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх;	100 хувь	Үр дүнтэй
7	Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх төвийг байгуулах;	60 хувь	Эрчимжүүлэх шаардлагатай
8	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Дэд зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;	100 хувь	Үр дүнтэй

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн үнэлгээ	Ангилал
	Дундаж үнэлгээ:	81.6 хувь	Тодорхой үр дүнтэй

**Үйл ажиллагаа 1:**<sup>47</sup> Хүн худалдаалах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий бие даасан бүтцийг байгуулах ажил “**үр дүнтэй**” байна.

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс дэх Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг 2 хүний бүрэлдэхүүнтэй байсныг 5 хүний бүрэлдэхүүнтэй болгож өргөтгөжээ. Ийнхүү бие даасан тасгийн үйл ажиллагааг өргөтгөснөөр хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд ахиц дэвшил гарсан гэж холбогдох байгууллагын төлөөллүүд үзэж байна. Гэвч энэхүү гэмт хэргийн цар хүрээтэй харьцуулахад 5 хүний бүрэлдэхүүнтэй тасаг нь хүн хүчний хувьд багадаж байна гэж үзэж байна. Тодруулбал 2018 онд тус тасаг нэмэлтээр дүүрэг, орон нутгаас албан хаагчид авч 9 бүлгийн 26 гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан бөгөөд хэргийн илрүүлэлт мөрдөгчдийн тоотой шууд хамааралтай байдаг байна. Түүнчлэн 2019 онд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн гишүүн байгууллагуудаас чиглэл хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдын нэрсийг авч техникийн зөвлөл байгуулжээ.

Цаашдын хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэх арга, хэлбэр цаг үе, нийгмээ даган хувьсан өөрчлөгдөж эрүүгийн нөхцөл байдал жил ирэх тутам хүндэрч, хохирогчдын тоо өссөн, нас залуужсан, бэлгийн замын халдварт өвчний тархалт хяналтаас алдах өндөр эрсдэлтэй нөхцөл байдал бодитоор бий болсныг харгалзан үзэж хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, улсын хэмжээнд энэ гэмт хэргийн нөхцөл байдлыг тодорхойлж мэдээллийн урсгалд дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэх ажлын шугамаар илрүүлэх, таслан зогсоох үндсэн бүтэц, хүн хүч, олон тоог нэмэгдүүлэн “Хар тамхитай тэмцэх нэгж”-ийн жишигт нийцүүлэн зохион байгуулах цаг үе зайлшгүй тулгарч байгаа гэдгийг цагдаагийн байгууллагын төлөөлөл дурджээ.

Улсын ерөнхий прокурорын газар нь 2020 онд “Хүн худалдаалах болон бусад төстэй гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэргийг дагнан хариуцах прокурорыг томилон ажиллуулах чиглэлээр харьяа прокурорын газруудад өгч, улсын хэмжээнд 49 прокурор энэ төрлийн хэрэгт дагнан хяналт тавин ажиллаж байна.

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллах бие даасан тасаг болон техникийн зөвлөлийг байгуулж үйл ажиллагаа тогтмол явагдаж байх боловч тухайн бие даасан тасгийг өргөтгөх, үйл ажиллагааг тэлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

**Үйл ажиллагаа 2:**<sup>48</sup> Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн алба хаагчийг бэлтгэн нийслэл болон хүн худалдаалах гэмт хэргийн гаралт өндөртэй нутаг

<sup>47</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.3.1 дэх заалт

<sup>48</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.3.2 дахь заалт

дэвсгэрийн цагдаагийн байгууллагад ажиллуулах, цаашид тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажил “**тодорхой үр дүнтэй**” байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд дурдсанаар хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх, энэ чиглэлээр мэргэшсэн албан хаагчдыг бэлдэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

- 2018 онд хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн сан үүсгэн, мэдээллийг хүлээн авч боловсруулах, цахим мэдээллийн сан бүтээж Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Хүн худалдаалахтай тэмцэх нэгжид хүлээлгэн өгсөн бөгөөд сангийн журмыг боловсруулсан. Энэхүү мэдээллийн санг Улсын бүртгэлийн ерөнхий газрын “ХУР” мэдээллийн сантай холбосон бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүн худалдаалахтай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудтай “Цахим мэдээллийн санг ашиглах гэрээ”-г байгуулсан;
- 2018 онд Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн хэлтэс тус бүрээс 1 албан хаагчийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн сургалтад хамруулж, Эрүүгийн цагдаагийн албаны чиглэл хариуцсан хэлтэст 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 1 сарын хугацаатайгаар ажиллуулан туршлага судлуулсан;
- 2019 онд Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийн хүрээнд техникийн зөвлөлийн гишүүдийг мэргэшүүлэх сургалтад 12 хүнийг хамруулсан;
- 2019 онд ГБХЗХГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хөдөлмөрийн улсын байцаагч, хүүхдийн эрхийн улсын байцаагч нийт 64 албан хаагчийг хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар чадавхжуулах сургалтад хамруулсан. Сургалтыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Бангкокийн товчооны хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр хариуцсан мэргэжилтнүүд удирдан явуулсан;
- 2020 онд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дахь хүний эрх, Эрүү шүүлт, ялгаварлан гадуурхахтай тэмцэх нь” сэдэвт 2 цагийн сургалт зохион байгуулсан;
- 2020 онд “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” сэдэвт хууль сахиулах байгууллагын алба хаагчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан;
- 2021 онд “Хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах асуудал” сэдэвт 40 минутын видео сургалтын материал бэлтгэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хүргүүлсэн;
- 2021 онд Дорноговь аймгийн Замын-Үүд, Сайншанд сумуудад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, туслалцаа үзүүлэх чиглэлээр цагдаагийн алба хаагч, хохирогчид шууд үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын ажилтнуудад сургалт орсон. Улсын хилийн хаасантай холбогдуулан БНХАУ-ын цагдаагийн албан хаагчид болон тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад тус сургалтыг БНХАУ дахь Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага ижил арга зүйгээр зохион байгуулсан.

Чанарын судалгааны үр дүнгээс харахад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй ЦЕГ–ын Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасагт ажиллаж буй албан хаагчдыг чадваржуулах чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж, сургалтуудыг тогтмол орж байгаа талаар дурдсан. Тухайлбал 2018 оноос хойш хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр гадаад улс руу 5 удаагийн сургалтад албан хаагчдыг хамруулсан байна. Гэвч тухайн албан хаагчдаас Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасагт ажиллаж байгаа хүн байхгүй буюу хамгийн удаан ажиллаж байгаа албан хаагч нь 2019 оноос хойш 3 дахь жилдээ ажиллаж байна. Ийнхүү ажилтан албан хаагчдын тогтвортой байдлыг бий болгох чиглэлээр анхаарч ажиллах хэрэгцээ шаардлага байна гэж холбогдох байгууллагын төлөөллүүд үзжээ.

Мөн дүүрэг, олон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдийн баг бүрэлдэхүүний алба хаагчид хүн худалдаалах гэмт хэргийн талаар ойлголт хангалтгүй байдаг учир иргэдийн өгсөн дуудлага мэдээллийн мөрөөр хэргийн газарт очиж ажиллахдаа хэрхэн яаж шалгах арга зүй дутмаг, хохирогчийг буруутгах хандлагатай, гэмт хэргийг дутуу шалгаснаар гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд яд завших боломжийг олгох, сэжигтэй этгээдүүдийн зүгээс хохирогчид нөлөөлж мэдүүлгээс нь буцаалгах, гэмт хэргийн нууц далд хэлбэрт шилжих нөхцөлийг бүрдүүлдэг байна. Тиймээс дүүрэг орон нутгийн цагдаагийн хэлтэст ажиллаж байгаа албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг мэдээллийг тогтмол өгөх хэрэгтэй гэж үзэж байна.

Ийнхүү хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогч төвтэй хандлагыг бий болгох чиглэлийн сургалт нөлөөллийн ажлуудыг хийж, энэ чиглэлээр ажиллах ажилтан албан хаагчдыг бэлдэх ажлыг зохион байгуулж байх тул дээрх үйл ажиллагааг тодорхой үр дүнтэй гэж үзлээ. Гэвч энэ чиглэлээр мэргэшиж байгаа алба хаагчдын ажлын онцлогт тохирсон ажиллах нөхцөлийг бий болгох, дүүрэг, хороо, орон нутгийн цагдаагийн хэлтэст ажиллаж байгаа албан хаагчдад хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, мэдээлэл түгээх ажилд онцгой анхаарах хэрэгцээ байсаар байна.

**Үйл ажиллагаа 3:**<sup>49</sup> Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагыг холбогдох бусад байгууллагатай мэдээллийн нэгдсэн сүлжээгээр холбож мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн шаардлагатай техник хэрэгслээр хангах, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажиллах ажилтныг “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

2018 онд Хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийг хүлээн авч боловсруулах, цахим мэдээллийн сан бүтээж Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Хүн худалдаалахтай тэмцэх нэгжид хүлээлгэн өгсөн бөгөөд сангийн үйл ажиллагааны журмыг боловсруулан баталсан. Энэхүү мэдээллийн санг Улсын бүртгэлийн ерөнхий газрын “ХУР” мэдээллийн сантай холбосон бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүн худалдаалахтай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудтай “Цахим мэдээллийн санг ашиглах гэрээ”-г байгуулсан.

<sup>49</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.3.3 дахь заалт

Гэвч хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий холбогдох байгууллагуудыг мэдээлэл солилцох боломжоор хангасан нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан одоогийн байдлаар бий болоогүй байна.

Чанарын судалгаанд оролцогчдын зүгээс байгууллага хооронд мэдээллээр хангах нэгдсэн сан бий болгохоор төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд хоорондын мэдээлэл солилцох үйл ажиллагаа сул байдаг талаар дурджээ.

**Үйл ажиллагаа 4.**<sup>50</sup> Хүн худалдаадах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудад уг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, гэмт хэргийг таслан зогсооход орчин үеийн техник, хэрэгслийг ашиглах ур чадвар эзэмшүүлэх, бусад орны хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанаас туршлага судлах зэрэг сургалтад хамруулах ажил **“тодорхой үр дүнтэй”** байна.

Хүн худалдаалахтай тэмцэх чиг хүүрэг бүхий цагдаагийн байгууллага болон бусад байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийг шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах, тэдгээр дээр хэрхэн ажиллах заавар зөвлөгөө өгөх, мэргэжилтнүүдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, олон улсын туршлага судлуулах ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, энэ чиглэлээр мэргэшин ажиллаж буй 8 (давхардсан тоогоор) цагдаагийн албан хаагчдыг хөтөлбөр хэрэгжих хугацаанд (2018, 2019 он) гадаадын туршлага судлуулах 6 төрлийн сургалтад хамруулжээ. Гэвч одоогоор албан хаагчдаас Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст ажиллаж буй албан хаагч (хэлтсийн даргаас бусад) байхгүй байна. 2020, 2021 онд Ковид 19 цар тахлын улмаас хилээр зорчих хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой гадаад улсад туршлага судлах сургалт зохион байгуулаагүй байна.

*Хүснэгт 10. Цагдаагийн байгууллагын хүн худалдаалахтай тэмцэх чиг үүрэг бүхий хэлтсийн албан хаагчдын гадаад улсад сургалтад суусан, мэргэжил дээшлүүлсэн байдал*

Он	Суралцсан гадаад улс	Сургалтын төрлийн тоо	Сургалтад хамрагдан албан хаагчийн тоо	Одоогоор ажиллаж буй албан хаагчийн тоо
2018	БНСУ	1	1	-
	Тайланд	1	1	-
	БНХАУ	2	2	-
2019	БНХАУ	2	4	1
<b>Нийт</b>		<b>6</b>	<b>8</b>	<b>1 /хэлтсийн дарга/</b>

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтан албан хаагчдыг чадваржуулах, олон улсын туршлагаас суралцах боломжийг бий болгож, холбогдох арга хэмжээг авсан боловч ажилтан албан хаагчдын тогтвор суурьшилд анхаарах хэрэгтэй байна.

<sup>50</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.3.4 дэх заалт





**Үйл ажиллагаа 5:**<sup>51</sup> Хүн худалдаалахтай тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дүрэм, журам, стандартыг баталж, мөрдүүлэн байгууллага хоорондын уялдаа, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа **“тодорхой үр дүнтэй”** байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллага хоорондын хамтын ажиллагаа сайжирч байна гэж холбогдох байгууллагуудын төлөөллүүд үзжээ. Тухайлбал хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа бөгөөд дэд зөвлөл бий болсноор байгууллагуудын удирдлагуудын хамтын ажиллагаа сайжирч нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй болсон гэж үзэж байна. 2021 онд хүн худалдаалахтай тэмцэх, хүүхэд хамгааллын чиглэлээр хамтран ажиллах зорилго бүхий таван агентлагийн даргын хамтарсан тушаал гарсан нь байгууллагуудын дунд шатны менежерүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, идэвхжүүлэх, тэдний мэдлэг, ойлголтыг тэлэхэд томоохон дэмжлэг болсон гэж чанарын судалгаанд хамрагдсан төлөөллүүд дурджээ.

Ийнхүү холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх чиглэлээр тухайлсан арга хэмжээг авч үр дүнд хүрсэн байна. Гэвч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан зарим журам батлагдаагүй байна. Үүнд:

1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.2.3 дахь хэсэг буюу Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9.4 дэх хэсэг буюу Хамгаалах байрны бүтэц зохион байгуулалт, ажиллах журам
3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12.1.4 дэх хэсэг буюу Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам.

**Үйл ажиллагаа 6:**<sup>52</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх ажлыг **“үр дүнтэй”** гэж үнэлэв.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд улсын төсвөөс 2018 онд 709 сая төгрөг, 2019 онд 506 сая төгрөг, 2020 онд 432 сая төгрөг, 2021 онд 432 сая төгрөг тус тус олгосон байна.

Ийнхүү хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн санхүүжилтыг жил бүр улсын төсөвт суулган, төлөвлөгөөний дагуу зарцуулагдсан байна.

**Үйл ажиллагаа 7:**<sup>53</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх төвийг байгуулах ажлыг **“эрчимжүүлэх шаардлагатай”** байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл өгөх тусгай төв байгуулагдаагүй бөгөөд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн тусламжийн 108 утас, “Хүйсийн тэгш

---

<sup>51</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.3.5 дахь заалт

<sup>52</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.3.6 дахь заалт

<sup>53</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.3.7 дахь заалт

эрх төв” ТББ –ын 1800-1903 утсаар энэ төрлийн гэмт хэргийн дуудлагын авч шаардлагатай мэдээллийг өгч холбон зуучлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. 2017-2021 онд Хүүхдийн тусламжийн 108 тусгай дугаарт хүн худалдаалахтай холбогдох 19 дуудлага ирж, зөвлөгөө мэдээлэл өгсөн бол Хүйсийн тэгш эрх төв ТББ-ын тусламжийн 1800-1903 утсанд ирсэн дуудлагуудаас 14 хохирогчийг илрүүлж шаардлагатай үйлчилгээ үзүүлсэн байна.

**Үйл ажиллагаа 8:**<sup>54</sup> Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажил “**үр дүнтэй**” байна.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/173 дугаар тушаалаар байгуулж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны оны 01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны оны 01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Дэд зөвлөлийн ажиллах нийтлэг журмын дагуу дэд зөвлөл нь жилд 2–оос дээш удаа хуралдаж, энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлын талаар сонсож, салбар дундын уялдаа, хамтын ажиллагааны талаар хэлэлцдэг.

Чанарын судалгааны үр дүнгээс байгууллагуудын хүн худалдаалахтай тэмцэх чиг үүргийн хариуцан ажиллаж буй удирдлагууд хамтран ажиллаж тулгарч буй асуудлаа хэлэлцэж, цаашдын үйл ажиллагаагаа хамтран төлөвлөж байгаа нь дараах байдлаар эерэг нөлөө үзүүлж байгааг мэргэжилтнүүд дурджээ. Үүнд:

- Удирдлагууд ажилтан, албан хаагчдын хийхээр төлөвлөж буй ажилд дэмжлэг үзүүлэх
- Удирдлага хүн худалдаалахтай тэмцэх чиглэлийн үйл ажиллагааг дотоод ажлын төлөвлөгөөнд тусгах
- Удирдлагууд тухайн асуудлын талаар ойлголттой болж шинэлэг мэдээллээр хангагдах
- Байгууллага хоорондын хамтын ажиллагаа, дэмжлэг нэмэгдэх
- Дэд зөвлөлд тайлан мэдээ тавьдаг тул төлөвлөгөөний биелэлтэд анхаарч ажиллах г.м

#### 3.4. Дөрөвдүгээр зорилтын үйл ажиллагаануудын үнэлгээ, үр дүн

“Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх” дөрөвдүгээр зорилтын хүрээнд дараах 3 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

<sup>54</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.3.8 дахь заалт

Хүснэгт 11. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, тэдгээрийн үнэлгээ

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилтийн үнэлгээ	Ангилал
1	Монгол Улсад хүн худалдаалахтай тэмцэх талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;	100 хувь	Үр дүнтэй
2	Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх болон энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид үзүүлэх зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх;	100 хувь	Үр дүнтэй
3	Монгол Улсын иргэд ихээр зорчдог, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий улс орнуудтай хамтран ажиллах, тогтмол мэдээлэл солилцох сувгийг бий болгож, хамтын ажиллагааг өргөжүүлэх;	80 хувь	Тодорхой үр дүнтэй
<b>Дундаж үнэлгээ:</b>		<b>93.3 хувь</b>	<b>Тодорхой үр дүнтэй</b>

**Үйл ажиллагаа 1:**<sup>55</sup> Монгол Улсад хүн худалдаалахтай тэмцэх талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хүрээнд “үр дүнтэй” байна.

Дэлхийн улс орнуудын хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, засгийн газрын авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тоймлосон олон улсын хүн худалдаалах гэмт хэргийн тайланд Монгол Улсыг хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр дараах дэвшлүүд гарсан болохыг дурджээ. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, холбогдогч талуудыг мөрдөж, олж ирүүлэх чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллаж байна.
- Төрийн байгууллагууд болон олон улсын байгууллагатай мэдээлэл хуваалцах, солилцох үйл ажиллагаанд дэвшил гарсан төдийгүй Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийг байгуулсан
- Прокурорын байгууллагад хүн худалдаалах гэмт хэргээр дагнан ажиллах мэргэжилтнүүдийг бэлдэж, энэ чиглэлд дагнан ажиллах ажлыг байрыг бий болгосон
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн найруулж хүний хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудлуудыг нарийн тусгаж, хүний эрхийн мэдрэмжтэй хууль баталсан г.м<sup>56</sup>

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцын хэрэгжилтийн талаар Монгол Улсын 5 дугаар тайлан илтгэлийг НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос хэлэлцээд ирүүлсэн зөвлөмжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, ЦЕГ-тай хамтран цахим орчин дахь зохистой хэрэглээг бий болгох, хүүхдийг цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүний дотор хүн худалдаалах, хүн хулгайлах, бэлгийн мөлжлөг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “UNFRIEND” тусгай арга хэмжээг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх агуулга бүхий 55 постер, 15 видео сурталчилгаа, нэвтрүүлэг, 1 дуу бүтээж 31 телевиз, олон нийтийн цахим сүлжээгээр түгээсэн нь давхардсан тоогоор 6,101,000 хүнд хүрсэн байна.

<sup>55</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.4.1 дахь заалт

<sup>56</sup> Department of state-USA, Trafficking in persons report, 2022, page 392

Чанарын судалгааны үр дүнгээс харахад Монгол Улс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр НҮБ, АНУ-ын төрийн департамент болон бусад олон улсын байгууллагуудын зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч ажилладаг. Монгол Улс биеэ үнэлэлтийг зохион байгуулах гэмт хэргийг Эрүүгийн хуулиар ял шийтгэдэг байсныг 2017 онд өөрчилж Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэх болсон нь эрх зүйн хувьд ухралт болж, 2018 оны АНУ-ын төрийн департаментын гаргасан тайланд “Tier 2”<sup>57</sup>–оос “Tier 2 Watchlist” –рүү орсон байна. Ийнхүү олон улсын байгууллагын зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд эргэн “Tier 2” жагсаалтад орсон байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллаж байгаа нь гадаадын улс орноос санхүүжилт авахад нөлөөлж байна. Тухайлбал, 2020-2024 онд хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах чиглэлээр хэрэгжих “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төсөл”-ийн 5 сая ам.долларын буцалтгүй тусламжийг АНУ-ын төрийн департаментас олгосон тухай холбогдох байгууллагуудын төлөөллүүд дурдсан.

Мөн ГХУСА33АА-наас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл рүү тайлан мэдээгээ тогтмол явуулж хамтран ажиллаж байна.

1. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний протокол
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, түүний нэмэлт протокол
3. Хүүхдийн эрхийн тухай конвенц,
4. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол,
5. Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт мэдээлэл хүргүүлэх журмын тухай III протоколын хэрэгжилтийн тайланг өгч байна.

**Үйл ажиллагаа 2:**<sup>58</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх болон энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид үзүүлэх зарим үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хүрээнд “**үр дүнтэй**” байна.

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл 55 хүнийг оролцуулж зөвлөмж гаргаж холбогдох байгууллагуудад хүргэсэн. Мөн олон улсын байгууллагуудын санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд төсрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал Нидерланд улсын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төслийг Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэжээ. Үүнд:

<sup>57</sup> АНУ-ын төрийн департаментас жил бүр дэлхийн улс орнуудыг “Tier 1-Сайн”, “Tier 2-Дунд”, “Tier 2 Watch list-Анхаарах шаардлагатай”, “Tier 3-Муу” гэх ангиллаар ангилдаг. Энэ нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тухайн улсын засгийн газар хэрхэн ажиллаж байгааг илтгэх үзүүлэлт юм.

<sup>58</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.4.2 дахь заалт

- Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх “Мөрөөдлийн шүхэр” мэдээллийн аян, мэдээллийн аяны дараа 18-27 насны 500 охид, эмэгтэйчүүд дунд мэдлэг, хандлага, үйлдлийг тогтоох судалгаа хийсэн;
- МигАпп гар утасны аппликейшнийг Монгол хэл дээр хөгжүүлж иргэдэд хүргэж эхлээд байна;
- Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлийн талаар олон нийтэд сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилго бүхий “Даван туулагчийн түүх” баримтат кино бүтээж олон нийтэд хүргэсэн;
- Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын тухай суурь судалгаа хийсэн;
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж тогтоох, туслалцаа үзүүлэхэд хамтран ажиллах тухай сургалт хийсэн;
- Хүн худалдаалах тухай мэдлэг, ойлголт өгөх цахим сургалт боловсруулах ажил 2021 оны 9 дүгээр сард эхлүүлсэн.

БНСУ-ын Жендерийн тэгш эрх, гэр бүлийн яамтай 2019.05.01 -ний өдрөөс эхлэн 5 жилийн хугацаатай “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх төсөл” -ийг Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, ялангуяа хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгт өртсөн охид, эмэгтэйчүүдэд туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, тэднийг эдийн засгийн хувьд нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх дараах араг хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тогтоох удирдамжийг төслийн багийн уулзалтаар хэлэлцэж, уулзалтаас гарсан санал зөвлөмжийг нэмж, тусгасан;
- Анхан шатны туслалцаанд 20 үйлчлүүлэгч хамруулсан;
- Хамгаалах байранд хоёр хохирогчийг 25 хоногийг хугацаатай түр байрлуулсан;
- Хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээнд 3 хэргийн 4 хохирогчийн эрх ашгийг хамгаалан ажиллуулахаар өмгөөлөгч нартай хамтран ажиллаж байна.

Монгол Улсад ГХУСА33АА хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн “Хүйсийн тэгш эрх төв” ТББ –тай хамтын ажиллагааны урт хугацааны гэрээ байгуулсан. Гэрээний үр дүнд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, энэ чиглэлийн сургалтын үйл ажиллагааг албан хаагчдад зохион байгуулах, хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, мэдээлэл авах утсыг ажиллуулах зэргээр хамтран ажиллаж байна.

**Үйл ажиллагаа 3:**<sup>59</sup> Монгол Улсын иргэд ихээр зорчдог, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий улс орнуудтай хамтран ажиллах, тогтмол мэдээлэл солилцох сувгийг бий болгож, хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагааг **“тодорхой үр дүнтэй”** гэж үнэлэв.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаас үзэхэд Монгол Улсын иргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох өндөр магадлалтай гадаад улсуудтай хамтын ажиллагааг

<sup>59</sup> Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 3.4.3 дахь заалт



өргөжүүлэхэд илүүтэй анхаарчээ. Тухайлбал 2018 онд БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Засгийн газартай хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан, ялтан шилжүүлэх тухай гэрээг Бүгд Найрамдах Казахстан Улстай 2018 онд байгуулсан, 2019 онд Монгол Улсын иргэд олноор зорчдог Малайз, Тайланд зэрэг улстай эрх зүйн туслалцааны хэлэлцээрийг байгуулсан. Малайзын талтай тухайлан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан байна.

Мөн НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын Монгол Улсыг хариуцсан захирал Кросетиттэй 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдөр уулзалт зохион байгуулж гадаад улс дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа 30 консулын ажилтнуудыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр цахим сургалтад хамруулсан. 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Бээжин хотод Монгол Улс, БНХАУ-ын ГХЯ хоорондын 19 дэх удаагийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан бөгөөд уулзалтын үеэр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цахим залилан, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, консулын хамгаалалт буюу иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах асуудлаар зөвлөлдсөн. Уулзалтын дараа БНХАУ-ын Хууль зүйн яам, Нийгмийг аюулаас хамгаалах яам, Ардын дээд шүүх, Ардын дээд прокурорын газрын холбогдох удирдлагуудтай уулзалт хийж үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Төрийн департамент хооронд байгуулсан Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн Хүүхэд хамгааллын компакт гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр баталгаажуулж, 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг эх оронд нь эгүүлэн авчрах, буцаах, нийгмийн хамгаалал, эрх зүйн цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байна. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага нь эх орондоо эргэж ирэх иргэдэд замын зардлын дэмжлэг үзүүлдэг бөгөөд салбар байгууллагуудаараа дамжуулан гадаадад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлан ажиллаж байна.

Чанарын судалгааны үр дүнгээс харвал үндэстэн дамнасан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, Монгол Улсын иргэд ихээр зорчдог, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэл бүхий улс орнуудтай мэдээлэл солилцох хамтын ажиллагааг тогтмол хийж байна. Үүний үр дүнд гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэдийг олж ирлүүлэх, эх оронд нь авч ирж мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ч хүн худалдаалах, хөдөлмөрийн мөлжлөгт Монгол Улсын иргэд өртөх өндөр магадлалтай, визгүй зорчдог улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд анхаарах хэрэгцээ байсаар байна. Жишээ нь Бүгд Найрамдах Турк улс руу сүүлийн жилүүдэд зорчих хөдөлгөөн нэмэгдэж байгаа төдийгүй тухайн улсад очоод хөдөлмөрийн мөлжлөгийн хохирогч болон зугтаж эх орондоо иргэн ирсэн кейс гарсан тухай холбогдох байгууллагын төлөөллүүд дурдсан.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой гадаад хамтын ажиллагаа сайжирсан ч Ковид-19 цар тахлын улмаас тогтоосон улс, орны хил хаалттай байсан учраас хөтөлбөр хэрэгжих хугацаанд хилээр нэвтрэх иргэдийн зорчих урсгал огцом буурчээ.



---

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ**

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ

Улсын Их Хурлаас 2020 оны 05 дугаар сарын 07–ны өдөр шинэчлэн баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21.4, Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолын 2, 5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сарын 09–ний өдөр “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”–ыг шинэчлэн баталсан. Тус журмын 8 дугаар хавсалт болох “Бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээний дүн”–г үндэслэн Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24–ны өдрийн 148 дугаар тогтоолын хавсралтаар баталсан аргачлалаар Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээг хийлээ.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь нийгэм, олон нийт болон зорилтот бүлгийн иргэд, төрийн, олон улсын, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа тухай энэхүү бүлэгт оруулсан болно.

*Хүснэгт 12. Үр нөлөөний үнэлгээ хийх хүрээ*

№	Нийгмийн нөлөөлөл	Үр нөлөөний үнэлгээ хийсэн хүрээ
1	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөлөл	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлсэн зорилтот бүлгүүдийг тодорхойлсон Эдийн засагт үзүүлсэн нөлөөг тооцоолсон
2	Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөлөл	Зорилтот бүлгүүдэд үзүүлсэн нөлөөг тодорхойлсон
3	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлсэн нөлөө	Бодлогыг хэрэгжүүлэх явцад бий болсон хууль, эрх зүйн шинэчлэлүүдийг оруулсан
4	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлсэн нөлөө	Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлсэн нөлөөний тухай бичсэн

### 4.1. Үндэсний хөтөлбөрийн зорилтот бүлгүүд

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт болох Бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээний дүнгийн А буюу Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөллийн нэгдүгээр хэсэгт тус хөгжлийн бодлогын үр нөлөө хүртсэн зорилтот бүлгийг тодорхойлохоор заасан.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үр нөлөөг хүртсэн зорилтот бүлгийг дараах байдлаар тодорхойлсон.

- Байгууллагын албан хаагчид /төрийн, иргэний нийгмийн байгууллага, хувийн байгууллага/
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид
- Иргэд, олон нийт
- Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд



## 4.2. Эдийн засагт үзүүлсэн нөлөө

“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжсэнээр гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа эрчимжиж, хүн худалдаалах гэмт хэргийн холбогч, хохирогчийн тоо нэмэгдэхээс урьдчилан сэргийлсэн. .

Хүснэгт 13. Эдийн засгийн таамаглал

	2017	2018	2019	2020	2021
Илрүүлсэн гэмт хэргийн хохирогчийн тоо	46	26	65	39	26
Эдийн засгийн зардал /төгрөгөөр/	115,000,000	65,000,000	162,500,000	97,500,000	65,000,000

Нэг хүний дундаж зардлыг 2,500,000 төгрөгөөр тооцоолов

Хүн худалдаалах гэмт хэргийг хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээний дундаж зардал 800-1000 ам.доллар байдаг аж<sup>60</sup>. Үүнийг Монгол төгрөгт шилжүүлбэл дунджаар нэг хүнийг нөхөн сэргээх зардлыг 2.5 сая төгрөгөөр тооцоолон дээрх эдийн засгийн таамаглал тооцоог судалгааны багийн зүгээс хийлээ. Дээрх тооцоололд нөхөн сэргээхээс бусад /тээвэр, өмгөөлөгч гм/ зардлыг оруулаагүй.

Мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон тэдгээрийн өрхийн эдийн засагт дараах байдлаар нөлөөлсөн байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлж, мэргэжлийн сургалтад хамруулснаар тухайн хүн, түүний гэр бүлийн орлого нэмэгдэхэд нөлөөлжээ. Цаашлаад ажлын байр нэмэгдэх, өөр бусдыг ажлын байраар хангах, хохирогч хамгаалах байрны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэх мэт эерэг нөлөөллүүд бий болдог тухай чанарын судалгаанд хамрагдсан байгууллагын төлөөллүүд дурдсан юм.

Шигтгээ 2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эдийн засагт үзүүлсэн нөлөө

Манайхаас үйлчилгээ аваад мэргэжлийн сургалтад суусан хүүхдүүдээ ажлын байранд гараад эхний орлогоо олж эхлэх хүртэл нь дэмжихийг хичээж ажилладаг. Жишээ нь нэг хохирогч хумсны маникюр хийдэг боллоо гэхэд эхний орлогоо олж эхлэх хүртэлх сургалт, сургалтад суух хугацааны урсгал зардал, ажлын байрын түрээс, эхний ээлжид ашиглах хэрэгслээр нь бүрэн хангадаг. Манайхаас үйлчилгээ авч мэргэжилтэй болоод гарсан охидоос одоо зарим нь салонтой болчихсон доороо хүмүүс цалинжуулаад явж байгаа. Заримдаа ирж хамгаалах байрны хүүхдүүдэд хандив өгдөг.

Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас

## 4.3. Нийгэмд үзүүлсэн нөлөө

### 4.2.1. Албан хаагчид

**Төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдад** энэ төрлийн мэдлэг мэдээллийг түгээх сургалт нь олон эерэг нөлөөллийг бий болгожээ. Тодруулбал ажилтан албан хаагчид сургалт, мэдээллийн ажилд оролцсоноор хүн худалдаалах гэмт хэрэг нь зөвхөн бэлгийн мөлжлөг бус өргөн цар хүрээтэй, онц ноцтой гэмт хэрэг гэдгийг мэдэж авдаг.

<sup>60</sup> Хүйсийн тэгш эрх төв ТББ-аас өгсөн мэдээлэл

Түүнчлэн гэмт хэргийн хохирогчид илрэх шинж тэмдэг, хохирогчтой хэрхэн харьцах, үйлчилгээ үзүүлэх зэрэг мэдлэгийг олж авчээ.

Ийнхүү дээрх зүйлсийн мэддэг болсноор хил гааль болон бусад байгууллагууд хяналтын үйл ажиллагаа сайжирч, гэмт хэргийн илрүүлэлт нэмэгджээ.

*Шигтгээ 3. Төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдад үзүүлсэн нөлөө, хохирогч илрүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн тухай*

*Сургагч багшийн сургалт маш үр дүнтэй байсан. Урьд нь хүн худалдаалах гэмт хэрэг гэхээр биеэ үнэлүүлэх хэлбэрээр л илэрдэг гэж боддог байсан бол сургалтад суугаад энэ асуудлыг харах өнцөг тэлсэн. Зөвхөн биеэ үнэлэлтээс гадна, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтнийг худалдаалах гэх мэт төрлүүдээр бас илэрдэг юм байна гэдгийг ойлгосон.*

*Хөдөлмөрийн улсын байцаагч нар бүгд өөр өөр мэргэжилтэй өөр өөр салбарын хүмүүс байдаг тул хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг гэх мэт ойлголтуудыг сайн ялгадаггүй. Тиймээс сургалт хийснээр мэргэжилтэн, албан хаагч байцаагч нар нэгдсэн нэг ойлголттой болж авдаг. Зөрчлүүдийг хэрхэн яаж ялгах хэрэгтэй, бид нар үүнийг юу гэж ойлгох юм, яаж оролцох юм гэх мэт мэдлэг мэдээллийг олж авсан нь хамгийн том давуу тал үүнийгээ өдөр тутмын ажил дээрээ ашиглаж байгаа.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Түүнчлэн төрийн байгууллагын албан хаагчдад мэдлэг, мэдээлэл өгснөөр хохирогч төвтэй хандлага төлөвших суурь болсон байна. Өмнө нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хууль хүчний байгууллагын ажилтнууд гэм буруутан мэтээр харж хэргээ хаах үйл ажиллагаанд төвлөрдөг байсан бол сүүлийн үед энэ байдал өөрчлөгдөж хүний эрхийг дээдэлсэн, хохирогч төвтэй хандлага бий болоход нөлөөлж байна гэж судалгаанд хамрагдсан төлөөллүүд дурджээ.

*Шигтгээ 4. Төрийн байгууллагын албан хаагчдад үзүүлсэн нөлөө, хохирогч төвтэй хандлага төлөвшиж байгаа тухай*

*Хүний эрхийг хангаж ажиллах хандлага бий болж байна. Өмнө нь хэрэг шийдвэрлэлтэд түлхүү анхаардаг байсан бол одоо хэрэг хянан шалгах ажиллагааны явцад хүний эрх тал руугаа илүү анхаарч, хүмүүсээ чадавхжуулж байна. Ийнхүү чадавхжуулснаар хүний эрхийг дээдэлсэн үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлж байна.*

*...энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид олон дахин сэтгэлийн шарх үүсгэхгүй байх, нүүр царайг нь ил гаргахгүй байхад илүү анхаардаг болсон юм шиг санагддаг.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Мөн төрийн байгууллагын ажилтан, албан хаагчид тухайн үйл ажиллагаанд оролцох үүрэг, хуулиар хүлээсэн хариуцлагаа ухамсарлаж хэрэгжилтийг хангахад анхаарах болжээ. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаанд холбогдох байгууллагын удирдлагууд нэг баг болж хамтран ажилласнаар хүн худалдаалахтай тэмцэх нь зөвхөн цагдаа, хууль сахиулах байгууллагын үүрэг бус төрийн болон төрийн бус, олон улсын холбогдох бүх байгууллагууд хамтын ажиллах хэрэгтэйг ойлгох болсон. Өөрийн байгууллагын тодорхой чиг үүргийг биелүүлэхийн тулд удирдлагууд манай байгууллага буюу миний зүгээс хэрхэн ажиллах боломжтой байна, байгууллагынхаа нэгдсэн төлөвлөгөөнд хүн худалдаалах гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх чиглэлээр юу хийж болох талаар өөрийн байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбон харж, төлөвлөгөөндөө тодорхой үйл ажиллагаа тусгахад анхаардаг болжээ.

*Шигтгээ 5. Төрийн байгууллагын албан хаагчдад үзүүлсэн нөлөө, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах болсон тухай*

*Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа илүү сайжирч байна. Би өөрөө дэд зөвлөлд байдаг. Мөн он дуусахаас өмнө байгууллагынхаа дараа жилийн ажлыг төлөвлөнө. Тухайн төлөвлөгөөндөө хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлуудыг оруулах бодолтой байгаа.*

*Хөтөлбөр хэрэгжсэнээр хуулиар хүлээсэн чиг үүргээ байгууллагууд ухамсарладаг юм байна лээ. Хөтөлбөрийн тайлан гаргах хэрэг гардаг болохоор үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн чиг үүргээсээ оруулаад биелүүлээд явдаг юм. Мөн байгууллагууд хоорондоо холбогдож, харилцан санаа авч ажиллаж болдог юм байна гэдгийг ойлгосон, хэн нэг хүн эсвэл байгууллага ажиллах биш бүгдээрээ ажиллах хэрэгтэй гэдгээ ойлгох цогц мэдээлэл авч байгаа юм.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Өмгөөлөгч, сэтгүүлч, иргэний нийгмийн байгууллага, хувийн аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудад нөлөөллийн ажлыг хийснээр тодорхой үр дүнд хүрчээ.

Өмгөөлөгчдийн хувьд хохирогчийн нийгэм, сэтгэл зүйн байдлыг ойлгох, сэтгэл зүйн гэмтлийг нэмэхгүй байх, сэтгэл зүй, эрүүл мэндийг хохирлыг бүрэн барагдуулахад анхаарах зэрэг илүү мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх чадвар нэмэгджээ.

*Шигтгээ 6. Өмгөөлөгчдөд үзүүлсэн нөлөө*

*...бид нарыг сургалтад суулгаж байгаад дараа нь дүүргүүдийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст хуваарилж бүртгээд зорилтот бүлэгт үнэ төлбөргүй өмгөөлөл үзүүлэх чиглэлээр зохицуулалт хийсэн. Тухайлбал аливаа төрлийн гэмт хэрэг хүчирхийллийн хохирогчид хорооныхоо цагдаад ханддаг, тухайн хорооны цагдаа нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст хэргийн талаар мэдэгдэнэ, тухайн хохирогчийн хэрэгт өмгөөлөгч хэрэгтэй боллоо гэхэд өмгөөлөгч нарт хандаад Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтсээс тодорхой санхүүжилт аваад үйлчилгээг үзүүлнэ гэсэн гуравласан үйл ажиллагаа хэрэгжүүлнэ гэсэн нь маш зөв санагдсан. Өмгөөлөгч нар жилдээ 2-3 хохирогчдыг цэвэр өөрөөсөө бүх зардлыг нь гаргаад өмгөөлөх тохиолдол байдаг ч 20-30 хүнийг үнэ төлбөргүй өмгөөлнө гэж байхгүй.*

*Өмгөөлөгч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулдаг. Манайд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ байдаггүй болохоор энэ орон зайг нөхөх сургалт зохион байгуулахад сургалтад суусан өмгөөлөгч нартайгаа хамтарч ажиллаад утас, унаа гэх мэт урсгал зардлыг нь гаргаад өмгөөллийн үйлчилгээг үнэгүй үзүүлдэг. Гол давуу тал нь энэ төрлийн гэмт хэрэгтэй илүүтэй мэргэшчихдэг болохоор хэрэг дээрээ илүү сайн ажилладаг.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Сэтгүүлчдийн хувьд илүү урт хугацааны туршид нөлөөллийн ажлыг хийж байгаа буюу сүүлийн 8 жил сургалтад хамруулж хамтран ажиллаж байгаа хэмээн дурдсан. Эрэн сурвалжлах буюу гэмт хэрэгтэй холбоотой мэдээ, мэдээлэл бэлддэг сэтгүүлчид цагдаа, хууль сахиулах байгууллага, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын байгууллагууд зэрэг олон төрлийн эх сурвалжаас мэдээ мэдээлэл бэлтгэн хүргэдэг болсон нь хүн худалдаалахтай холбоотой мэдээллийг цагдаад өгөхөөс айдаг бол нийгмийн ажилтанд, хүүхдийн тусламжийн утаст өгч болох юм гэсэн ойлголтыг олон нийтэл өдөг байна. Түүнчлэн сэтгүүлчид хүний хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй хандаж асуудал, шийдэл рүү анхаарах болсон төдийгүй редакцын соёл бага багаар бий болж байна гэж чанарын судалгаанд оролцсон төлөөллүүд дурджээ.

#### *Шигтгээ 7. Сэтгүүлчдэд үзүүлсэн нөлөө*

*Бид нар сэтгүүлчдийг бэлддэг, бид нар сэтгүүлчдэд ямар шаардлага тавьдаг вэ гэхээр нэг ярилцлага авахдаа хамгийн багадаа 4-өөс доошгүй эх сурвалжаас мэдээлэл ав гэдэг. Ингэснээр нийгэмд хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа, нийгэм хамгааллын үйлчилгээ үзүүлэгч талаар хүрэх мэдээлэл цогц болдог. Тэгээд хохирогч би энэ асуудлын тухай заавал цагдаа биш нийгмийн ажилтандаа ч хэлж болох юм байна гэдгийг олж мэддэг. Хүүхдээр гуйлга гуйлгуулаад байвал 108 руу хэлэх юм байна гэсэн мэдээллийг авч чаддаг. Энэ мэт мэдээлэл аль болох олон хүнд очих тусам хүмүүсийн оролцоог нэмэгдүүлж байгаа юм.*

*Сэтгүүлчдийн гаргаж байгаа мэдээллийг хараад байхаар зарчмын өөрчлөлтүүд маш их гарч байгаа. Өмнө нь гэмт хэрэг гарлаа гэхэд айлын гэр, хүний зураг, хаяг гэх мэтийг гаргаад л энд ийм зүйл болж ээ гээд ямар ч шүүлтүүргүй ханддаг байсан бол тийм мэдээллүүд багасаар асуудал руу, шийдэл рүү илүү анхаардаг мэргэшсэн сэтгүүлч бий болж байгаа. Өмнө нь ингэж сурсан сэтгүүлч цаг хугацааны явцад нэг редакц ахлаад явна. Үүнтэй холбоотой редакцын соёл гэдэг зүйл бий болж байгаа юм. Сэтгүүлчид хүний хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй ханддаг болсон.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Хувийн хэвшлийн байгууллагын ажилтан албан хаагчдын хувьд хөдөлмөрийн тухай хуулийн сургалт орсноор байгууллагын удирдлага болон ажилтнуудын зүгээс хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрлөх суурь зарчмын талаарх мэдлэгээ нэмэгдүүлдэг байна. Мэдлэг нь нэмэгдсэнээр өөрийн ажиллаж буй ажлын байранд хуулийн зүйл заалт зөрчигдөж байгаа эсэхэд ажилтан, албан хаагчид хяналт тавих, байгууллагын удирдлагын зүгээс хөдөлмөрийн тухай хуулийн зүйл заалтад зөрчилтэй үйл ажиллагаа байгууллагынх нь хүрээнд байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх боломжийг бий болгодог байна. Түүнчлэн албан хаагчид мэргэжилтнүүдээс хууль зүйн зөвлөгөө, тусламж авахаар ханддаг бөгөөд тэднээс ирсэн асуултын урсгалд дүн шинжилгээ хийж дагаа дараагийн ажлын төлөвлөгөөнд тусган ажилладаг байна.

*Шигтгээ 8. Хувийн байгууллагын ажилтан, албан хаагчдад үзүүлсэн нөлөө*

*Байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчдын хувьд нөлөөллийн ажлуудыг хийснээр тухайн албан байгууллага хөдөлмөрийн гэрээн дээр юу тусгах хэрэгтэйгээ мэдэж авна, албан байгууллагын ажилтнууд юун дээр алдаа гарч байгааг юун дээрээ анхаарах шаардлагатай гэх мэт хөдөлмөрийн хуулийн ойлголт, үндсэн зарчмуудыг мэдэж авч өөрийн ажилд болж байгаа болохгүй байгаа зүйлсийг тусгаж авдаг. Мөн хөдөлмөрийн тухай хуулийн талаарх сургалтын ажлыг хийх явцад хүмүүс өөрт тулгарсан хаанаас мэдээлэл авахаа мэддэггүй хууль зүйн зөвлөгөө асуултуудыг маш их асуудаг. Хүмүүсийн асуудаг асуултын хүрээнд манай байгууллага дээд шатны байгууллагатаа мэдээ тайлан илгээж энэ тал дээр ийм байдлаар ажиллая гэх чиглэлийг гаргаж ирдэг.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

**4.2.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид**

**Хохирогчид** үзүүлж байгаа хамгийн гол нөлөө бол тэдгээр хүмүүс өөрийгөө гэмт хэргийн хохирогч болсон гэдгээ мэдэх явдал байв. Тодруулбал хохирогч өөрийгөө гэмт хэргийн хохирогч болчихлоо, энэ төрлийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг, хууль зөрчсөн үйл ажиллагаа буюу өөрийнх нь эрхэд халдаад байгаа зүйл гэдгийг мэддэггүй байсан. Харин үндэсний хөтөлбөрийн хүрээнд хохирогчдыг илрүүлэх үйл ажиллагаа эрчимжсэнээр хохирогч гэмт хэргийг хохирогч болсноо мэдэж дараа дараагийн хамгааллын арга хэмжээг авч эхэлжээ.

*Шигтгээ 9. Хохирогчид үзүүлсэн нөлөө, гэмт хэргийн хохирогч гэдгээ мэдэж авдаг тухай*

*Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг илрүүлж авч ирээд та энэ гэмт хэргийг хохирогч болсон байна гэдэг. Гэтэл хохирогчид энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон гэдгээ мэддэггүй. Ямар гэмт хэрэг, би өөрөө л үйлдсэн шүү дээ гэдэг.*

*Хохирогч хүүхдүүд хэзээ ч өөрийгөө биеэ үнэлэгч гэж хэлэхгүй, бэлгийн мөлжлөгт өртсөн гэж ч хэлэхгүй. Анхан шатны бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд тэрийгээ энгийн үзэгдэл шиг ойлгоод, нөхцөл байдалтай эвлэрчихсэн байдаг.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Ийнхүү хохирогчийг хамгаалалтад авч үйлчилгээ үзүүлснээр нийгэм, сэтгэл зүйн болон эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж хэвийн амьдралд ороход тусалж чадсан. Эрүүл мэндийн хувьд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид бэлгийн замын халдварт өвчин болон бусад төрлийн бие мах бодын хохирол авсан байдаг. Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг эмчлүүлснээр энэ төрлийн өвчин цаашаа дамжих эрсдэлээс хамгаалж байна.

*Шигтгээ 10. Хохирогчид үзүүлсэн нөлөө, эрүүл мэндийн үйлчилгээ авсан тухай*

*Авч ирсэн хохирогчдын ихэнх нь тэмбүүтэй нэмээд бусад дайвар өвчинтэй байдаг. Хохирогч охид тэмбүүтэйгээ мэддэггүй, авч байгаа хүмүүс нь мөн цаанаа гэр бүлтэй гэх мэтээр бэлгийн замын халдварт өвчин бол замаа алдаж байгаа. Бид нар нэг ч болтугай хүний бэлгийн замаар дамжих өвчнийг илрүүлж эмчилснээрээ өөр олон хүнийг эрсдэлээс хамгаалж байгаа юм.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Сэтгэл зүйн үйлчилгээний хувьд хохирогчид нөхөн сэргээх үйлчилгээг нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдээс гадна, СЭМҮТ-ийн эмч мэргэжилтнүүд үзүүлдэг байна. Ийнхүү сэтгэл зүйн эмчилгээ үйлчилгээ үзүүлснээр хүүхэд гэр бүлдээ эргэн нэгдэх, дахин гэмт хэрэгт өртөхгүй байх, өөр бусдыг гэмт хэрэгт татан оруулахгүй байх үндсийг бий болгосон байна.

*Шигтгээ 11. Хохирогчид үзүүлсэн нөлөө, сэтгэл зүйн үйлчилгээ авсан тухай*

*...сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудал маш чухал. Хүн худалдаалахын хохирогч хүүхдүүдэд СЭМҮТ-ийн сэтгэлзүйн оношилгоонд оруулаад 5 хүүхдэд нь одоогоор мартаж үйлчилгээ үзүүлээд, удаан хугацааны эмчилгээнд оруулж байгаа. Нөхцөл байдалтай эвлэрээд байх л ёстой зүйл юм шиг хүлээж авдаг болчихсон байдлыг нь залруулаад хэлж тайлбарлаад үйлчилгээ үзүүлээд ирэхээр эргээд хүүхэд энэ нь байж болох нөхцөл байдал биш гэдэг ээ ойлгоод, гэр бүлдээ эргэн нэгдэх гэх мэтээр энэ үйлчилгээ үр дүн гэрдэг.*

*Цагдаагийн байгууллагатай хамтран ийм төрлийн гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлснээр дараа дараагийн хүүхдүүдэд нэг нэгнийгээ даган дуурайхгүй байх, уруу татахгүй байх, нэгнийгээ буруу зам руу оруулахгүй байхад нөлөөлж байгаа гэж үзэж байгаа.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын гэр бүлийн асуудал хамгийн чухал байдаг бөгөөд нэг хохирогчид үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхийн тулд ар гэрт нь анхаарч мөн ижил үйлчилгээ үзүүлжээ. Энэ нь эргээд тухайн гэр бүлийн эрүүл харилцааг бий болгох, гэр бүлийн гишүүдийг бусад эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалах нөхцөлийг бүрдүүлж байна.

*Шигтгээ 12. Хохирогчийн гэр бүлд үзүүлсэн нөлөө*

*...хүүхдээр дамжуулаад дараа дараагийн гэр бүлийн асуудлаас урьдчилан сэргийлж, хамгаалж байгаа гэж харж байна.*

*Ар гэрийн нөхцөл байдал хүнд байвал ар гэрт нь давхар үйлчилгээ үзүүлээд явдаг.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

### **4.2.3. Олон нийт**

**Олон нийтэд** чиглэсэн ажлын хүрээнд иргэд энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдээлэх үүргээ мэддэг болсон нь хамгийн эерэг үр нөлөө байв. Иргэд, олон нийт мэдээлэх үүргээ мэддэг болсноор энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэх болон холбогдох утсанд ирэх дуудлагын тоо нэмэгдэж байна хэмээн мэргэжилтнүүд үзэж байна.

*Шигтгээ 13. Олон нийтэд үзүүлсэн нөлөө, мэдээлэх үүргээ ухамсарласан тухай*

Урьд нь хүмүүс хүчирхийллийг мэдсэн ч мэдээгүй юм шиг өнгөрдөг, хэн нэгэнд ч юм уу, холбогдох байгууллагад мэдээлэх ёстойгоо мэддэггүй байсан. Сүүлийн жилүүдэд цахим орчин дахь мэдээллийн урсгал эрс идэвхтэй болж, ЦЕГ-аас иргэдэд энэ төрлийн мэдээллийг мэдээлэх ёстой шүү гэдгийг нь илүү таниулж, сурталчилж мэдээлэх болсон тул иргэд мэдээлэх үүргээ ухамсарладаг болсон. Үүнтэй холбоотой хүмүүс мэдээлэх ёстой гэдгээ ойлгодог болсон.

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Хөдөлмөрийн мөлжлөгтэй холбоотой нөлөөллийн ажлуудыг хийж, энэ чиглэлийн асуудалд анхаарах болсонтой холбоотой хүмүүсийн уламжлалт хандлага өөрчлөгдөж эхэлжээ. Ийнхүү иргэд хүүхдийн хөдөлмөр мөлжлөгтэй холбоотой асуудлууд дээр анхаарч дуу хоолойгоо нэгтгэдэг болсон байна. Жишээ нь хүүхдээр хурдан морь унуулах асуудалд анхаарах болсон бөгөөд хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт заалтууд орж, холбогдох стандарт дүрэм журам батлагджээ.


*Шигтгээ 14. Олон нийтэд үзүүлсэн нөлөө, уламжлалт хандлага өөрчлөгдөж байгаа тухай*

Олон нийтийн хувьд уламжлалт хандлагаар зөв мэт хардаг байсан зүйлс болох хүний эрхийн зөрчил, хөдөлмөрийн мөлжлөгийн асуудлуудыг нийгмээрээ анзаарч хардаг болсон. Тодруулбал, хамаатан айлдаа амралтаараа хүүхэд харах, хөдөө айлд очиж мал маллах, хүүхэд хурдан морь унах гэх мэт хүүхдийн хөдөлмөрийн мөлждөг байсан уламжлалт хандлагуудыг зөрчил гэж хардаг болсон.

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*


Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 50.0 хувь нь хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар нэг мэдээлэл сонсож байсан байна. Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан иргэдийн 49.0 хувь нь энэ төрлийн гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар нэг мэдээлэл сонсож байсан бол орон нутагт амьдардаг иргэдийн 75.0 хувь нь ямар нэг мэдээлэл сонсож байжээ. Харин судалгаанд хамрагдсан гадаад улсад амьдардаг иргэд энэ төрлийн гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар нэг мэдээлэл сонсож, уншиж байгаагүй байна. Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх нь Улаанбаатар хотод амьдардаг иргэд байсныг харгалзан үзэх хэрэгтэй.

*График 28. Хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сонссон, хувиар, амьдарч буй байршлаар*




Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 41.7 хувь нь, эмэгтэйчүүдийн 51.2 хувь нь хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар нэг мэдээлэл сонсож байжээ. Мөн 3 эрэгтэй тутмын 1 нь мэдэхгүй гэж хариулжээ.

График 29. Хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар нэг мэдээлэл сонсож, уншиж байсан байдал, хүйсээр



Судалгаанд хамрагдсан хүн худалдаалах гэмт хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ямар нэг мэдээлэл сонсож, уншиж байсан иргэдийн 27.3 хувь нь интернэт орчин ашиглаж мэдээлэл авсан байна. Тэдний 21.8 хувь нь телевиз, радиогоос мэдээлэл авсан бол 14.5 хувь нь хэвлэмэл материал болох брошур, ном, сонин, сэтгүүлээс уншжээ.

График 30. Мэдээллийн эх үүсвэр, давхардсан тоогоор




Судалгаанд хамрагдсан иргэдийн 66.0 хувь нь “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг ач холбогдолтой гэжээ. Тус хөтөлбөрийн талаар сонсож байсан иргэд хөтөлбөрийг илүү ач холбогдолтой гэж үзэж байна. Тодруулбал, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн сонсож байсан иргэдийн 86.4 хувь нь хөтөлбөрийн ач холбогдолтой гэж үзэж байгаа бол сонсож байгаагүй иргэдийн 57.6 хувь нь хөтөлбөрийн ач холбогдолтой гэж үзэж байна.






График 31. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн талаар сонссон байдал, ач холбогдлоор




Судалгаанд хамрагдсан иргэдийн 50 гаруй хувь нь хөтөлбөр хэр амжилттай хэрэгжсэн талаар мэдэхгүй байна гэж хариулжээ. Тэдний 30 орчим хувь нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжсэн гэж үзэж байна.

График 32. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар, судалгаанд оролцогчдын хариулт




Улаанбаатар хотод амьдардаг судалгаанд хамрагдсан иргэдийн 38.8 хувь нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар сонсож байсан байна. Харин орон нутагт амьдардаг иргэдийн 75.0 хувь нь хөтөлбөрийн талаар сонсож байсан гэж хариулсан байна. Гадаад улсад амьдардаг иргэд тус хөтөлбөрийн талаар огт сонсож байгаагүй байна.

График 6. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар сонссон байдал, амьдардаг байршлаар



Судалгаанд хамрагдсан 3 эрэгтэй тутмын 1 нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар сонсож байжээ. Харин эмэгтэйчүүдийн 41.9 хувь нь тус хөтөлбөрийн талаар сонсож байсан байна.

График 7. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар сонссон байдал, хүйсээр



#### 4.2.4. Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд

**Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хувьд** хөтөлбөр хэрэгжиж хүн худалдаалах гэмт хэрэгт онцгойлон анхаарах болсноор илрэх гэмт хэргийн тоо нэмэгдэж, бүлэглэн гэмт хэрэгт үйлдэж байсан этгээдүүдийг барьж Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Мөн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг хорих ангид байх хугацаанд нь соён гэгээрүүлэх, хувь хүний хөгжилд чиглэсэн сургалтыг ордог төдийгүй МСҮТ–д өөрийн хүссэн мэргэжлийн боловсролыг эзэмшиж, ажилд зуучлуулах боломжоор хангадаг байна.

*Шигтгээ 15. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үзүүлсэн нөлөө, мэргэжил эзэмшиж болох тухай*

2018 онд ажлаа эрчимжүүлээд 9 бүлгийн 26 этгээдийг тогтоох ажлыг дүүрэг орон нутгаас албан хаагчид авч ирж ажиллуулаад олон хэрэг илрүүлж шүүхээр шийдүүлж хэрэгтнүүдэд 3-25 жилийн ял шийтгүүлсэн.

Сургалтын хувьд заавал суух ёстой болон заавал суух шаардлагагүй буюу сайн дурын гэсэн ангилалтай байдаг. Заавал суух ёстой сургалт нөлөөллийн ажилд бүх нийтээрээ суудаг...манайх дэргэдээ МСҮТ -тэй. Жил бүр тухайн төвд суралцах хүмүүсийг бүртгэдэг. Ял эдэлж байгаа этгээд өөрийн хүссэн мэргэжлээр сурах боломжтой байдаг бөгөөд тухайн мэргэжлээрээ суралцсан хүмүүст чадамжийг гэрчилгээ өгдөг, ялаас чөлөөлөгдөхөд нь ГБХЗХГ -аас ажилд жуучилж өгдөг.

Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас

#### 4.4. Бодлогын хэрэгжилтийн явцад бий болсон хууль, эрх зүйн шинэчлэл

Тус хөтөлбөр хэрэгжих хугацаанд хэд хэдэн хууль эрх зүйн өөрчлөлт шинэчлэл болсон байна. Тодруулбал:

- Биеэ үнэлэлтийг зохион байгуулах үйлдлийг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэдэг байсныг өөрчлөн, Эрүүгийн хуулийн 12.6-д тусгаж 2020 оны 01 –р сараас мөрдөгдөж



эхэлсэн. Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлд хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг тусгайлан заасан,

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан.
- Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан.
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон,
- Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага: MNS 6264:2018,
- Цэцэрлэг, ЕБС-ийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар баталсан,
- Аж ахуй нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг тусгуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн үлгэрчилсэн заавар баталсан.

#### 4.5. Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын тогтолцоонд үзүүлсэн нөлөө

##### 4.5.1. Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлсэн нөлөө

**Байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны хувьд** дараах өөрчлөлтийг бий болгожээ. Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтийн үйл ажиллагааг өргөсгөж 5 хүний бүрэлдэхүүнтэй болгосон. Ийнхүү хүний нөөцийн бүтэц өөрчлөгдсөнөөр илрүүлэх гэмт хэргийн тоо нэмэгдсэн гэж үзэж байна.

Мөн тухайн хэлтэст 2018 онд нийслэл, дүүргийн цагдаагийн газраас нэмэлт хүч төвлөрүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн 9 бүлгийн 26 хэргийг илрүүлж, тохирох ялаар шийтгүүлсэн байна. Энэ нь цаашид хохирох магадлалтай байсан иргэдийн хамгаалж, хохирсон байсан иргэдийг нөхөн сэргээж хэвийн амьдралдаа эргэн ороход томоохон нөлөө үзүүлсэн төдийгүй гадаад улсууд, олон улсын тусламжтай дараа дараагийн төслийг хэрэгжүүлж, санхүүжилтийг татах боломжийг бий болгожээ.

*Шигтгээ 16. Байгууллагын бүтцэд үзүүлсэн нөлөө*

*2018 онд ажлаа эрчимжүүлээд 9 бүлгийн 26 этгээдийг тогтоох ажлыг дүүрэг орон нутгаас албан хаагчид авч ирж ажиллуулаад олон хэрэг илрүүлж шүүхээр шийдүүлсэн. Үүний үр дүнд манайх саарал жагсаалтаасаа гэрч нэг шатаар ахисан үр дүнг үзүүлсэн. Ингэснээр дараа дараагийн хөрөнгө оруулалтыг татах ажлууд боломжтой болсон. Одоо хэрэгжиж эхэлж байгаа хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төсөл энэ үйл ажиллагааны үр дүнд хэрэгжиж байгаа нэг томоохон ажил юм. Энэ төслийн хүрээнд “Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс” гэж мөрдөн байцаах албад байгуулагдсан. Мөн дүүрэг орон нутгийн цагдаагийн алба нэгжүүдэд хоёр хоёр албан хаагч нэмэгдэж ажиллаж байна. Нийтдээ улсын хэмжээнд 110 албан хаагч нэмэгдсэн байгаа.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Тус хөтөлбөр хэрэгжсэнээр төрийн байгууллагууд болон бусад холбогдох олон улсын, ТББ-уудын хамтын ажиллагааг илүү өргөжүүлсэн чаджээ. Тодруулбал хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй зэрэгцэн Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл байгуулагдсан бөгөөд тухайн дэд зөвлөл тогтмол хурал уулзалт зохион

байгуулснаар өөр хоорондоо илүү сайн танилцаж, салбарын асуудлаа хэлэлцэх, нэгдмэл байр суурьтай болж чадсан байна.

Ийнхүү нэгдмэл байр суурьтай болох нь хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг нэгдсэн үйл ажиллагааг төлөвлөн, зохион байгуулалттай ажиллах суурь болох юм. Түүнчлэн байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргээ илүүтэй ухамсарлаж, харилцах суралцаж, жишээ авч ажиллаж байна.

*Шигтгээ 17. Байгууллага хоорондын хамтын ажиллагаанд үзүүлсэн нөлөө*

*Төрийн болон төрийн бус байгууллагууд дэд зөвлөл болоод хамтран ажилласнаараа бүх зүйлийг нэг цонхоор харж чаддаг болсон.*

*Салбар дундын хамтын ажиллагаа өргөжиж байгаа. НЭМҮТ, ЦЕГ, Мэргэжлийн хяналт зэрэг байгууллагуудтай энэ чиглэлээр хамтран ажиллах ажиллагаа эрчимжиж байна.*

*Олон байгууллагатай хамтран ажиллах шаардлага бий болдог манай байгууллагын хувьд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, ГХЯ, Гадаадын иргэн, харьяатын газар, ЦЕГ зэрэгтэй нягт хамтран ажилладаг. ХНХЯ-ны чиг үүрэг, оролцоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа.*

*Хөтөлбөр байснаараа хуулиар хүлээсэн чиг үүргээ байгууллагууд ухамсарладаг юм байна лээ. Хөтөлбөрийн тайлан гаргадаг болохоор үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн чиг үүргээсээ оруулаад биелүүлээд явдаг юм. Мөн байгууллагууд хоорондоо холбогдож, биесээсээ санаа авч ажиллаж болдог юм байна гэдгийг ойлгож байна.*

*Хүн худалдаалахтай тэмцэх нь хэн нэг хүн эсвэл байгууллага ажиллах биш бүгдээрээ ажиллах хэрэгтэй гэдгээ ойлгох цогц мэдээлэлтэй болж байна.*

*Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

#### 4.6. Үр нөлөөний үнэлгээний үр дүн

Өмнөх бүлгүүдэд үр нөлөөний үнэлгээг хэрхэн хийсэн, ямар үр нөлөө бий болсон талаар дэлгэрэнгүй дурдсан билээ. Дараах хүснэгтэд үндэсний хөтөлбөрийн бий болгосон үр нөлөөг хураангуйлан харууллаа.

Хүснэгт 14. Үр нөлөөний үнэлгээний үр дүн

№	Үр нөлөөний ангилал	Гол үр дүн
1	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлсэн нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын албан хаагчид /төрийн, иргэний нийгмийн байгууллага, хувийн байгууллага/</li> <li>- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид</li> <li>- Иргэд, олон нийт</li> <li>- Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд</li> </ul> <p>- Хэрэв хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжээгүй байсан бол энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоо жилд дунджаар 53 хувиар өсөх хандлагатай байсан гэж таамагласан. Ийнхүү өссөн бол 2020 онд хохирогчийн тоо 100, 2021 онд хохирогчийн тоо 153 болж тэдгээрт үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээний зардал 2021 онд дунджаар 320 сая төгрөг болох байсан байна.</p> <p>- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлж, мэргэжлийн сургалтад хамруулснаар тухайн хүн, түүний гэр бүлийн орлого нэмэгдэхэд нөлөөлжээ. Цаашлаад ажлын байр нэмэгдэх, өөр бусдыг ажлын байраар хангах боломжийг бий болгодог тухай чанарын судалгаанд хамрагдсан байгууллагын төлөөллүүд дурдсан юм.</p>
2	Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийгмийн хөгжилд үзүүлсэн нөлөөлөл	<ul style="list-style-type: none"> <li>- <b>Ажилтан албан хаагчид</b> сургалт, мэдээллийн ажилд оролцсоноор хүн худалдаалах гэмт хэрэг нь зөвхөн бэлгийн мөлжлөг биш бусад гэмт хэргүүдийг багтаасан өргөн ойлголт гэдгийг мэдэж авдаг байна. Ийнхүү хохирогчийг илрүүлэх ажил илүү үр дүнтэй явагдах болсон хэмээн үзэж байна.</li> <li>- Түүнчлэн төрийн байгууллагын албан хаагчдад мэдлэг, мэдээлэл өгснөөр хохирогч төвтэй хандлага төлөвших суурь болсон байна</li> <li>- Хөтөлбөрийн хэрэгжих хугацаанд холбогдох байгууллагын удирдлагууд нэг баг болж ажиллажээ. Хамтран ажиллаж төлөвлөх үйл ажиллагаанд оролцсоноор хүн худалдаалахтай тэмцэх нь зөвхөн цагдаагийн эсвэл хууль хүчний аль нэг байгууллагын үүрэг бус төрийн болон ТББ, олон улсын гэх мэт олон байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа чухал гэдгийг илүүтэй ойлгодог болсон.</li> <li>- Энэ төрлийн гэмт хэрэгтэй ямар нэг байдлаар холбогдож болзошгүй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын албан хаагчдад нөлөөллийн ажлыг хийснээр хохирогчийн нийгэм, сэтгэл зүйн байдлыг илүүтэй ойлгож, хохирлын барагдуулах, сэтгэл зүйн гэмтлийг нь нэмэхгүй байх гэх мэт зүйлс дээр анхаарч мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадвар нэмэгджээ.</li> <li>- Сэтгүүлчид хүний хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй ханддаг болсон бөгөөд асуудал, шийдэл рүү анхаардаг болсон төдийгүй редакцын соёл бага багаар бий болж байна гэж чанарын судалгаанд оролцсон төлөөллүүд дурджээ.</li> <li>- <b>Хохирогчдыг</b> илрүүлэх үйл ажиллагаа эрчимжсэнээр хохирогч гэмт хэргийн хохирогч болсноо мэдэж дараа дараагийн хамгааллын арга хэмжээг авч эхэлжээ.</li> </ul>

№	Үр нөлөөний ангилал	Гол үр дүн
		<ul style="list-style-type: none"> <li>- Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг эмчлүүлснээр энэ төрлийн өвчин цааш дамжих эрсдэлээс хамгаалж байна.</li> <li>- Сэтгэл зүйн эмчилгээ үйлчилгээ үзүүлснээр хүүхэд гэр бүлдээ эргэн нэгдэх, гэмт хэрэг рүү дахин орохгүй байх, өөр бусдыг гэмт хэрэгт татан оруулахгүй байх үндсийг бий болгосон байна.</li> <li>- Нэг хохирогчид үр дүнтэй үйлчилгээ үзүүлэхийн тулд ар гэрт нь анхаарч мөн ижил үйлчилгээ үзүүлжээ. Энэ нь эргээд тухайн гэр бүлийн эрүүл харилцааг бий болгох, гэр бүлийн гишүүдийг бусад эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалах нөхцөлийг бүрдүүлж байна.</li> <li>- <b>Олон нийтэд</b> чиглэсэн ажлын хүрээнд иргэд энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдээлэх үүргээ мэддэг болсон нь хамгийн эерэг үр нөлөө байв.</li> <li>- Иргэд хүүхдийн хөдөлмөр мөлжлөгтэй холбоотой асуудлууд дээр анхаарч дуу хоолойгоо нэгтгэдэг болсон байна.</li> <li>- <b>Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг</b> хорих ангид байх хугацаанд соён гэгээрүүлэх, хувь хүний хөгжилд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, МСҮТ –д өөрийн хүссэн мэргэжлийн боловсролыг эзэмшиж, ажилд зуучлуулах боломжийг бүрдүүлж өгдөг байдаг байна.</li> </ul>
3	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлсэн нөлөө	<ul style="list-style-type: none"> <li>- Тус хөтөлбөр хэрэгжих хугацаанд хэд хэдэн хууль эрх зүйн өөрчлөлт шинэчлэл болсон байна. Тодруулбал:</li> <li>- Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгт оноох ял шийтгэлийг тусгайлан заасан</li> <li>- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон</li> <li>- Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага: MNS 6264:2018</li> <li>- Эрүүгийн хуулийн 12.6 гэсэн шинэ зүйл заалтыг нэмэлтээр оруулж 2020 оны 1 –р сараас мөрдөгдөж эхэлсэн.</li> </ul>
4	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлсэн нөлөө	<ul style="list-style-type: none"> <li>- <b>Байгууллагуудын бүтэц, үйл ажиллагааны хувьд:</b> Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь 5 хүний бүрэлдэхүүнтэй болгосноор илрүүлэх гэмт хэргийн тоо нэмэгдсэн гэж үзэж байна. Мөн тус хэлтэст 2018 онд нийслэл, дүүргийн цагдаагийн газраас нэмэлт хүч төвлөрүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн 9 бүлгийн 26 хэргийг илрүүлж, тохирох ялаар шийтгүүлсэн байна. Энэ нь цаашид хохирох магадлалтай байсан иргэдийг хамгаалж, хохирсон иргэдийг нөхөн сэргээж хэвийн амьдралдаа эргэн ороход томоохон нөлөө үзүүлсэн төдийгүй гадаад улсууд, олон улсын тусламжтай дараа дараагийн төслийг хэрэгжүүлж, санхүүжилтийг татах боломжийг бий болгожээ.</li> <li>- Дэд зөвлөл тогтмол хурал уулзалт зохион байгуулснаар өөр хоорондоо илүү сайн танилцаж, салбарын асуудлаа хэлэлцэх, нэгдмэл байр суурьтай болж чадсан байна. Ийнхүү нэгдмэл байр суурьтай болох нь хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг нэгдсэн үйл ажиллагааг төлөвлөн, зохион байгуулалттай ажиллах суурь болох юм. Түүнчлэн байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ илүүтэй ухамсарлаж, харилцах суралцаж, жишээ авч ажиллаж байна.</li> </ul>

#### 4.7. Салбарын тулгамдсан болон цаашид анхаарах асуудал

Эрүүгийн хуулийн зарим зүйл заалтууд ойлгомжгүй байдал үүсгэдэг байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль эрх зүйн хувьд боловсронгуй байх нь нэн тэргүүний шаардлага бөгөөд хууль эрх зүйн хувьд тодорхой бус байх нь хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэж буй талд маш том давуу байдлыг бий болгож гэмт хэргийн шийдвэрлэх байдлыг илүү төвөгтэй болгох, ял завших боломжийг бий болгодог байна. Монгол Улс хүн худалдаалах гэмт хэргийн Эрүүгийн хуулийн 13.1-ээр шийдвэрлэдэг бөгөөд хүн худалдаалахтай ижил төстэй гэмт хэргүүдийг эрүүгийн хуулийн бусад зүйлээр зохицуулсан байдаг нь хуульд төөрөгдөл үүсэх, хэрэгтэн ял завших боломжийг бий болгодог хэмээн холбогдох байгууллагуудын төлөөллүүд үзэж байна. Жишээ нь өмгөөлөгч, цагдаагийн байгууллагын зүгээс Эрүүгийн хуулийн 13.1 хүн худалдаалах гэмт хэрэг мөн болохыг тогтоосон байхад шүүхээс хүн худалдаалах биш бэлгийн мөлжлөг гэж шийдвэрлэгдэхэд яллагдагч илүү цөөн жилээр эрүүгийн шийтгэл хүлээх боломжтой байдаг байна. Түүнчлэн хуулийн хүрээнд хөдөлмөрийн мөлжлөг, боолчлол зэргийг ойлгомжтой байдлаар тайлбарлаж ямар үед хүн худалдаалах гэмт хэрэгт орох ямар үед хөдөлмөрийн мөлжлөг болох эсэхийг нарын зааж ялгамжтай болгох хэрэгтэй байгааг холбогдох мэргэжилтэн, албан хаагчид дурджээ. Иймд улс орнуудын туршлагыг судалж, хүний эрхийн чиглэлээр ажилладаг мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөөнд үндэслэн хүн худалдаалах гэмт хэрэгт болон түүнтэй ижил төстэй гэмт хэргүүдийн зааг ялгааг маш нарийн гаргаж ойлгомжтой байдлаар тайлбарлах хэрэгтэй байна.

*Шигтгээ 18. Судалгаанд оролцогчдын сэтгэгдэл*

*Шүүх дээр 13.1 байна гэхээр бэлгийн мөлжлөг байна аа гээд алх тогшоод байгаа юм. Тэгэхээр бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэсэн 2 төрлийн гэмт хэргийн ялгаа заагийг хууль эрх зүйн хүрээндээ гаргах хэрэгтэй.*

*Эрүүгийн тухай хуульд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн ялгаа маш ойлгомжгүй, практикт ялгахад маш төвөгтэй байдаг. Хуульчдын зүгээс хүн худалдаалах бол хохирогчийг зорчих боломжгүй байдалд байлгадаг харин бэлгийн мөлжлөг зорчих эрхийг нь хязгаарлаагүй нөхцөлд байдаг гэж тайлбарладаг. Гэтэл орчин үед хохирогчийн зорчих эрхийг зөвхөн нэг газар гаргахгүй хорих гэхээс илүү интернэт орчныг ашиглан хязгаарлах явдал байна. Эрүүгийн хуулиар бол интернэт сүлжээ ашиглах тухайн хүнийг сүрдүүлж гэмт хэрэг үйлдсэн бол бэлгийн мөлжлөг болоод цөөн жилийн ял шийтгэхээр байгаа гэсэн үг юм. Бидний зүгээс 31.1 байна гээд явуулахаар 13.1 биш бэлгийн мөлжлөг байна гээд алх цохидог.*

*Нэр томьёо ойлголтын зөрүүг гаргах. Жишээ нь албадаг хөдөлмөр, боолчлолыг олон улсын хэмжээнд хэрхэн хардаг юм. Эдгээр нь яавал хүн худалдаалах болох юм, түүнчлэн оноох ял нь адил байх юм уу, өөр байх юм уу гэдгийн маш тодорхой болгох хэрэгтэй. Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас*

Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх арга улам нарийсаж байгаа тул ажиллах чиг үүрэг бүхий албан хаагчдыг үргэлж сургаж, чадваржуулах, тэдний тогтвортой ажиллуулахад анхаарах хэрэгтэй байна. Мөн албан хаагч, мөрдөгчдийн илрүүлсэн тооноос хэргийн тоо шууд хамаарах тул ажилтан, албан хаагчийн тоон дээр анхаарах хэрэгтэйг холбогдох байгууллагын төлөөллүүд илэрхийлсэн.

Хөтөлбөрийн хугацаанд нийт 5 удаа гадагшаа сургалтад хамрагдсан. Гэхдээ одоо тэр албан хаагчид байхгүй. Манайд хамгийн удаан ажиллаж байгаа албан хаагч 2019 онд орж ирсэн хүн л байна. Бусад албан хаагчдын ажлын байр өөрчлөгдсөн. Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах хэрэгцээ шаардлага байгаа ч албан хаагчдын хүчлэх боломжгүй болохоор хэцүү байдаг. Ажлын ачаалал ихтэй, ар гэртээ цаг зарцуулж чаддаггүй болохоор гэр бүлийн асуудал их гардаг. Бид нарт амралтын өдөр гэж байдаггүй. Хөтөлбөрийн хүрээнд мөн орон тоо нэмэгдсэн. Өмнө нь нэг, хоёр хүнтэй байсан. Одоо бол 5 албан хаагчтай болсон. Бодлогын бичиг баримтаа харах юм бол маш өргөн хүрээнд ажиллахаар байдаг ч хүний нөөцийн бололцоо маш хангалтгүй байна.

Гэмт этгээдүүд нарийн зохион байгуулалтад орчихсон, цахим орчны ашиглаж илүү нарын зохион байгуулагдаж байгаа болохоор тэдэнтэй ажилладаг мэргэжлийн албан хаагчийг бэлдэх хэрэгцээ байгаа гэсэн үг. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх тасаг гэж байдаг ч тэдний чиг үүрэг нь өөр байдаг болохоор ийшээ ороод байдаггүй. Цахимаар үйлдэгдэж байгаа хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллах хүмүүсийг чадавхжуулах хэрэгтэй

Чанарын судалгаанд оролцогчийн ярианаас

Энэ төрлийн гэмт хэргийн хэрэг шийдвэрлэх үйл ажиллагаа нь урт хугацаанд үргэлжилдэг. Тиймээс энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хэргийг шалгах явцад шантрах, гомдлоо буцаах, олон удаа мэдүүлэг өгснөөс болж сэтгэл зүйн үйлчилгээ үр дүнгүй болох, сэтгэл зүйн гэмтэл сэдрэх гэх мэт асуудал үүсдэг байна. Иймд холбогдох байгууллагууд хохирогчийн сэтгэл зүй, нийгмийн байдлыг сайтар харгалзан анхаарч ажиллах шаардлагатай байна.

Шигтгээ 20. Судалгаанд оролцогчдын сэтгэгдэл

Бодит байдал дээр сайн өмгөөлөгчтэй тал нь ялдаг тул хохирогчийг мэргэшсэн өмгөөлөгчөөр хамгаалуулах хэрэгтэй. Дийлэнх тохиолдолд хохирогчийн эн тэргүүний асуудал нь мөнгөний асуудал байдаг тул мөнгөөр тохиролцох, шүүхээр асуудлаа шийдвэрлүүлж байх үедээ шантрах тохиолдол гардаг үүнээс шалтгаалж энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт болоод шийдвэрлэлт буурах эрсдэлтэй байдаг.

Хохирогчтой илүү сайн тулж ажиллах хэрэгтэй. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид дахин дахин яриа өгөх болон гомдлоо буцаах асуудал байдаг юм шиг байна лээ, үүнээс болоод гэмт этгээд ялаас мултрах ял завших асуудал гардаг байж магадгүй. Тиймээс хохирогчтой маш сайн ажиллах хэрэгтэй.

Чанарын судалгаанд оролцогчийн ярианаас

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод хамгаалах байрны хэрэгцээ шаардлага хамгийн их байдаг байна. Учир нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдыг бусад төрлийн гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчидтой нэг газар байрлуулж мэдүүлэг авах, хамгаалалтад байлгах нь олон эрсдэлийг бий болгодог байна. Жишээ нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч бусдыг уруу татах болон энэ төрлийн гэмт хэргийн хохирогч харьцангуй цөөн байх хандлагатай байдаг тул мэдээллийн нууц байдал алдагдах гэх мэт асуудал үүсэх өндөр эрсдэлтэй байдаг байна.



Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчоос мэдүүлэг байцаалт авахад зайлшгүй түр хамгаалах байранд хамгаалах шаардлагатай боловч бусад төрлийн гэмт хэргийн хохирогчтой хамт байлгах явдал нь хэрэг хянан шийдвэрлэх явц нь удаан хугацаанд үргэлжлэх нийгмийн үйлчилгээ авч чадахгүй, бусад хүүхдүүдэд нөлөөлөх гэх мэт эрсдэлүүд үүсдэг.

Хамгаалах байрын хүрэлцээ муу байдаг. Ихэвчлэн манайх “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-д өгдөг. 108-д өгдөг ч тэнд бүх хэргийн хохирогч хүүхдүүдийг нэг газар байрлуулдаг болохоор тухайн хүүхдүүдийн дунд том нь багыгаа асрах, шөнө унтаж чадахгүй байх, ядрах гэх мэт асуудал үүсдэг юм шиг байна лээ. Мөн эндээс очиж байгаа хүүхдүүд тэнд байгаа хүүхдүүдээс хүрээгээ тэлэх, эсвэл тэнд байгаа хүүхдүүд нь эндээс очиж байгаа хүүхдүүдийг ялгаварлан гадуурхах, дээрэлхэх биеэ үнэлэгч гэсэн байр сууринаас хандах гэх мэт хүний эрхийн зөрчлүүд үүсэх эрсдэл өндөр байдаг. ЦЕГ-т түр хамгаалах байр байгаа ч 108-тай адилхан байдаг. Тийм болохоор хүн худалдаалахын хохирогчийг хамгаалах, хэргээ шийдвэрлэхийн тулд өөр газрууд руу аваачихыг боддоггүй.

Чанарын судалгаанд оролцогчдын ярианаас

Гадаад улсуудтай хамтын ажиллагаагаа тэлэх хэрэгцээ байсаар байна. Монгол Улсын иргэд визгүй зорчих боломжтой улсуудад очиж хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байна.

Монгол Улс 10-аад улстай энэ төрлийн гэмт хэргээс сэргийлэх харилцан туслалцах гэрээ байгуулсан байдаг. Энэ гэрээг илүү өргөжүүлэх шаардлагатай. Жишээ нь Турк руу визгүй гардаг нь энгийн иргэдэд давуу тал мэт боловч гэмт хэрэгтнүүдэд мөн илүү давуу талыг бий болгодог. Турк Улсад амралтгүй, хүнд нөхцөлд олон цагаар бичиг баримтыг нь хурааж аваад цалингүй ажиллуулах гэх мэтээр хохирогч болоод ажиллахаа больё гээд больж чадахгүй эрхээ хязгаарлуулчхаад зугтаагаад ирсэн залуучууд байдаг ч Монголд ирээд хөдөлмөрийн мөлжлөгт өртчихлөө гээд цагдаад хандахаасаа илүү "нэгэнт болоод өнгөрсөн юм чинь" гээд хаях тохиолдол их байдаг.

Чанарын судалгаанд оролцогчийн ярианаас

Хамтран ажилладаг байгууллагуудын хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг хариуцаж ажилладаг ажилтнуудын ажлын ачаалал үйл ажиллагааг үндсэн чиг үүрэгтэй нь тохируулж ажиллах таатай орныг бүрдүүлэх хэрэгтэй байдаг байна. Учир нь байгууллагын үндсэн чиг үүрэг нь биш боловч энэ төрлийн гэмт хэрэг рүү орж ажиллах шаардлагатай байгууллагуудын ажилтан албан хаагчдад үндсэн ажил дээр нь ачаалал нэмдэг бөгөөд зарим үед байгууллагын удирдлага, шууд удирдлага буюу дээд албан тушаалтнууд ойлгохгүй байх хандлага гардаг тул үүнийг зохицуулах хэрэгцээ байна гэж зарим байгууллагын төлөөллүүд үзэж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын үйл ажиллагааг бизнесийн байгууллагаас ялган дэмжих буюу ажлын байр гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тодруулбал төрийн худалдан авах үйл ажиллагаанд оролцоход бизнесийн байгууллагатай адил шаардлага, санхүүгийн баталгаа тавихгүй байх, ямарваа үйл ажиллагааны санхүүжилтэд ажилтан албан хаагчдын цалинг тооцоолох зэрэг байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2019 онд хийгдсэн дунд шатны үнэлгээнээс 9.1 нэгж хувиар өсжээ. Хөтөлбөрийн хүрээнд нийт 4 зорилтын 26 үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Нэгдүгээр зорилт “Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах” 95.1 хувийн биелэлттэй. Тус зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудаас 5 дугаар үйл ажиллагааны 4 дүгээр дэд үйл ажиллагаа “Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулах” хамгийн доогуур үнэлгээтэй байна. Хувийн хэвшлийн байгууллагуудад сургалт орох, хяналт шалгалт хийх тодорхой ажлуудыг гүйцэтгэсэн боловч хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх магадлал хамгийн өндөр салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагууд цагдаагийн байгууллагаас авдаг байсан үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахыг зогсоожээ. Тиймд энэ төрлийн гэмт хэргийн зохион байгуулах магадлалтай байгууллагуудыг хянах механизм суларсан байна.

Хоёрдугаар зорилт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх” 94.6 хувийн биелэлттэй байна. Энэхүү зорилтын хүрээнд хэрэгжсэн үйл ажиллагаанаас эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа байхгүй бөгөөд цаашид хохирогчийн сэтгэл зүйн гэмтлийг зэргийг тогтоож, эмчилгээ, нөхөн сэтгээх хариу арга хэмжээг сайжруулахад анхаарах хэрэгцээ байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг төрийн бус байгууллагатай хамтран хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Хохирогч хамгаалах байрны хүрэлцээний асуудалд байгууллага бүрийн төлөөлөл ялгаатай байр суурьтай байна. Тодруулбал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шууд үйлчилгээ үзүүлдэг байгууллагын төлөөллүүд хохирогч хамгаалах байр хүрэлцээ хангалтгүй бөгөөд стандартын шаардлага хангадаггүй хэмээн үзэж байгаа бол бусад төрлийн хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөллүүд Монгол Улсын хэмжээнд байгаа нийт хохирогч хамгаалах байр хангалттай байгаатай холбон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалах байрыг хангалттай гэж үзэж байна.

Гуравдугаар зорилт “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах” 84.75 хувийн биелэлттэй байна. Гуравдугаар зорилтын хүрээнд хэрэгжсэн үйл ажиллагаануудаас эрчимжүүлэх шаардлагатай 2 үйл ажиллагаа байна. Үүнд: 1). Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг бусад байгууллагатай мэдээллийн нэгдсэн сүлжээгээр холбож мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх шаардлагатай техник хэрэгсэл, боловсон хүчнээр хангах 3 дугаар үйл ажиллагаа болон 2). Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх төвийг байгуулах 7 дугаар үйл ажиллагаа. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага хооронд мэдээлэл солилцох нэгдсэн систем бий болоогүй бөгөөд нэг байгууллагаас нөгөөд шилжсэн гэмт хэрэг болон бусад мэдээлэл хэрхэн шийдвэрлэгдсэн тухай байгууллага хоорондын мэдээлэл солилцох нь муу байна. 7 дугаар үйл ажиллагааны хүрээнд мэдээлэл өгөх төв шинээр байгуулагдаагүй бөгөөд Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ийн утсаар мэдээлэл авах, өгөх үйл

ажиллагааг зохион байгуулж байна. Хүүхдийн тусламжийн 108 утасны хувьд зөвхөн мэдээлэл хүлээн авах, холбон зуучлах үйлчилгээг үзүүлж байна.

Дөрөвдүгээр зорилт “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх” 93.3 хувийн биелэлттэй байна. Энэхүү зорилтын хүрээнд 3 төрлийн үйл ажиллагаа авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 1 болон 2 дугаар үйл ажиллагааны биелэлт 100 хувь, 3 дугаар үйл ажиллагааны биелэлт 80 хувь байна. 3 дугаар үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын иргэд олноор зорчдог, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох магадлал бүхий улс орнуудтай тогтмол харилцаа холбоотой байж, хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Гэвч дэлхий ертөнц хувьсан өөрчлөгдөхийн хэрээр улс орон хоорондын хамтын ажиллагаа, иргэдийн зорчих чиглэл өөрчлөгдөж байгаатай уялдуулах хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгцээ байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр гэмт хэрэг илрүүлэх үйл ажиллагаа эрчимжиж, энэ төрлийн гэмт хэрэг хүрээгээ тэлж хохирогчийн тоо нэмэгдэхээс урьдчилан сэргийлж чадсан бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нэгдсэн нэг төлөвлөгөөтэй болж, түүнд холбогдох байгууллага бүрийг татан оруулж, улсын төсөв болон олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжиж байна.

Иймд цаашид оролцогч талуудын хамтын ажиллагааг хангасан, нэгдсэн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай.

Иргэд энэ төрлийн гэмт хэргийн талаар тодорхой ойлголт мэдлэгтэй болж, хүний эрхийн зөрчлийг мэдээлэх үүргээ ухамсарладаг болсон нь эерэг үр дүнгүүдийн нэг болсныг онцолж тэмдэглэж байна. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд ажиллах хүчний чадвар, хүний нөөцийг нэмэгдүүлснээр гэмт хэргийн илрүүлэлт өсөхөд чухал нөлөө үзүүлжээ. Гэмт хэргийн илрүүлэлт өссөнөөр хохирогчдыг хамгаалах, нийгэм сэтгэл зүй, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж хэвийн амьдралдаа эргэн ороход нь тусалцаа үзүүлэхэд анхаарч ажиллаж байна. Гэвч цаашид гэмт хэргийг илрүүлэх, хохирогчид тусалцаа үзүүлэх чиглэлээр ажиллаж буй ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал, онцлог нөхцөл байдлыг нарийвчлан судалж, тэдний ажлын онцлогт тохирсон уян хатан нөхцөл бүхий дэмжлэг үзүүлэх хэрэгцээ шаардлага байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг ТББ-уудын үйл ажиллагаа сайн байгаа нь сайшаалтай үр дүн байлаа.

Цаашид иргэний нийгмийн оролцоог илүүтэй дэмжиж, тэдний үйл ажиллагааны онцлогт тохирсон бодлогын дэмжлэгийг үзүүлэх хэрэгтэй.

### Бодлогын түвшинд

1. Эрүүгийн тухай, Зөрчлийн тухай хуулийн хүн худалдаалах болон түүнтэй ижил төстэй гэмт хэргийн холбогдогч талд хариуцлага тооцох зүйл заалт бүрийг дахин нягталж, хуульд ямар нэг төөрөгдөл үүсэхгүй байхаар ойлгомжтой, ялгаатай байх нөхцөлийг бүрдүүлж гэмт хэргийн ял завших боломжийг бий болгохгүй байхад онцгой анхаарч бодитой арга хэмжээ авах;
2. Сэтгэл зүйн хохирлыг тогтоох, барагдуулах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
3. Хүн худалдаалах гэмт хэргийн зохион байгуулах магадлалтай салбарт үйл ажиллагаа явуулдаг ААНБ-уудын үйл ажиллагааг хянах, цагдаагийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авдаг тогтолцоог сэргээх: Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн албан хаагчдыг тоог нэмэх, бүтцийг өргөтгөх, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
4. Тендерийн шалгаруулалтад НҮТББ, иргэний нийгмийн шалгуур үзүүлэлтийн бизнесийн байгууллагаас ялгаатай болгож өөрчлөх. Олгож буй санхүүжилтийн зардалд иргэний нийгмийн ажилтан, албан хаагчдын цалинг тусгадаг байх;<sup>61</sup>

### Дэд зөвлөлийн цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5. Цаашид Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр тодорхой хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулах хэрэгжилтийг ханган ажиллах. Хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахдаа хүн худалдаалахтай тухайн үйл ажиллагааг хариуцах эзэн, байгууллагын тодорхойлж, үйл ажиллагааны үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой боловсруулах;
6. Байгууллага бүрийн чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, арга зүйг тодорхойлж дотоодын, хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийж, хэлэлцүүлдэг байх;
7. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагуудыг нэгдсэн мэдээллээр хангах цахим санг бий болгон статистикийн үзүүлэлтүүдийг холбогдох байгууллага бүрээр нарийвчлан гаргаж зөрүүтэй байдал үүсгэлгүй нэгтгэж, дүн шинжилгээ хийн цаашдын үйл ажиллагаандаа оновчтой ашиглах;
8. Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны үнэлгээнд кейс судалгааны арга зүйг ашиглах;
9. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр ажилладаг ажилтан, албан хаагчид, хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг хууль эрх зүйн болон холбогдох бусад мэдээ мэдээллээр хангах ажлыг тасралтгүй зохион байгуулж хэвших;
10. Аймаг, дүүрэг, сум хорооны хүүхэд хамгааллын хамтарсан баг, нийгмийн ажилтан, баг, хорооны дарга, төлөөлөгчдийг өөрийн орон нутгийн иргэд, өрхийн эмзэг байдлын судалгааг тогтмол хийж аливаа төрлийн гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогч болохоос

<sup>61</sup> НҮТББ-ын зүгээс аливаа тендер оролцохдоо бизнесийн байгууллагатай ижил шалгуураар оролцдог. Үүнд тендерийн баталгаа, орлогын хэмжээ зэрэг санхүүгийн өндөр шаардлага тавьдаг нь иргэний нийгмийн байгууллагуудын хувьд тендерийн шалгуурын биелүүлэхэд хүндрэлтэй байдаг бөгөөд бага үнийн дүнтэй санхүүжилт олгож аливаа ажил хийлгэхэд санхүүгийн зардалд ажилтан, албан хаагчдын цалинг тусгадаггүй тухай иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүд дурджээ.

хамгаалж ажиллахад холбогдох байгууллагуудын зүгээс бодлого, арга зүйн дэмжлэг тусалцаа үзүүлэх;

11. Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт бэлтгэж буй мэргэжлийн онцлогийг харгалзан оюутнуудын сургалтын хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэргийн талаар цогц мэдлэг олгох хичээлийг тусгах
12. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй албан хаагчдыг сурган дадлагажуулах мэргэшүүлэх, гадаадын туршлагыг судлуулах, сайн туршлагыг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангахад анхаарч ажиллах;
13. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрыг нэмэгдүүлэх энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг бусад төрлийн хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогчтой хамтад нь нэг газар байрлуулж үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
14. Иргэдийн гэмт хэрэг, хүчирхийлэл, хууль эрх зүйн, мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр нөлөөллийн ажлыг мэргэжлийн түвшинд, ямар нэг сэдэл өгөхгүй байхаар тогтмол зохион байгуулах. Энэ төрлийн сургалтыг зөвхөн мэргэшсэн хүн, тодорхой хөтөлбөрийн дагуу ордог байхаар зохицуулах;
15. Монгол Улсын иргэд олноор зорчиж буй болон Монгол Улсын иргэд гэмт хэргийн хохирогч болох магадлалтай улс орны судалгааг хийж, судалгааны үр дүнд үндэслэн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;

## ХАВСРАЛТ МАТЕРИАЛ 1 – ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО

№	Байгууллага	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцсон байдал
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, энэ чиглэлийн бодлого хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажиллах
2	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, ард иргэдэд нөлөөллийн ажлыг зохион байгуулах бусад төрлийн бодлого хөтөлбөрт энэ төрлийн гэмт хэргээс хамгаалах арга хэмжээг тусгах. Хүн худалдаадах гэмт хэргийн хохирогчийн хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, мэргэжилтнүүдийг бэлдэх, чадваржуулах
3	Гадаад харилцааны яам	Гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд тухайн улсад Монгол Улсын харьяат иргэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон иргэнийг хамгаалах арга хэмжээ авч ажиллах
4	ЦЕГ Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг голлон зохион байгуулах, хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэх, мөрдөн байцаах, хохирогч болон холбогдогч талуудыг хамгаалах
5	Гадаад иргэн, харьяатын газар	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон гадаад улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, ух оронд нь буцаах ажлыг хариуцан гүйцэтгэдэг
6	Хил хамгаалах ерөнхий газар	Хилээр нэвтэрч байгаа иргэдэд хяналт тавих, мэдээлэл түгээх энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх
7	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх хамгаалах, сургалт мэдээллийн ажил зохион байгуулах, оролцох. Гэмт хэрэг үйлдсэн, суллагдсан этгээдийг ажлын байранд зуучлах
8	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Хүн худалдаалах тэр дундаа хөдөлмөрийн мөлжлөгт өрсөн, өртөж болзошгүй иргэдийн илрүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг таслах зогсоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл түгээх
9	Улсын ерөнхий прокурорын газар	Хүн худалдаалах гэмт хэргийг мөрөөр хянах, хэргийн гэмт хэргийн шинжийг олж илрүүлэх, гэмт хэрэг үүсгэх, шүүхэд шилжүүлэх
10	Тагнуулын ерөнхий газар	Хүн худалдаалах гэмт хэргийг олж илрүүлэх, шалгах, мөрдөх
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн шүүхийн шийдвэрийг гүйцэлдүүлэх, тэднийг соён гэгээрүүлэх, мэргэжлийн сургалтад суулгах арга хэмжээг зохион байгуулах
12	Гаалийн ерөнхий газар	Хилээр нэвтэр буй иргэдэд хяналт тавих, сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, илэрсэн тохиолдолд холбогдох хууль сахиулах байгууллагад мэдээгдэх
13	Монголын хуульчдын холбоо	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль, зүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, хохирлыг нөхөн төлүүлэх

№	Байгууллага	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцсон байдал
14	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх, санхүүжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн талаарх судалгаа шинжилгээний ажил хийх, холбогдох албан хаагчид, мэргэжилтнүүдийг бэлдэх, чадваржуулах
15	Хүйсийн тэгш эрх төв ТББ	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хохирогчид нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, хэвийн амьдралдаа эргэн нэгдэх дахин гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх. Олон нийтийн дунд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх, санхүүжилд босгох, холбогдох албан хаагчид, мэргэжилтнүүдийг бэлдэх, чадваржуулах
16	АНБАУНД ТББ	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хохирогчийг илрүүлэх, холбон зуучлах сургалт хийх
17	ЭКПАТ МОНГОЛ ТББ	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох эрсдэлт бүлгийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх, хамгаалах
18	Эрүүл мэндийн яам	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэдэд бие махбодь, сэтгэл зүйн нөхөн сэргээх эрүүд мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх,
19	Соёлын яам	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах, иргэдийн соён гэгээрүүлэх, мэдлэг мэдээллээр хангах
20	Боловсрол, шинжлэх ухааны яам	Бүх шатны боловсролын байгууллагуудаар дамжуулан иргэдэд нас сэтгэл зүйн онцлогт тохирсон нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хичээлийн хөтөлбөрт энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах агуулгыг тусгах
21	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Иргэдийг гадаад улс руу жуучилдаг, гадаадаас Монгол Улс руу гадаад улсын иргэдийн жуучилдаг байгууллагуудад хяналт тавих, иргэдийн хохирогч болохоос хамгаалах. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг албан байгууллагуудад энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг түгээх, энэ төрлийн гэмт хэргийг зохион байгуулахаас хамгаалах
22	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	Уул уурхай, хүнд үйлдвэрлэл дагасан газар иргэдийн /насанд хүрээгүй/ хөдөлмөрийн болон бусад төрлийн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
23	Сангийн яам	Хүн худалдаалахаас хамгаалах үйл ажиллагаанд жил бүр улсын төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгө суулгах, хөрөнгийн зарцуулалтыг хянах.
24	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байх магадлал бүхий иргэнд шинжилгээ хийх, баталгаажуулах, хэрэг үнэн зөв шийдвэрлэгдэхэд туслалцаа үзүүлэх
25	Дотоод хэргийн их сургууль	Хүн худалдаалахтай холбоотой судалгаа шинжилгээний ажлыг хийх, оюутнуудад энэ төрлийн гэмт хэргийн талаар мэдээ мэдээлэл түгээх

Энэхүү судалгааны тайланг “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба”-ны захиалгаар “Эс Ай Си Эй” ХХК бэлтгэв. Тайланд тусгагдсан мэдээлэл нь захиалагчийн өмч тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хувиан олшруулахыг хориглоно.